



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-6</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>8-25</i>

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах	7-8
1. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	8-23
2. Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	23-74
3. Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	74-99

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 04-ний өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Н.Учрал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 65 гишүүн хүрэлцэн ирж, 51.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 40 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Баатархүү, М.Бадамсүрэн, Р.Батболд, Х.Баттулга, Б.Батцэцэг, П.Батчимэг, Ж.Баярмаа, Ж.Баясгалан, Х.Булгантуяа, Д.Бум-Очир, Ш.Бямбасүрэн, А.Ганбаатар, Д.Ганбат, Г.Дамдинням, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан, Б.Жаргалан, Б.Заяабал, Ч.Лодойсамбуу, С.Лүндэг, Ц.Мөнхбат, Л.Мөнхбаясгалан, П.Наранбаяр, Ч.Номин, Г.Очирбат, Л.Соронзонболд, Р.Сэддорж, А.Ундраа, Ч.Ундрэм, О.Цогтгэрэл, С.Цэнгүүн, Б.Энхбаяр, Д.Энхтуяа, С.Эрдэнэболд;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, О.Батнайрамдал, Х.Жангабыл, Н.Номтойбаяр, М.Нарантуяа-Нара, Д.Энхтүвшин;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Х.Болормаа, Л.Гантөмөр, М.Сарнай, Ц.Туваан, Б.Тулга;

Тасалсан: О.Амгаланбаатар, Л.Оюун-Эрдэнэ;

Хоцорсон: Н.Алтанхуяг-14 минут, С.Амарсайхан-2 цаг 20 минут, Б.Батбаатар-33 минут, Э.Болормаа-16 минут, Г.Ганбаатар-1 цаг 17 минут, Т.Доржханд-06 минут, П.Мөнхтулга-27 минут, З.Мэндсайхан-30 минут, Б.Пунсалмаа-02 минут, Г.Хосбаяр-2 цаг 32 минут, Р.Эрдэнэбүрэн-1 цаг 44 минут.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах

Улсын Их Хурлын дарга Н.Учрал Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын 10 гишүүнээс 2025.11.27-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын 41 гишүүнээс 2025.11.27-ны өдөр өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Захирамж хүчингүй болгох тухай” Улсын Их Хурлын даргын 482 дугаар захирамжийг танилцуулав./10:47/

Нэг.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, мөн яамны Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Б.Гарамханд, “Үндэсний давхар даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Жавхлант, мөн компанийн Эрсдэлийн удирдлагын ахлах ажилтан П.Шинэзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, О.Алтангэрэл, Д.Жаргалсайхан, Г.Тэмүүлэн, Н.Наранбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ц.Идэрбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, “Үндэсний давхар даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Жавхлант нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./11:40/

Хоёр.Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн П.Золзаяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Я.Жавхлан, мөн газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч Б.Мандалбаяр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Банкны төлбөр барагдуулах газрын дарга Б.Дашдаваа, Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын ДНХ-ийн лабораторийн эрхлэгч Б.Тэнүүн, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга К.Нямдаваа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын ахлах шинжээч М.Цогтбаатар, Олон улсын

Улаанбаатар Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал О.Амарсанаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Д.Нямбаяр, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар нар танилцуулав.

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 20 минут үргэлжилж, 13 цаг 00 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 20 минутад эхлэв.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 14 цаг 20 минутаас хуралдааныг даргалав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Х.Тэмүүжин, Н.Алтаншагай, М.Мандхай, Л.Энхнасан, П.Сайнзориг, Д.Ганмаа, А.Ариунзаяа, О.Номинчимэг, Ц.Сандаг-Очир, О.Саранчулуун, Х.Баасанжаргал, Ж.Бат-Эрдэнэ, С.Одонтуяа, Г.Ганбаатар, С.Амарсайхан нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын ДНХ-ийн лабораторийн эрхлэгч Б.Тэнүүн, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын ахлах шинжээч М.Цогтбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал 15 цаг 55 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, П.Сайнзориг нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./16:11/

Гурав.Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.11.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн П.Золзаяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн

нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Я.Жавхлан, мөн газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Мөнгөнтуул, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга К.Нямдаваа, Улсын ерөнхий прокурорын газрын Бодлого, төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах прокурор З.Сансарзолбоо, Олон улсын Улаанбаатар Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал О.Амарсанаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, А.Ариунзаяа, Д.Ганмаа, О.Номинчимэг, О.Саранчулуун, Х.Баасанжаргал, С.Одонтуяа нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн П.Золзаяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./17:40/

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 40 дүгээр сургуулийн 12^в ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын урилгаар Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын төрийн албан хаагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын урилгаар Төв аймгийн Зуунмод сумын Социал Демократ Монголын залуучуудын холбооны гишүүд, залуучууд, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн урилгаар Олон улсын стандартчилалын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Сержио Мужико тэргүүтэй төлөөлөгчид, мөн гишүүний урилгаар Техник, Технологийн Их сургууль, Барилгын политехникийн коллежийн багш, оюутнууд, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн урилгаар Хүүхэд, залууст эх оронч үзэл, эв нэгдлийг түгээн дэлгэрүүлэх зорилготой “Зэв” холбооны гишүүд, Улсын Их Хурлын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 151 дүгээр сургуулийн 10^а ангийн багш, сурагчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 73 дугаар сургуулийн 8^е ангийн багш, сурагчид, Зэвсэгт

хүчний 119 дүгээр ангийн хугацаат цэргийн албан хаагчдын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, Чуулганы хуралдааны хэлтсийн референт Б.Нарантуяа, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 40 минут үргэлжилж, 126 гишүүнээс 78 гишүүн хүрэлцэн ирж, 61.9 хувийн ирцтэйгээр 17 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 40 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Учрал: Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Төсвийн байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хуралдаж дуусаж байна. Гишүүдийн ирц бүрдлээ. 51,6 хувийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Төсвийн байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хуралдсан. Байгаль орчны байнгын хорооны хурал өндөрлөсөн. Төсвийн байнгын хороо хуралдаж байна. Үүнтэй холбогдуулж бас чуулганы хуралдаан хоцорч эхэллээ. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

1.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. /Засгийн газар 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, зарчмын зөрүүтэй 6 саналтай/.

2-т Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. /Засгийн газар 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

3-т Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. /2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Засгийн газар өргөн мэдүүлсэн/.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасан.

Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар та бүхэнд танилцуулъя.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Очирбатын Амгаланбаатар нарын 10 гишүүн 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Очирбатын Амгаланбаатар нарын 41 гишүүн 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газраас 11 дүгээр сарын 28-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсныг та бүхэнд танилцуулъя.

Зочид Их Хурлын чуулганы хуралдааны үйл ажиллагаатай танилцаж байна. 40 дүгээр сургуулийнх нь уу, Техник, технологийн их сургууль уу.

Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийн урилгаар Техник, технологийн их сургууль, Барилгын политехникийн коллежийн багш, оюутнууд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны үйл ажиллагаатай танилцаж байна. Та бүхэнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Улсын Их Хурлын гишүүн Золжаргалын урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 40 дүгээр сургуулийн 12^В ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагч нартаа сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсье.

Байнгын хороодод Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хуваарилсан талаар та бүхэнд танилцууллаа.

Мөн Монгол Улсын Их Хурлын даргын захирамж Дугаар 482

“Захирамж хүчингүй болсонд тооцох тухай”

Ажлын хэсгийн санал, дүгнэлт гарсан болон холбогдох хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулсантай холбогдуулан “Ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын даргын 2024 оны 80, 82, 86, 87, 89, 94, 95, 98, 104, 107, 110, 111, 113, 115, 173, 292, 254, 289, 321 дүгээр захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Ажлын хэсгийн үйл ажиллагааны хугацаа дууссан, үр дүн хангалтгүй байгаа. “Ажлын хэсэг байгуулах тухай” Их Хурлын даргын 2024 оны 73, 74, 75, 78, 97, 99, 100, 101, 102, 103, 106, 114, 116, 155, 156, 175, 290, 304, 329, 2025 оны 66, 68, 156, 158, 180, 185, 200, 210, 248, 255, 258, 264, 290, 303, 315, 362, 365, 438 дугаар дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Мөн Их Хурлын даргын 2024 оны 93, 96, 174 дүгээр захирамжтай холбогдуулан Засгийн газраас хуулийн төслүүдийг өргөн мэдүүлсэн тул хүчингүй болсонд тооцсугай гээд Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан 58 ажлын хэсгийг Их Хурлын даргын захирамжаар хүчингүй болгосныг та бүхэнд мэдэгдье. Тэгээд 7 ажлын хэсгийн хүрээнд цаашдаа ажиллах болно.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалд орёе. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна. Индэрт урья.

Ц.Идэрбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг тус Байнгын хорооны 2025 оны 6 тоот тогтоолоор байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, С.Ганбаатар, Р.Сэддорж, У.Отгонбаяр нарын гишүүд ажилласан болно.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Ажлын хэсгээс даатгагч гэрээний хугацаанд ус, цаг уур орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан урьдчилсан мэдээ, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан сумын малын хорогдлын дүнд үндэслэн нөхөн төлбөрийг 1 удаа урьдчилан олгож болох, даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийг хуваарилах зорилгоор сум бүрээр тогтоосон 1 дүгээр босго үзүүлэлтийг 5 хувь, 2 дугаар босго үзүүлэлтийг 30 хувь байхаар тогтоож Засгийн газар босго үзүүлэлтийг шинэчлэн тогтоохдоо 1 дүгээр босго үзүүлэлтийг 1 хувиар, 2 дугаар босго үзүүлэлтийг 5 хүртэл хувиар нэмэгдүүлж эсвэл бууруулж тогтоож болох, Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах зэрэг зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай

хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Цагаанхүүгийн Идэрбат гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Төмөр-Уяагийн Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Эрдэнэ-Очирын Мягмарханд Үндэсний статистикийн хорооны Эдийн засгийн статистикийн газрын Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн статистикийн хэлтсийн дарга, Батбаатарын Амарбаясгалан Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга. Хаана байна. Батсайханы Гарамханд Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн, Батмөнхийн Жавхлант “Үндэсний давхар даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирал, Пүрэвлхагвын Шинэзул “Үндэсний давхар даатгал” ХК-ийн эрсдэлийн удирдлагын ахлах ажилтан.

Ажлын хэсгийг та бүхэнд танилцууллаа. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Баасанжаргал гишүүнээр тасаллаа. Гишүүд асуулт асууж хариулт авна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Тэгэхээр улс орны хөгжил ямар улс орон илүү сайн хөгжилтэй байна вэ гэхээр төрдөө итгэлтэй байдаг тэр ард түмэнтэй улс орон л илүү сайн хөгжиж байгаа. Гэвч харамсалтай нь өнгөрсөн хугацаанд Монгол Ардын нам 9 жил төр барихдаа төрийг хэтэрхий данхайлгаж, энэ татвар төлөгчдийн мөнгийг хэд дахин дабльдаж төсөв нэмэгдүүлэх замаар энэ үргүй зарцуулах дарга нарын тансаглалд зарцуулах ийм зүйлүүдийг маш их хийсэн. Тийм учраас иргэдийн итгэл бол маш их буурч байгаа. Тэгээд энэ иргэдийн итгэлийг буцааж олж авахын тулд яадаг вэ гэхээр жишээ нь 1072 хувьцаагаар 300 мянган төгрөг хийж, яг сонгуулийн өмнө өгөх маягаар сонгуулийн саналыг худалдан авах ийм зүйлүүдийг хийдэг. Тэрний нэг жишээ нь бол Малчны тухай хуулийг 2024 оны 6 сарын 5-ны өдөр Тэмүүлэн нарын гишүүний өргөн барьснаар хууль батлагдсан. Энэ хууль батлагдсанаар малчны нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх тэр асуудлыг шийдвэрлэж, 2025 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж, 2026 оны 1 сарын 1 хүртэл үргэлжлэх ёстой. Гэвч энэ хугацаанд 3 сайд Нийгмийн хамгааллын сайд хийхдээ энэ асуудлыг огт оруулж ирээгүй. Энэ нь юуг харуулж байна вэ гэвэл малчдын саналыг 2024 оны 6 сарын 5-нд батлагдсан тэр хуулиараа 6 сарын 26-нд малчдын саналыг тэр нөхөн төлөх тэр заалтаараа авчхаад, тэгээд олонх болж авчинуутаа одоо та нарын хэрэггүй гээд ингээд хаяж байгаа байхгүй юу даа. Ийм луйврын ийм төрд яаж хүн итгэх юм бэ. Одоо 1 сарын хугацаа болж. Өнгөрсөн хугацаанд 2025 оны хавар ноолуурын үеэр малчид нэлээн мөнгөтэй болдог. Төлбөрөө төлмөөр байна. Нөхөн төлбөрөө төлж, тэтгэвэрт хамрагдмаар байна гээд зөндөө олон хүн хүссэн боловч тэр шийдвэр нь гараагүй. Одоо жоохон 11 сард мал махаа зараад бас жоохон мөнгөтэй болдог. Энэ үеэр бас та нарыг хүлээгээд бас байхгүй.

Тийм учраас энэ асуудлыг маш хурдан оруулж ирээч ээ. Аубакир сайд аа. Хөдөө, орон нутгаас сонгогддог ийм хүн. Тэр Баян-Өлгийд чинь маш их олон малчид

байж байгаа. Энх-Амгалан сайдад хэлээд бүр ядсан. Бүр эсрэг юм ярьдаг ийм нөхөд байгаа. Тэгээд Их Хурлын гишүүд энэ хуулийг хугацааг нь сунгах асуудлыг өргөн барих юм бол Засгийн газраас 1 сарын хугацаатай санал аваад ингээд явсаар байгаад бүр хавар луу очно. Тийм учраас амжихгүй. Тийм учраас Засгийн газрын гишүүн Засгийн газраасаа энэ саналыг ирэх 7 хоногийн хурлаар оруулаад, 1 жилээр сунгах ийм асуудлыг маш хурдтайгаар шийдвэрлэж өгөөч ээ. Тэгэхгүй бол та бүхэн хөдөө орон нутгаар явна. Энэ үеэр чинь малчид та бүхнээс энэ малчдын нийгмийн даатгалын шимтгэлээс нөхөн төлөх, энэ хуулийн хэрэгжилтийн талаар асууна. Та нарыг хуурсан тухай үг хэлнэ. Энэ чинь бол асар их төрд итгэх итгэлийг малчдын дунд байхгүй болгож байгаа ийм ая асар аюултай зүйл шүү гэдгийг бас хэлье.

Н.Учрал: Хэн хариулах вэ. Ажлын хэсгээс Жамбалцэрэн дарга. Өөр хэн байна. Бямбацогт сайд хариулах уу. Санал хэллээ гэж ойлголоо. Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууна. Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууна. Оюунсайханы Алтангэрэл гишүүн асуулт асууна.

О.Алтангэрэл: Энэ мал малчны асуудал яригдаж байх юм. Тэгээд Хөдөө аж ахуйн сайд нь хааччихсан юм. Малчны асуудал яриад байна шүү дээ. Би 1 тоо уншаад өгчихье. Дорноговь 20, Баянхонгор 21, Булган 22, Сүхбаатар 23, Хэнтий 26, Завхан 30. Ямар учиртай тоо хэлээд байна гэж бодож байж магадгүй Энэ шөнөдөө хасах градустай хонож байгаа аймгуудын градусын хэмжээ. Ингээд малчдын асуудал ярьж байхад сайд нь ч байхгүй. Уул уурхайн сайд нь ч байхгүй. Энэ түлээ түлш олдохгүй байна шүү дээ хөдөөгүүр. Энд сайхан юм яриад суугаад байдаг. Дизель түлш олдохгүй байна. Малчдын портер, бонгоны гол тэжээл, дизель түлш байхгүй байна. Өвс тэжээлээ татаж чадахгүй байна. Хоол хүнсээ татаж чадахгүй байна. Амралтын өдөр нь хүүхдүүдээ дотуур байрнаас нь аваад, гэртээ авчраад 2 хонуулчхаж чадахгүй байна. 92 ч гэсэн тасарчихлаа. Улаанбаатар хотод очер дугаар үүсээд эхэллээ. Сумд 1 литр 92-ын үнэ шагийн үнэд орчихсон, олдохгүй. Дээрээс нь 3300 төгрөгийн үнэтэй байна. Би сая тойргоор яваад ирлээ. 3500 хүрчихсэн юм байна тэгвэл. Үгүй ээ, ийм болчихоод байхад малчидтай холбоотой асуудлаар Малчны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хууль санаачлагчид нь буцаая гээд Байнгын хороо нь шийдчихсэн, мал, малчинтай холбоотой юм ярьж байхад сайд нь байхгүй байна шүү дээ. Бид нар юугаа хийж суух юм. Ямар сэтгэл нь өвддөггүй юм. Тэр хээр гадаа отроор явж байгаа, нимгэн нойтон гэртэй, түлээ түлшгүй малчид ядарч байна шүү дээ. Энэ Сүхбаатарын талбайд ирээд жагсахгүй болохоор нь, хөдөө орон нутгаас ирж чадахгүй болохоор нь ингэж дээрэлхэж боож байгаа юм уу. Малчин болохоор нь дээрэлхэж байгаа юм уу. Энэ амьдрал нь хүнд байна шүү дээ. Тэгээд яг асуудлыг нь ярих болохоор байхгүй. Дийлэнх нь байхгүй. Монгол Улс чинь тэр уул уурхайн сайдын хэлснээр 2 Уул уурхайн яамтай болсон гээ биз дээ. Энэ түлээ түлш яачихсан юм. Бензин нь яачихсан юм. Одоо тэгээд сав гээд нэг юм яриад байгаа юм. Тэгээд Тувааны үед савтай байсан юм уу. Байхгүй л байсан шүү дээ. Бусад сайдын үед энэ асуудлууд нь байгаагүй юм уу. Дайн гээд юм ярьж байна лээ. 4 жил болж байна шүү дээ наад дайн чинь. Тэгээд хэрвээ малчдаа ингээд түлш бензинээр таслах гэж байгаа бол эртхэн хэл. Ердийн хөсөгтөө бэлдье. Тэр тэрэгний шар жингийн тэмээг чинь урдаас сургаж бэлддэг юм. Тэр машин тэргээ больё. Эртхэн энийгээ хэлмээр байна. Энэ асуудлыг тоож байгаа ч хүн алга, ярьж байгаа ч хүн алга. Нэг л их сайхан хүмүүс яваад байх юм. Үгүй ээ, малчны хуультай холбоотой, Малын индексжүүлсэн даатгалын хуультай холбоотой юм өнөөдөр ярья гэхээр энэ хариуцсан хүмүүс нь байхгүй байна. Тийм учраас энэ хуулийн төсөлтэй холбоотой асуулт алга. Санал хэллээ.

Н.Учрал: Алтангэрэл гишүүн санал хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбатын урилгаар Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын төрийн албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхний ажилд өндөр амжилтыг хүсье. Амьдралд нь сайн сайхныг хүсье. Баярлалаа. Жаргалсайхан гишүүн байхгүй байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Малын индексжүүлсэн даатгалын тухай энэ хуулийн төслийг анх хавар өргөн барихад нь би бас байр сууриа илэрхийлж байсан. Засагдаад ороод ирэх болов уу гэсэн бас орж ирсэнгүй. Тэр дундаа манай тойргийн гишүүд энэ хуулийн төсөлдөө анхаараад, үг, үсгээ нэмээд, энийгээ сайжруулах болов уу гэсэн ерөөсөө тийм санал гараагүй байна. Сөрөг хүчнийхэн бас энэ хууль дээр ажилласангүй. Бүгдээрээ л хийх ёстой ажлаа цаг тухайд нь тухай бүрд нь хийх ёстой. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийг дагаж өргөн мэдүүлж байгаа энэ Малчны тухай хуульд орж байгаа заалт байгаа. Бүгд заавал малын индексжүүлсэн даатгалд даатгуулах болж байгаа. Ямар ийм хэрэгцээ, шаардлага байгаа юм бэ. Зайлшгүй ингэж бүгдийг нь ахиж даатгалд даатгуулах тийм үндэслэл шалтгаан байгаа юм уу гэдэг 1 асуулт байна.

2 дугаарт даатгалд даатгуулаад яг үндсэндээ айл өрхүүд хохирлоо барагдуулж авдаг уу гэвэл үгүй. Та нар бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ. Тойргийн гишүүд бүгдээрээ л орон нутагт очоод л ажиллаад л энэ зовлонг сонсдог шүү дээ. Бүгдээрээ нэг ийм хувь тэнцүүлэх маягтай. Тухайн сумд, тухайн аймагт өртсөн нийт хохирлоор нь тэнцүүлэх замаар л энэ даатгал өөрөө явдаг. Алийн болгон ийм байдалтай, нүглийн нүдийг гурилаар хуурсан маягтай ийм даатгалын систем үйлчлэх юм. Хэрвээ ашиггүй байдаг бол энийг заавал байлгах хэрэг байгаа юм уу. Ашигтай байдаг юм бол тухайн айл өрхөд холбогдох даатгалын нөхөн төлбөрийг нь олгох хэрэгтэй шүү дээ. Яагаад ерөөсөө ингээд олгохгүй өдий хүртэл ингээд яваад, энэ олон жил энэ даатгал ингээд амьд байгаад байдаг юм бэ гэдгийг асуумаар байна. Хавар би бас асууж байсан. Отроор явах, зуд турхан нүүрлэх, тэгээд тодорхой хэмжээний айл өрх баг, тодорхой хэмжээний уулын ам ч гэдэг юм уу ингээд цаг агаарын нөхцөл байдлаас болоод харилцан адилгүй заавал тухайн сум бүхлээрээ зудад өртсөн байхгүй байх ийм нөхцөлүүд зөндөө л болсон шүү дээ. Өнгөрсөн хугацаанд та бүхэн зөндөө судалгаа хийсэн байх. Тэгээд энийг хэзээ өөрчлөх юм. Хэзээ яг даатгуулсан айл өөрийнхөө нөхөн төлбөрийг яг бодитой авдаг болох юм. Энэ дээр яг нэг хариулт хэлээдхээч. Тооцоо судалгаа байна уу. Эсвэл хураамж нь нэмэгдсэн үед авах юм уу. Яг тэн дээр яг тодорхой тоо хэлээдэх гэсэн ийм байр суурьтай.

Н.Учрал: Жамбалцэрэн дарга наад хуулиа нэг тайлбарлаадхаач. Тэр босгыг яаж бууруулж байгаа юм. Харин тийм. Буурч байгаа гэж тайлбарлаад байгаа байхгүй юу. Ажлын хэсэг хариул даа. Идэрбат гишүүн хариулъя. Ажлын хэсгийн ахлагч.

Ц.Идэрбат: Гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд Засгийн газраас өргөн барьсан энэ нэмэлт, өөрчлөлтийн ажлын хэсгийг бас ахалж ажиллалаа. Тэгээд энэ хугацаанд Засгийн газар ч бас нэлээдгүй судалгаа хийсэн юм байна малчдын дунд. Ажлын хэсгийн гишүүд ч гэсэн өнгөрсөн намрын чуулганы завсарлагаагаар өөрсдийн тойрог, малчидтай баг дээр очиж уулзах уулзалтуудыг зохион байгуулсан. Мэдээж Засгийн газрын өргөн

барьсан хуулийн төсөл болон малчдын тавьж байгаа хүсэлт, шаардлагын хувьд бол зарчмын зөрүүтэй саналууд бол бас мэдээж байгаа. Энэ хуулийг илүү цааш нь сайжруулах шаардлага байгаа юу гэвэл байгаа. Баасанжаргал гишүүнтэй санал нэг байгаа.

Гэхдээ саяын хэлдэг малчдыг нөгөө албан журмын даатгал шиг хэмжээнд аваачиж байна гэдэг бол бас буруу ойлголт. Засгийн газраас бол төрөөс ямар нэгэн хөнгөлөлттэй зээл, тусламж авч л байгаа бол энэ малын индексжүүлсэн даатгалын даатгалд заавал даатгах ёстой гэсэн ийм зүйл, заалтыг оруулж ирсэн. Ажлын хэсгийн хувьд бол заавал ийм албан журмын даатгал шиг тийм хэмжээнд бол аваачиж болохгүй. Өнөөдөр малчид руу хандсан маш их хөтөлбөр, маш их хөнгөлөлттэй зээлүүд явж байгаа. Энэ тохиолдолд хэрвээ ингээд баталчих юм бол яг нөгөө албан журам гэдэг юм руугаа орчих гээд байна гэж. Тийм учраас хууль санаачлагчид нь энэ малчин заавал даатгуулах ёстой буюу хөнгөлөлттэй зээл, тусламж, үйлчилгээ авахын тулд малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан бай ёстой гэдэг энэ саналыг нь бол бид Засгийн газарт эргүүлээд буцааж байгаа гэж ойлгож болно. Тэгэхээр малчид бол хуучин өөрийнхөө хүслээр даатгадаг тэр зарчим руугаа бол явна. Хэвээрээ гэж ойлгож болно.

Яах вэ, ашиг тусын хувьд бол ер нь дэлхийд байхгүй ганц л тогтолцоо. Энэ малын индексжүүлсэн даатгал Монголд байдаг юм байна лээ. Африкт Кени улсад байдаг гэж байгаа. Тэр нь бол тэгэхдээ нөгөө газрын гарц, одоо монголчилж ярих юм бол зуншлагатай холбоотой, газрын гарцтай холбоотой зохицуулалтуудыг хийдэг юм байна лээ. Тэгэхээр манай энэ бэлчээрийн мал аж ахуй дэлхийд ганц байдаг энэ аж ахуйд зохицуулагдсан даатгалын үйлчилгээ дэлхийд байхгүй. Гэхдээ Монголд 2006 оноос хойш Дэлхийн банкны санхүүжилтээр төсөл хэрэгжиж байгаад, 2014 онд бие даасан хууль болж гарсан. Өнөөдөр бид ингээд нэмэлт, өөрчлөлт хийх гэж байгаа. Энэ хугацаанд бас жишээ нь хамгийн сүүлийн жишээ гэхэд 2023 оны өвөл, 2024 оны хавар Монгол Улсын мал аж ахуйн салбарт 1,6 их наяд төгрөгийн хохирол учирсан. Үүнээс бол малын индексжүүлсэн даатгалаас 22 мянган малчин өрхөд бол 16,8 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөрийг олгосон байх жишээтэй. Тэгэхээр энэ бол бас яг ор тас ямар нэгэн ашиг тусгүй гэдэг юм уу, тийм байдлаар бас шууд харж болохгүй байх. Гэхдээ цаг дуусаж байх шиг байна.../минут дуусав/

Н.Учрал: Баасанжаргал гишүүн тодруулна.

Х.Баасанжаргал: Миний асуулт маш тодорхой асуулт байгаа. Ажлын хэсэг эсвэл хариулах у, яах уу. Яг тоо хэлээч. Хэзээ яг бодитой хохирлоо авдаг болох систем рүү энэ даатгал шилжих вэ. Одоо ингээд дандаа хувь тэнцүүлэх маягтай л явж байгаа шүү дээ. Энэ систем өөрчлөгдөх үү. Эсвэл огт өөрчлөгдөх боломжгүй юм уу. Хураамж нэмэгдэж байж энэ систем өөрчлөгдөх юм уу. Хураамж нэмэгдэх бол хэд болж нэмэгдэж байж энэ нь өөрөө яг бодит хохирлоо авдаг энэ систем рүү шилжих юм. Одоо бид нар бүгдээрээ автомашины даатгал гээд л яг ийм л систем бий болох гэж байна гэж уг нь бол хараад байдаг. Гэтэл ерөөсөө ийм систем бол үүсээгүй байна. Тэгэхээр малчдын хувьд бол энэ өөрөө нэмэлт зардал болж гараад байна. 2014 оноос хойш энэ хууль батлагдсан гээд байдаг. Ерөөсөө үүнээс хойш малчдын даатгалд даатгуулах итгэл, үнэмшил нэмэгдэхгүй байгаа. Үүний шалтгааныг та нар юу гэж харж байгаа вэ. Тэгээд түрүүн асуусан отрыг бас хариулаад өгөөч. Оторт явж байгаа малчдын даатгалын асуудал яах вэ.

Н.Учрал: Идэрбат гишүүн хариулна.

Ц.Идэрбат: Баасанжаргал гишүүний 2 асуулт хоорондоо зөрчилдөөд байна л даа. Хэрвээ автомашины даатгал шиг тийм хэмжээнд очих гэж байгаа бол жолоочийн албан хариуцлагын даатгал гэж албан журмын даатгал шиг тийм хэмжээнд очиж байж тэр даатгалтай зүйрлэж ярих байх. Өнөөдөр бол энэ чинь сайн дурын үндсэн дээр малчин өөрийнхөө малыг тодорхой хэмжээнд өөрөө үнэлээд даатгаж байгаа. Тэгэхээр би түрүүнд хэлсэн. Дэлхийд бол яг энийг ингээд дуурайчих жишиг бол бидэнд байхгүй юм байна. Гэхдээ яг саяын Баасанжаргал гишүүний хэлж байгаа шиг ийм даатгал 1968 онд нэгдэл гэж байх үед бол хийсэн юм билээ. Тухайн үед нэгдлийн малыг даатгуулаад, яг хотонд хорогдсон хэмжээгээр нь өгөхөд дээд тал нь 40 хувь нь л даатгалд хамрагдаж байсан. Тэгээд энэ тогтолцоо бол цаашдаа явахгүй юм байна гээд 1980-аад онд бол энэ нь зогссон ийм түүх бас байдаг юм билээ. Гэхдээ энэ малын индексжүүлсэн даатгал гэж мал аж ахуйд үүсээд байгаа ... 1 минутаа авчих уу. /минут дуусав/

Н.Учрал: Идэрбат гишүүнд нэмэлт 1 минут.

Ц.Идэрбат: Мал аж ахуйд ганцхан зуд гэдэг ийм хохирол үүсгэдэггүй. Гамшиг болдоггүй. Энэ үер, малын гоц халдварт өвчин, тэгээд л аянга цахилгаан гээд олон зүйлүүд малчид маш их эрсдэл дунд энэ мал аж ахуйг өнөөдөр маллаад явж байгаа. Энэ Мал аж ахуйн салбарыг бид өшөө цогц даатгалын хэмжээнд аваачих ийм зайлшгүй шаардлага бол урган гарсан гэж би бол ингэж харж байгаа. Малчидтай уулзахад ч энийг ярьдаг. Тэгэхээр нэр бүхий гишүүдээс бол Малын индексжүүлсэн даатгалын хууль дээр энэ даатгалын системийг илүү боловсронгуй болгох тал дээр бас хуулийн төслийг өргөн барих бэлтгэлээ хангаад, Засгийн газарт өргөн барьсан. Харамсалтай нь Засгийн газар дэмжих боломжгүй ийм санал ирүүлсэн. Гэхдээ энийг илүү цааш нь засаад саяын хэлдэг энэ байгалийн давагдашгүй хүчин зүйл болон малын эрүүл мэндтэй холбоотой олон зүйлүүдийг бас цогцоор нь авч үзэх ийм хуулийн төсөл бол зайлшгүй хийх ёстой юм байна гэсэн ийм л дүгнэлтэд ажлын хэсэг бас .../минут дуусав/

Н.Учрал: Ажлын хэсгээс нэмж хариулъя. Жавхлант захирал 4 дүгээр микрофон

Б.Жавхлант: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирал Жавхлант. Баасанжаргал гишүүний асууж байгаа асуулт бол яг бид нарын мэргэжлийн хэллэгээр уламжлалт мал аж ахуйн даатгал гэж хэлдэг. Идэрбат гишүүний хэлсэнчлэн уламжлалт мал аж ахуйн даатгалыг Монгол Улс 1968 оноос хойш хэрэгжүүлээд, 1990 онд үндсэндээ зогссон. Өөрөөр хэлбэл уламжлалт мал аж ахуйн даатгалын бүтээгдэхүүн бол эдийн засгийн хувьд, үр ашгийн хувьд оршин тогтнох боломжгүй болоод 1990 оноос хойш энэ даатгалын бүтээгдэхүүн огт яваагүй юм. 2005 он хүртэл хугацаанд мал аж ахуйн салбарт ямар нэгэн даатгалын тогтолцоо байхгүй явж байгаад, 2005 оноос Монгол Улсын мал аж ахуйн салбарт даатгалын тогтолцоог бий болгох шаардлагатай гэж үзэж, Дэлхийн банктэй хамтарсан төсөл хэрэгжүүлсэн. Энэ дээр Дэлхийн банкны мэргэжилтнүүд болон Монгол Улсын эрдэмтэн, судлаачдын хамтарсан бүрэлдэхүүнээр индексэд суурилсан даатгалын бүтээгдэхүүн Монгол улсад тохиромжтой..../минут дуусав/

Н.Учрал: Жавхлант аа, чи гол асуултдаа хариул. Элсэлтийн шалгалтад хүүхэд конкурс өгөөд билет сугалаад ярьж байгаа юм шиг юм ярих юм. Яая гээд байгаа юм бэ гээд асуугаад байна шүү дээ. Үүх түүх, тэдэн он, наадах чинь хэнд хэрэгтэй юм. Жавхлант захирал.

Б.Жавхлант: Тэгэхээр уламжлалт мал аж ахуйн даатгалын тогтолцоог эргүүлэн сэргээхэд хувийн хэвшлийн салбар бол дэмжлэг үзүүлэхгүй байгаа. Тийм учраас уламжлалт мал аж ахуйн салбарын чиглэлээр дахиад шинжилгээ, судалгаа хийх ийм зайлшгүй шаардлага байгаа. Хувийн хэвшил бол дэмжиж орох боломжгүй. Индексэд суурилсан даатгалын тогтолцоог бол хувийн хэвшил дэмжээд ажиллах боломжтой ийм тогтолцоо байгаа.

Н.Учрал: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууна.

Г.Тэмүүлэн: Малын индексжүүлсэн даатгалтай холбогдуулаад хэд хэдэн асуудлыг бас бид нар ярихгүй бол болохгүй байна. Мал аж ахуйн салбар өөрөө Монгол Улсын эдийн засгийн гол өөрөө тулгуур салбар байгаа. Тэгээд цаашид ч юу гэдэг юм эдийн засгийг илүү төрөлжүүлэх дээр бид нарын уламжлалт бас гол үндсэн эдийн засгийн суурь бааз маань өөрөө хөдөө аж ахуйн салбар байсан. Мал аж ахуйн салбар байсан. Тэгээд энэ салбарыг жоохон эдийн засагжуулах, эргээд юу гэдэг юм энэ салбарын гол хүч нь болсон малчдаа эдийн засгийнх нь гол үндсэн бааз нь болсон мал аж ахуйн салбараа бид нар бас хамгаалах, дэмжих асуудлаар Малчны тухай хууль гээд санаачлаад, 2 жилийн өмнө Улсын Их Хурлаар орж батлуулаад, өнгөрсөн жилээс энэ жилээс хэрэгжээд эхлээд явж байгаа. Гэтэл Хөдөө аж ахуйн яам газар тариалангийнхаа бүс нутаг руугаа нүүгээд, газар тариалантайгаа ойртоод, мал аж ахуйгаасаа холдсон. Энэ яам маань мал аж ахуйн салбараа хаясан. Малчин, мал 2-оо хэзээ анхаарч эхлэх юм бэ.

Магадгүй энэ яамных нь хамт олон, яамных нь ажил хариуцсан сайд нар нь байгаа бол энэ хуулийг хэзээ хэрэгжүүлж эхлэх юм бэ. Хууль батлагдсанаас хойш хууль хэрэгжүүлдэггүй, хариуцлагагүйн зуд нүүрлээд байна. Уг нь гол үндсэн асуудал маань мал аж ахуйн салбарт дэмжих төрийн бодлоготой болгоод авъя. Энэ салбарыг авч явж байгаа малчдынхаа эрх ашгийг нь хамгаалах хуультай болгоё гэдэг асуудлыг гаргаж ирж, анх удаагаа 200, 300 мянган малчид маань хуультай болсон. Энэ хууль дээр бид нар малчдын боловсролыг нь дээшлүүлэхээс авхуулаад, мэдлэг, чадвар олгох, чадавхжуулах, мэргэшүүлэх энэ үндэсний хөтөлбөрийг хүртэл гаргах асуудлуудыг гаргаж ирж тавьсан. Эрүүл мэнд, нийгмийнх нь баталгааг хангах суурь зохицуулалтуудыг хууль дээр нь хүртэл оруулж өгсөн. Эргээд тодорхой хэмжээний төрөөс энэ малчин хүнийхээ эрүүл мэндийг нь хамгаалдаг тодорхой бүтэц тогтолцоог нь хийж өгч, нийгмийнх нь даатгалынх нь баталгааг хангах хууль, эрх зүйн орчныг нь тавьж, хуулийг нь хугацаагаар нь зааж өгсөн асуудлууд байгаад байгаа. Эдийн засгийн баталгааг нь хангах үүднээс амьжиргаа, орлогыг нь дэмжих, тодорхой энэ бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх, тодорхой хөнгөлөлттэй зээл, дэмжлэг, туслалцаанд хамаарагдах энэ зохицуулалтууд бас хийж өгсөн байгаад байгаа. Эрсдэлээс хамгаалах бодлогууд нь бас хийгдэж өгсөн байгаад байгаа. Өнөөдөр орж ирж байгаа малыг нь эрсдэлээс хамгаалах асуудал бол 1 л асуудал байгаа. Гэтэл түүнийг хариулж яваа малчныг нь эрсдэлээс хамгаалах асуудал яасан бэ. Эрүүл мэнд, нийгмийн баталгааны асуудлууд яасан бэ. Хуультай болоод хууль хэрэгждэггүй хариуцлагагүйн зудын асуудлыг яах ёстой юм бэ. Би ажлын хэсгийн даргаас бол асуухгүй. Энэ асуудал хариуцсан яамнаас нь хүмүүс байна уу. Сайд нь байна уу.

Хөдөө аж ахуйн яамаа тариалангийнхаа бүс рүү нүүж аваачаад газар тариалантайгаа ойртсон байж магадгүй. Одоо тэгээд малчдаа мал аж ахуйн салбар луугаа хэзээ ойртох юм бэ. Мартагдсан тэр малчин болоод мал хоёроо хэзээ анхаарч эхлэх юм бэ энэ яам. Хэрэгжүүлдэггүй хуулийнхаа заалтуудыг хэзээ хэрэгжүүлэх юм. Улсын Их Хурал бол хууль тогтоох төрийн эрх барих дээд байгууллага хуулийг нь баталж өгдөг. Хуулийг хэрэгжүүлэх үүрэг Засгийн газар, гүйцэтгэх засаглал дээр байгаа. Энэ асуудал дээр жоохон хариуцлагатай хаа хаанаа хандмаар байна. Хөдөө аж ахуйн яам энэ асуудлыг хариуцсан. Уг нь бол хуулийг нь санаачилж байсан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нь ч гэсэн энэ дээр бас нэг жоохон манлайлалтай, хүний эрх гэсэн сэтгэлээр бас хандмаар байгаа юм. Удаа дараа бичгүүд явуулсан. Холбогдох энэ асуудлууд дээр ахиц дэвшил гардаггүй. Эрүүл мэнд болоод нийгмийн баталгааны асуудлууд нь одоог хүртэл орхигдоод, хууль хэрэгждэггүй жил гаруй болж байгаа асуудал байна. Энэ асуудлууд дээр эргээд ингэж хариуцлагагүй хандах юм бол хатуу асуудлууд бас ярина шүү гэдэг асуудлыг бол холбогдох яамдад бас хэлж байгаа шүү.

Н.Учрал: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Энэ Малчны хууль батлагдсан. Яагаад хэрэгжихгүй байна. Хууль батлаад хэрэгжихгүй юм бол хууль батлах хэрэггүй шүү дээ. Ажлын хэсэг байгуулаад үр дүн гарахгүй юм бол ажлын хэсэг ч хэрэггүй. Тэгээд Малчны хууль ямар түвшинд байна. Хэн хариулах вэ. 4 дүгээр микрофон.

Т.Жамбалцэрэн: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн. Мал аж ахуйн салбар, малчны асуудлыг салбарын яам хариуцаж ажиллаж байгаа. Ялангуяа Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ цэнийг өсөн нэмэгдүүлэх зориулалттай Цагаан алт хөтөлбөр, Шинэ хоршоо чинээлэг малчин хөтөлбөр, Атрын 4 дүгээр аянуудын хүрээнд эдгээр 4 хөтөлбөрийн тодорхой тус бүр 1 бүлэг нь мал аж ахуйн салбарыг сайжруулах, сэргээн хөгжүүлэх мал аж ахуйн салбарт чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явж байгаа. Энэ хүрээнд урт хугацаатай, Засгийн газрын нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгүүд, бусад эрх зүйн орчныг сайжруулах чиглэлийн ажлууд хийгдэж байгаа. Энэ чиглэлээр бас холбогдох тайлан, мэдээ, дүгнэлтүүд Улсын Их Хурал, Байнгын хороод дээр бас танилцуулагдаад явж байгаа.

Малчны тухай хууль батлагдсантай холбоотой хэд хэдэн журмуудыг боловсруулах ажлууд салбарын яаман дээр хийгдэж байгаа. Тухайлбал түрүүн яригдсан малчны нийгмийн даатгалыг нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудал журмын төслийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулаад, журмын төслийг боловсруулчихсан хэлэлцүүлгийнхээ шатад явж байгаа. Ойрын хугацаанд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээд, энэ батлагдаад хэрэгжээд явна.

Мөн гамшиг болон аюулт үзэгдлийн улмаас малчин ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 48 сараар тооцож нэмэгдүүлэхтэй холбоотой буцалтгүй тусламжийг олгохтой холбоотой журмын төсөл боловсруулагдсан. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлчихсэн. Ойрын хугацаанд энэ журам маань батлагдаад явчихна. Малчин өрхийн орон нутгийн ипотекийн зээлд хамруулах, зээлийн хөнгөлөлт үзүүлэх энэ зохицуулалттай холбоотой журам 21 аймаг, малчдаар хэлэлцүүлгийн ажлууд

хийгдээд Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлээд, санал солилцоод явж байгаа. Ойрын хугацаанд Засгийн газрын хуралдаанаар ороод хэлэлцүүлэгдэнэ.

Мөн малчин өрхийн хүүхдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр сургахтай холбоотой асуудал журмын зохицуулалт нь батлагдчихсан. Ингээд хэрэгжээд явж байгаа. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан малчныг холбогдох хууль, тогтоомж жил бүр үнэ төлбөргүй хамруулах журмын төслийг боловсруулаад, хэлэлцүүлээд явж байгаа. Үндсэндээ энэ хууль дагасан 6 журам 1, 2 дугаар сард багтаад бүрэн батлагдаад хэрэгжилт нь хангагдаад явна гэсэн ийм мэдээллийг өгье.

Малын индексжүүлсэн даатгалтай холбоотой 2014 онд батлагдаад, 2015 оноос хойш сүүлийн 11 жилийн хугацаанд нийтдээ давхардсан тоогоор 190 орчим, 290 орчим мянган малчин өрх хамрагдсан. Үндсэндээ давхардсан тоогоор 62 сая толгой малыг даатгуулсан ийм дүнтэй байгаа. Тэгээд нөхөн төлбөрт өнгөрсөн хугацаанд 65 мянга орчим малчин өрхөд 26,1 тэрбум төгрөгийн нөхөн олговрыг энэ хуулийн хүрээнд олгосон ийм үзүүлэлттэй байгаа.

Н.Учрал: Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууна.

Н.Наранбаатар: Гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийг зайлшгүй бас тодорхой хэмжээгээр өөрчлөхгүй бол болохгүй байгаа юм. Энэ хууль бол яг бодитой малчид дээрээ очихоор зэрэг бодитой бас хэрэгжиж, тэдэнд тус нэмэр болохоосоо илүү бас тэдний бас бухимдал үүсгэсэн ийм л асуудлууд болчихоод байгаа юм. Тухайлбал нөхөн төлбөрийн асуудал. Нөхөн төлбөрийг авахдаа тэр тухайн сумынх нь малын хорогдолтой уялдуулж өгдөг нь бас их хүндрэл бэрхшээл болчихоод байгаа юм.

Дээрээс нь өөр аймгийн нутагт отор нүүдлээр явж байгаад малаа гамшиг зудад алдчихад бас нөхөн төлбөрийг тооцож өгөхгүй. Үндсэн өөрийнх нь харьяа сумын хорогдолтой уялдуулаад өгдөг. Бас урьдчилаад цаг хүндэрсэн яг хэрэгцээтэй үед бас урьдчилаад, 5 төгрөгийн хэрэг болоод урьдчилаад авчихъя гэхээр бас авч болдоггүй гээд малчдад тулгардаг хүндрэлүүд байгаа. Тэгээд нийт малчдын 10 хүрэхгүй хувь нь, нийт малын 10 хүрэхгүй хувь нь энэ даатгалд хамрагдчихсан гэсэн ийм судалгаа байгаа. Тэгээд эндээс харахад энэ хуулийг бол зайлшгүй өөрчлөх ёстой.

Тийм учраас энэ өөрчлөлтөд саяын миний хэлсэн малчдад тулгардаг энэ бэрхшээлүүдийг хэрхэн засаж сайжруулахаар энэ хуульд орсон байгаа вэ гэдэг дээр асуулт асууя. Тэгээд дараа нь тодруулъя.

Н.Учрал: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Малын индексжүүлсэн даатгалын хуульд Засгийн газраас өргөн барьсан нэмэлт, өөрчлөлт дээр бол үндсэндээ 3 өөрчлөлт л орно гэж тооцож байгаа.

1 дүгээрт бол яг 6 хувь гэж хатуу тогтоосон энэ хувийг тодорхой хэмжээнд 5 болон нэмж, хасах 1 буюу 4, 5 байх энэ бололцоог хуулиар нь нээж өгч байгаа.

2 дахь нь бол яг таны хэлсэн урьдчилж олгох гэж. Яг одоо амьдрал дээр яаж байна вэ гэхээр 6 сард болох хагас жилийн мал тооллогоор малын хорогдлын мэдээ

гардаг. Энийгээ нэгтгэж, даатгалын компаниуд нөхөн олговроо малчдын дансанд хийх гэсээр байтал бараг 10 сар луу гардаг. Тийм учраас энэ хуулийн бас нэг онцлог болох өөрчлөлт нь бол яг цаг хүндэрч байгаа тэр цаг үед энэ урьдчилж 1 удаа олгоно гэдэг бололцоог нь нээж өгч байгаа юм. Энд бол нөгөө Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, Статистикийн газрын мэдээлэл дээр үндэслээд олгоно гэсэн ийм зүйл энэ хуулийн төсөл дээр бас орж байгаа гэдгийг би хэлье.

3-д нь бол яг сая таны хэлдэг энэ хууль хэрэгжиж эхэлсэн цагаас хойш бол ер нь 12 хувиас эхэлж байсан энэ босго 6 хувьд хүрээд, 2014 оноос хойш 10 гаруй жил 6 хувьтай явж байгаа. Энийг нь тодорхой хэмжээнд багасгаад мөн 2014 оноос хойш аймгийн хэмжээнд малын хорогдлын дүнг бол ингэж авч үздэг. Тэгэхээр энэ хуулиараа бол сумын хэмжээнд авч үзэх хэмжээнд очиж байгаа. Тэгэхээр сум 330 сумын хувьд бол босгууд тогтоогдоно гэж бас ойлгож болно.

Отор нүүдэлтэй холбоотой асуудал түрүүнд бас Баасанжаргал гишүүн асуусан. Энэ отор нүүдэлтэй холбоотой асуудал дээр бол тухайн багийн тухайн, өөрийн харьяалагддаг сум, багийн удирдлагууддаа энэ малынхаа хорогдлыг хэдийгээр өөр нутагт явж байгаа, өөр аймаг, өөр сумд явж байгаа ч гэсэн мэдэгдэх ёстой гэж бас үзэж байгаа. Гэхдээ энэ дээр яг Монгол ахуйд буулгах зайлшгүй шаардлага байгаа юм бол отор нүүдэл хийгээд өөр аймагт очоод отор нүүдэл хийдэг. Гэтэл өөрийнх нь аймагт бол нөгөө босго хэмжээнд хүрэхээргүй малын хорогдол гарчихдаг. Оторлож очсон газарт нь болохоор гамшиг болчихдог. Тэгэхэд энэ малчин тэндээс авч чадахгүй байх нөхцөл бас үүсээд байгаа юм. Тэгэхээр энэ ажлын хэсгийн хувьд бол Засгийн газраас өргөн барьсан хуулийн хөндсөн хуулийн заалтууд дээр л ажиллаж байгаа. Ажлын хэсгийн гишүүдийг яг орон нутагт ажиллахад бол сум битгий хэл бүр багаар нь гаргамаар байна гэдэг зүйлийг ярьж байгаа шүү дээ. Зарим сумын хойд талын баг нь зудгүй байхад урд талын баг нь зудтай. Ингээд нийлбэр дүнгээрээ болохоор босго нь бага гараад байдаг. Гэтэл малынхаа 6 байтугай хувийг алдчихсан ийм зүйлүүд байгаа.

Тэгэхээр би түрүүнд хэлсэн. Малын индексжүүлсэн даатгалын хуулийг өшөө сайжруулахын тулд энэ малын гамшигийн эрсдэлийг бууруулах сан эд нар гэж бүр байгуулж/минут дуусав/

Н.Учрал: Нанзадын Наранбаатар гишүүн тодруулна.

Н.Наранбаатар: Тэр өөр аймгийн нутаг дэвсгэрт өвөлжиж байгаа айлуудтай холбоотой бол зайлшгүй бас цаашдаа анхаарахгүй бол болохгүй юм байна. Энэ удаагийн хууль бол үзэл баримтлалын хүрээнд л хөндсөн заалтууд дээр ярих учраас цаашдаа энэ дээр салбарын яам анхаарах ёстой. Яг адилхан зэрэгцээд байж байгаа 2 айл байгаа. Тэгээд хоёулаа адилхан малаа зудад алдчихсан. Гэтэл 1 нь нөхөн төлбөрөө аваад, нөгөөх нь авахгүй байгаа байхгүй юу. Яагаад гэхээр та бол өөр аймаг сумд бүртгэлтэй байна гээд. Уг нь бол хоёулаа адилхан л байх ёстой юм байгаа юм. Тэгээд энэ дээр л малчид бас гомдоллоод байгаа юм. Тэгэхээр энэ дээр цаашдаа онцгой анхаарч ажиллах нь зүйтэй юм гэж. Санал байна. Тодруулах зүйл алга.

Н.Учрал: Баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Жигжидийн Батжаргалын урилгаар Төв аймгийн Зуунмод сумын Социал

Демократ Монголын залуучуудын холбооны гишүүд, залуучууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуулт асууна.

Д.Жаргалсайхан: Энэ малын индексжүүлсэн даатгал гээд энэ хуульд бол өөрчлөлт орох нь зөв. Тэгэхдээ энэ хуулийн ажлын хэсэг нь бас санал нийлэхгүй асуудлууд байна. Тэгээд асуулт асууя. Энэ айл өрх хорогдол гаргачхаад тэгээд даатгуулчхаад малаа бүс нутгийн гэгчхээд байгаа юм. Бүс нутгийн тэгээд аймгийн, сумын гээд яваад өгч байгаа юм. Тэр айлын асуудал биш болчхоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ асуудлыг яаж өөрчилж байгаа юм бэ. Айл л малаа хорогдуулчхаад малаа даатгуулсан бол тэр даатгалаас л хорогдлынх нь даатгалыг авах ёстой шүү дээ. Тэгэхэд бүр сумын асуудал болоод аймгийн, бүс нутгийн асуудал болоод явчхаж байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр яг айлын асуудлыг оруулж ирээч ээ. Тэгээд хөдөөгийн малчид бол их бухимдалтай байна. Тэр тусмаа энэ үнийн өсөлт, бензин шатахууны өсөлт, тэгээд айл өрхөд очиж байгаа тэр хөдөө алслагдсан сумд очиж байгаа тэр тусмаа бас хангайн бүсийн тойрог Баянхонгор, Архангай, Өвөрхангайн сумуудад бас ажиллаад ирлээ. Иргэд маань юу ярьж байна вэ гэхээр энэ залуу малчид тэр тусмаа их бухимдалтай байна. Татварын дарамтад их өртөж байна. Орлогын албан татвар, малын хөлийн татвар, тэгээд мөн дээрээс нь ингээд баахан даатгал гээд авчихдаг. Тэгээд даатгуулахгүй болохоор нөгөө сайн малчин бусад төрөөс явуулж байгаа бодлогод хамрагдаж чаддаггүй. Тэгээд даатгуулчихдаг. Тэгээд эргээд юм олддоггүй. Тэгээд энэ даатгал маань ерөөсөө юу хэлж байна гэхээр яаж нөгөө олгохгүй байх вэ, өгөхгүй байх вэ гэдэг л юманд бүх анхаарлаа хандуулчихсан. Тэгээд л 1 айл зайлуул хорогдол гаргачихлаа, даатгалаасаа мөнгөө олж авна даа гэхэд л сум аймаг болоод, тэгээд бүс нутаг болоод явчихдаг. Энэ айлын асуудал дээр ямар асуудал байгаа юм бэ. Энийг яаж хуулийн өөрчлөлт дээр тусгаж байгаа юм. Тусгаагүй бол тусгаж өгөөч ээ гэдэг ийм асуудал байна.

Мөн дээрээс нь энэ малчдын асуудал ингээд сая ярьж байна л даа. Салбарынхан сайд нь байхгүй. Ер нь энэ малчид руу хандаж байгаа төрийн бодлого гэж ер нь байна уу. Энэ дээр яагаад ер нь анхаарахгүй байна. Сая гишүүд ярьж байна л даа. Үндсэндээ 250 мянган малчин өрх байгаа шүү дээ. Тэгэхэд Малчны тухай хууль гарчихсан. Нийгмийн даатгалыг нөхөн төлүүлэх тухай хууль яагаад хэрэгжихгүй байгаа юм. Яагаад энэ журмыг өнөөдөр хүртэл гаргахгүй, энэ 250 мянган өрх рүүгээ хандсан бодлогоо хэрэгжүүлэхгүй байгаа юм бэ гэдэг дээр энэ салбарын сайд, салбарын хүмүүс хариулт хэлэх ёстой. Ингээд энэ тал дээр малын индексжүүлсэн даатгал дээр ер нь төр оролцох ямар шаардлага байгаа юм. Бүх юм руу төр оролцдогоо хэзээ болих юм. Энэ дээр ямар нэгэн өөрчлөлт орж байгаа юу энэ хууль дээр.

Тэгээд сая урьдчилж олгох гээд юмнууд орж ирж байна л даа. Ер нь л бол айлаар нь л олгочихвол энэ чинь ойлгомжтой байгаа байхгүй юу. Бүр хавтгайруулаад 1 айлын асуудлыг сум, бүс болгоод явчих нь л өөрөө утгагүй байгаад байна шүү дээ ер нь ямар ч нөхцөлд. Тэгэхээр яг малчин руу ирэхдээ энэ хуулийн өөрчлөлтийг бол дэмжмээр байна. Яг энэ өөрчлөх гэж байгаа 3 санаа бол үндсэндээ ямар ч өөрчлөлт алга байна шүү дээ. Заавал индексжүүлэх гээд байх ямар шаардлага байгаа юм. Тэр айлын асуудлыг оруулж ирвэл яасан юм гэсэн ийм ийм асуултууд дээр хариулт аваад, нэмж тодруулж асууна шүү.

Н.Учрал: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Жаргалсайхан гишүүний зарим зүйлтэй бол санал 1 байна. Энэ хуулийн өөрчлөлтийг хийгээд ер нь яг тодорхой ямар бодитой өөрчлөлт орох вэ гээд. Яах вэ, малчидтай бид ч гэсэн ажлын хэсгийн гишүүдийн хувиар очиж газар дээр нь л уулзаж байгаа. Их Хурлын гишүүнийхээ хувиар ч байнга уулздаг. Малчдын хувьд ярьж байгаа зүйл бол яг л таны хэлж байгаа ийм зүйлүүд байгаа. Жишээ нь айлаа биш гэхэд ядаж багаар нь болгомоор байна. Суурь босгыг өшөө багасгамаар байна гэдэг ийм зүйлүүд ярьдаг. Нөгөө жил болгон төлөөд, зудын гамшиг болохгүй болоход нөгөө миний төлсөн даатгал маань тэр чигээрээ л даатгалын сан руу орчихлоо шүү дээ ч гэдэг ийм зүйлүүд ярьдаг. Энийг буцааж авмаар байна ч гэж ярьдаг. Хэрвээ бид яг энэ асуудлыг ажлын хэсэг дээр яриад үзэхээр өнөөдрийн энэ малын индексжүүлсэн даатгал гэдэг энэ тогтолцоог бүр сууриар нь өөр болгож байж цаашаа яг энэ түвшинд очих юм билээ.

Сая тэр ажлын хэсэг дээр бас яг энэ даатгалын түүхийг ярьж байхад 1968 онд нэгдэл, улсын малчин, улсын мал гэж байхад хотонд нь хоргодсон малынх нь тоогоор даатгал өгч үзсэн юм билээ. Энэ даатгалаа бас Герман руу, Англи руу давхар даатгалд оруулаад, явуулж үзсэн. Харамсалтай нь нөгөө Герман, Английн давхар даатгалын компаниуд нь ч энэнээс татгалзаад, энэ бол явахгүй юм байна гээд 1990-ээд оноос хойш байхгүй байж байж байгаад энэ малчид руу хандсан даатгалын систем энэ МИД даатгал буюу малын индексжүүлсэн даатгалаар орж ирж байгаа юм билээ. Тэгээд ажлын хэсгийн гишүүдийн хувьд бол энэ Засгийн газрын өргөн барьсан хууль учраас бид яг нөгөө Засгийн газрын өргөн барихдаа хөндсөн зүйл заалтын хүрээнд энэ асуудал яригдаж байгаа гэж та бас ойлгох хэрэгтэй.

Гэхдээ цаашдаа энэ малын, хөдөө аж ахуйн даатгалын асуудлыг бид бүр цогцоор нь авч үзэх ёстой юм байна гэдгийг би түрүүнд бас таныг орж ирэхээс өмнө бас тайлбарласан. Энэ ганцхан зуд биш ган, малын өвчин, аянга цахилгаан, гэнэтийн үйл явц зурвасхан газрыг хамраад тэр хавийн айлын бүх малыг хорогдуулчихдаг гамшигт хүртэл гарч байгаа шүү дээ. Тэгээд энэ болгоныг бид нар цогцоор нь харсан ийм хөдөө аж ахуйн даатгал тэр дундаа мал аж ахуйн даатгал сая Тэмүүлэн гишүүний хэлж байгаа малчнаа бодсон ч гэсэн тийм даатгалын юмыг бид тэр хуульд нь ер нь цогцоор нь авч үзэх ёстой юм байна лээ гэдэг дээр бол ажлын хэсэг санал нэгдээд ингээд явж байгаа. Энэ хууль дээр бол би сая хэлсэн. Хувь бууруулах асуудлыг малчид бол байнга ярьдаг. Анх 12 хувь байхаас нь 6 хувь болоод 11 жилийн хугацаа өнгөрч байна. Одоо бид энийг харин 4 хувь руу оруулах, 5 хувь руу оруулах энэ хуулийн бололцоог нь энэ хуулиараа нээж өгч байгаа.

Дараа нь урьдчилж олгох гэдгийг бол та бол мэдэж байгаа. Мал нь хорогдчихоод, өвөл нь хорогдсон малын даатгалын мөнгө нь аль наадмын дараа 9 сарын 1-ний ар дээр 10 сар, 11 сард малчны дансанд ордог. Тийм учраас гамшиг болж эхэлж байгаа тэр үйл явцад нь өөрийнх нь даатгуулсан .../минут дуусав/

Н.Учрал: Та нэмэлт 1 минут авах уу. Идэрбат гишүүнд нэмэлт 1 минут.

Ц.Идэрбат: Тэр урьдчилж олгох гэдэг бол яах вэ, нөгөө гамшиг тохиолдсоны ард дээр нь бүр намар өнгөрсний ард дээр мөнгө өгөх биш, яг гамшиг тохиолдож байх, эхэлж байх үед нь хивгийн нь үнэ өсөөгүй, өвснийх нь үнэ өсөж эхлэх гэж байгаа тэр цаг үед нь л яг даатгалынх нь хэмжээгээр өгье гэдэг ийм л зүйл байгаа

юм байна лээ. Малчдын хувьд бол 150 мянган төгрөгөөр даатгаад, эргүүлээд 350 мянга ч юм уу, 400-аад мянгыг авч байгаа ийм тохиолдлууд ч байна. 5 саяар даатгаад, 80 сая төгрөгийн төлбөр өнгөрсөн 2023, 2024 оны өвөл, хаврын тэр зуднаар авсан тохиолдол ч бас байгаа л юм байна лээ. Тэгэхээр ер нь яах вэ, энэ Малын индексжүүлсэн даатгалын хуулийг малчдад бид нар нэлээн ойртуулаад, үнэхээр гамшиг болсны дараа өрхийнхөө амьжиргааг аваад явчих хэмжээнд дахиад малын буян байна өсгөчих тийм хэмжээнд очуулахын тулд бас даатгалын ач холбогдол юмыг бас бид нар нэлээн сайн сурталчлах хэрэгтэй юм билээ. Тэгэхээр нөгөө өнөтэй өвөл болоод байх юм бол .../минут дуусав/

Н.Учрал: Идэрбат гишүүн бол маш ойлгомжтойгоор тайлбарлаж байна шүү. Ер нь Идэрбат гишүүн шиг ингэж хүний хэлээр ярьж сурах хэрэгтэй байна. Тэгэхгүй бол юу яриад байгаа нь мэдэгдэхгүй энэ ажлын хэсгийнхэн. Энэ чинь телевизээр хүмүүс үзэж байна шүү дээ. Малчдад ойлгомжтой хэлээр нь яримаар байна шүү дээ. Тэгэхээр малын энэ хорогдол болохоос нь өмнө, эрсдэл үүсэхээс нь өмнө урьдчилан сэргийлье. Тэгээд та нар энэ даатгалын компани байна. Энэ санхүүгийн зах зээлээ хөгжүүлэх, даатгалын ач холбогдлыг иргэд олон нийтэд ойлгуулах ажлыг үе шаттай хийх ёстой. Засгийн газар бол энэ даатгалын ач холбогдлыг малчдад ойлгуулах ажлыг хийхгүй бол энэ чинь бүрэн дүүрэн ойлгохгүй байна. Тэгээд Засгийн газар энэ даатгалынхаа хуулийг оруулж ирэх хэрэгтэй. Ер нь энэ даатгалын салбарт реформын шинжтэй хууль оруулж ирэхгүй бол энэ чинь зөвхөн малчдын асуудал ч биш шүү дээ. Хувийн эрх зүйн шинэчлэл оруулж ир гээд хэдэн жил ярив. Хувийн эрх зүйн шинэчлэлээ хийе л дээ. Тэгэхээр хувийн эрх зүйн хуулиа оруулж ирмээр байна. Даатгалын хууль оруулж ирмээр байна. Санхүүгийн зах зээлийн хөрөнгийн зах зээлийн ойлголтыг иргэд олон нийтэд ойлгомжтой болгомоор байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Жаргалсайхан гишүүн тодруулъя.

Д.Жаргалсайхан: Энэ төр даатгалын компанитай байх нь хэр зохимжтой юм бэ гээд энэ асуулт асуусан. Энд хариулт авсангүй. Тэгээд ер нь ингээд төр бүх юм руу ингээд оролцоод байх ёстой юм уу. Тэгээд төр оролцчихоор эргээд нөгөө бид нар хуулиа гаргаж чадахаа байдаг. Ер нь бидний хувьд энэ хуулиа гаргаад энэ олон хувийн даатгалын компаниудыг өрсөлдүүлдэг, урьдчилан сэргийлэх дээр малчид руу очиж яаж малаа эсэн мэнд эрсдэлээс хамгаалах дээр нь ажилладаг ийм л тогтолцоо руу явбал их зүгээр харагдаад байгаа байхгүй юу. Гэтэл энэ асуулт хариулт авч чадсангүй. Энэ дээр хариулт авъя.

Дараагийнх нь асуулт. Малчдын нийгмийн даатгалыг нөхөн төлүүлэх тал дээр ямар асуудал гарчхаад байгаа юм бэ. Журам боловсруулах гэдэг асуудал яригдчихаад одоо хүртэл ингээд хууль нь хэрэгждэггүй ийм асуулт байна. Тэгээд энэ дээр энэ салбарынхан, тэр тусмаа сайд маань яагаад энэ асуудал орж ирж байхад ирээгүй байгаа юм бэ. Энэ дээрээ хариулт авмаар байна.

Н.Учрал: Бадамсүрэн сайд Ерөнхийлөгчийн айлчлалд явж байгаа. Албан ёсны чөлөө авсан. 4 дүгээр микрофон хариулъя.

Б.Жавхлант: Сайн байцгаана уу. Жаргалсайхан гишүүний асуултад хариулъя. Төрийн хэвшил малын төсвийн даатгалын тухай хуульд зааснаар бол хувийн хэвшлийн даатгалын 7 компани даатгалын үйл ажиллагааг 21 аймаг, 330 сумд явуулж байгаа. Төрийн эзэмшлийн “Үндэсний давхар даатгал” компани бол хувийн

хэвшлийн даатгалын компанийн эрсдэлийг давхар даатгах чиг үүрэгтэйгээр ордог. Нийтдээ саяын босго үзүүлэлттэй холбоотой асуудлууд дээр бол нийтдээ 330 гаруй сумдаас 270 орчим сум нь бол босго үзүүлэлт 5-аас доош хувь руу орж байгаа болохоор нөхөн төлбөрийн хэмжээ бол нэлээд их хэмжээгээр нэмэгдэх ийм урьдчилсан судалгаа мэдээлэл байгаа. Баярлалаа.

Н.Учрал: Төр даатгалын компани байгуулах хэрэгтэй юу, хэрэггүй юу гэж асууж байна. 4 дүгээр микрофон.

Б.Жавхлант: Малын индексжүүлсэн даатгал бол гамшгийн эрсдэлийн даатгалын тогтолцоо олон улсад байдаг туршлагаасаа үзэх юм бол гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоонд төр оролцох ийм олон улсын жишиг байдаг юм байна лээ. Хувийн хэвшлийн даатгалын компанид өөрийнх нь даах хэмжээнд эрсдэлээ хариуцаад, түүнээс дээшээ давсан хэсгийг төрийн оролцоотойгоор эрсдэлийг хуваарилах механизмыг хангаад мөн түүнчлэн төрийн хэвшлийн даатгалын компани олон улсын давхар даатгал руу бас эрсдэлээ хуваарилах энэ системийг ингэж хэрэгжүүлж явдаг ийм олон улсын зүй тогтол жишиг байгаа юм.

Н.Учрал: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн нэмж хариулна.

Ц.Идэрбат: Тэгээд төрийн оролцоо бол нэг их байхгүй юм билээ. Төр бол яах вэ, энэ даатгалын компаниуд яг арилжааны энэ даатгалын компаниуд яадаг вэ гэхээр малчин хүний портерыг нь даатгахын төлөө л өрсөлдөөд байгаа болохоос биш тэрний малчны хотонд байгаа малыг даатгахын төлөө бол нэг их ажилладаггүй. Тэгэхээр энэ чинь өөрөө маш их эрсдэлтэй учраас төр тэр давхар эрсдэлийг нь даахын тулд төрийн оролцоо энд багахан хувь байдаг юм билээ. Тэгэхээр яах аргагүй бид хөдөө аж ахуй яг арилжааны банкнууд бол хэрвээ төр иймэрхүү оролцоог нь бас тодорхой хэмжээнд хангаж өгөхгүй бол гадаа байгаа портерыг нь даатгая гээд байгаа болохоос биш хотонд байгаа малыг нь бол огт тоодоггүй ийм л юм руугаа бид явчих юм билээ гэдгийг бас хэлэх зүйтэй байх гэж ингэж бодож байна.

Тэр малчдын нийгмийн даатгалтай холбоотой бас .../минут дуусав/

Н.Учрал: 4 дүгээр микрофон.

Т.Жамбалцэрэн: Жаргалсайхан гишүүний асуултад тодруулж хариулъя. Малчны тухай хуульд малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой 6 журам боловсруулахаар байгаа. 6 журмаас одоо 2 журам нь батлагдаад, хэрэгжилтэд хангаад явж байгаа. 4 журам нь боловсруулчихсан. Ойрын хугацаанд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэгдээд, батлагдана. Энэ дотор малчдын нийгмийн даатгалыг нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулаад, хэлэлцүүлээд одоо Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болчихсон явж байгаа. Малчин өрхийн 1 хүүхдийг хөдөө аж ахуйн чиглэлээр сургах, үнэ төлбөргүй сургах асуудалтай холбоотой журам батлагдчихсан. 2025-2026 оны хичээлийн жилд нийтдээ 48 оюутан ХААИС-д хөдөө аж ахуйн чиглэлээр үнэ төлбөргүй сургалтад хамрагдаад явж байгаа. Гамшиг болон аюулт үзэгдэлтэй холбоотой мал сүргийн 50-аас доошгүй хувь нь өртсөн малчин өрхөд/минут дуусав/

Н.Учрал: Хариулт болсон уу. Жамбалцэрэн дарга 4 дүгээр микрофон.

Т.Жамбалцэрэн: Гамшигт болон аюулт үзэгдэл нийт мал сүргийн 50-аас доошгүй хувь нь өртсөн малчин өрх, өрхийн нөхөн төлбөртэй холбоотой асуудлын журам нь боловсруулагдчихсан. Одоо Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон.

Эрүүл мэндийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамрагдах журмынх нь асуудал бас үндэсний хэмжээнд хэлэлцүүлэг хийгдээд, Эрүүл мэндийн яамнаас Засгийн газар дээр өргөн бариад хэлэлцүүлэгдэхэд бэлэн болчихсон. Энэ 4 журам 12 сар, 1 сард батлагдаад гарчихна. Тэгэхээр энэ Малчны тухай хуулийг дагасан малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой 6 журам ингээд үндсэндээ батлагдаад, хэрэгжих бүрэн бололцоотой болчихсон гэж ингэж хэлж болно.

Н.Учрал: Гишүүд асуулт асууж, хариултаа авч дууслаа. Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 6 санал байна. Төсвийн байнгын хороо хуралдаж дууссан уу. Санал хураалтыг нэгтгээд явуулъя. Санал хураалтыг нэгтгэж явуулна.

11.40 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэж эхэлнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт танилцуулна. Индэрт урья.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого баталсан. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болно.

Гэр бүл бол хүн төлөвших, хүн хүнээ гэх сэтгэл бүрэлдэн тогтох анхдагч орчин, хүнлэг энэрэнгүй нийгэм байгуулах эрхэм зорилгын үр үндэс, улс гэрийн хөгжил дэвшлийн гол тулгуур билээ. Тэр ч утгаараа Монгол Улсын Засгийн газраас хүний хөгжлийг бодлогынхоо төвд тавьж, хүнээ бодсон, иргэнээ эрхэмлэсэн засаг, төрийн үйл ажиллагаанаас улс гэр, эх орны ажил амьдралд шууд хамааралтай гэсэн зарчмаар ажиллаж байна.

Хувийн эрх зүйн асуудлуудыг зохицуулж байгаа суурь хуулиудын 1 нь 1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хууль боловч тус хууль нь гэр бүл, хүүхдийн эрхийг хамгаалах өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй болжээ. Цаашлаад хувьсан өөрчлөгдөж буй гэр бүлийн харилцааг бүрэн зохицуулж чадахгүйгээс практикт гэр бүлийн харилцааны олон асуудал гарахад хүүхэд, гэр бүлийн

гишүүдийн эрхийг бүрэн хамгаалж чадахгүй, мухардмал, ойлгомжгүй байдлыг үүсгэж нийгмийн өмнө тулгамдсан хөндүүр сэдвийн тоо улам бүр нэмэгдсээр байна.

Тухайлбал, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн эрх буюу гэрлэгчдийн дундаа болон хамтран өмчлөх эд хөрөнгийн эрхийн зохицуулалт, гэрлэлтийн гэрээ, хамтын амьдралыг гэрлэлттэй адилтгах нөхцөл байдал, хүйс солиулах нь гэрлэлтэд ямар үр дагавар үүсгэх, тээгч эхээр хүүхэд тээлгэх, зохиомол үр суулгах нь гэр бүлийн өв залгамжлалын эрх зүйгээр хэрхэн зохицуулагдах гэх мэт шинэ тутам тулгамдаж буй ээдрээтэй олон асуудлуудыг уг хууль бүрэн зохицуулж чадахгүй байгаа болно.

Тиймээс хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй өөрчлөлтийг тусгалаа.

1.Монгол улсад гэрлэлт цуцлалтын хувь хэмжээ жил ирэх тутам нэмэгдэж, тэр хэрээр гэр бүл салалтын улмаас эрх нь хамгийн их зөрчигдөх хүүхдийн асуудлыг хамтад нь шийдвэрлэхгүй байх тохиолдол улам бүр даамжирч байна. Иймд гэрлэлт цуцлалтаас болж хүүхэд хохирохгүй байх, хүүхдийн тэтгэлэг, хүүхдийн асрамж, тусдаа амьдрах эцэг эсхүл эхийн хүүхэдтэйгээ уулзах асуудлыг гэрлэлт цуцлалтай хамтад нь заавал шийдвэрлэж байхаар тусгаж байна.

2.Хүүхдийн тэтгэлгийн хэмжээг амьжиргааны доод түвшний хэмжээгээр бүгдийг тэгшитгэх бус тэтгэлэг төлөгчийн хөрөнгө, орлого, тэтгэлэг авагчийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нарийвчлан тогтоох. Хүүхдийн тэтгэлгийг сургуульд сурч байгаа 18-21 насны болон асаргаа, сувилгаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд наснаас үл хамааран олгохоор тусгалаа.

3.Гэрлэлт дуусгавар болсноос тусдаа амьдрах болсон эцэг эсхүл эх хүүхэдтэйгээ уулзах, уулзуулах үүргийг хуульчилж, хүүхэдтэйгээ уулзахгүй эсхүл хүүхэдтэй нь уулзуулахгүй бол Зөрчлийн тухай хуулиар албадан биелүүлж шийтгэл оногдуулахаар тусгаж, эцэг, эх байх хүүхдийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтийг нэмэгдүүлэх хуулийн хөшүүргийг бий болголоо.

4.Гэрлэлтийн гэрээ байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах, гэрлэлтийн гэрээ байгуулсан бол гэрлэлт цуцлахад гэрээний дагуу дундын эд хөрөнгийг хуваах нөхцөлийг бүрдүүллээ.

5.5-аас доошгүй жил хамтран амьдарч, эд хөрөнгө бий болгосон хамтран амьдрагчдын хамтын амьдрал дуусгавар болоход гэрлэгчдэд дундын эд хөрөнгөө хуваадагтай адилтган үзэхээр тусгалаа.

6.Цус ойртолтоос сэргийлж гэрлэлт бүртгүүлэхээс өмнө садан төрлийн холбоотой эсэхээ шалгуулж болохоор тусгасан болно.

7.Хүүхдийг үрчлүүлэх асуудлыг Засаг дарга шийддэг бус шүүх шийдвэрлэдэг байдлаар үрчлэлтийн асуудлыг олон улсын жишигт нийцүүллээ.

8.Хүүхдэд асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоохдоо тэргүүн ээлжид гэр бүлийн орчинд өсөн торних нөхцөлийг хангаж, асралт гэр бүлийн талаар тусгасан болно.

9.Гэр бүлээс гадуур харилцааны улмаас гэрлэлт цуцалбал буруутай гэрлэгчээс сэтгэл санааны хохирлоо нөгөө талд нэхэмжлэх мөн энэхүү нөхцөл

байдлыг дундын эд хөрөнгөө хуваахад харгалзан үзэхээр тусгалаа. Түүнчлэн гэр бүлээс гадуур харилцааны улмаас гэрлэлт цуцалсан бол хүүхэд нь буруутай эцэг эсхүл эхээ заавал тэжээн тэтгэх үүрэггүй байхаар тусгалаа.

10.Хүйсийн өөрчлөлтийн улмаас гэрлэлт дуусгавар болох, тээгч эхээр хүүхэд тээлгэхэд гэрээ байгуулсан гэрлэгчид хүүхдийн эцэг, эх байхаар мөн өөр хүний бэлгийн эсийг ашиглан хүүхэдтэй өөр хүний бэлгийн эс ашигласан гэрлэгчид хүүхдийн эцэг, эх байхаар тусгалаа.

Хуулийн төслийг дагалдуулан Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг 10 хуулийн төслийг боловсруулсан болно.

Бүхнээс эрхэм, бүгдээс чухал гэр бүлийн өмнө тулгамдаж буй эмзэг хийгээд ээдрээтэй олон асуудлын учиг зангилааг тайлж, нарийвчлан зохицуулах уг хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулгыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт танилцууллаа.

Төрийн ордны үйл ажиллагаатай Гэр бүлийн хууль хэлэлцэж байх энэ цаг мөчид Нийслэлийн ерөнхий боловсролын 73 дугаар сургуулийн 8^е ангийн багш, сурагчид танилцаж байна. 8^е ангийнхаа багш, сурагч та бүхэнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсье.

Гэр бүлийн хууль хэлэлцэх гэж байна шүү гишүүд танхимд цуглая. Тэгээд Гэр бүлийн хууль дээр танхимд байхгүй хүмүүс бол тэгээд ер нь хандлагаараа харуулж байна. Тэгээд хариуцлагатай гишүүд бол танхимд сууж байна. Тэгээд гэр бүлдээ хариуцлагатай хүмүүс орж ирж суух хэрэгтэй. Сууж байгаа хүмүүс бол тун их хариуцлагатай хүмүүс байгаа шүү тийм. Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар тэргүүтэй гишүүд оролцож байна. Тэгэхээр Гэр бүлийнхээ хууль дээр өндөр ач холбогдол өгье. Нийгэм, олон нийт бас харж байна. Тийм учраас иргэд, олон нийтэд зөв ойлголт, мэдээллүүдийг өгч, шүүн тунгаах хуулийг батлах учиртай. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулахаас өмнө та бүхэнд төслүүдийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга Даваагийн Цогтбаатар танилцуулна. Индэрт урья.

Даваагийн гэж андуурчихсан байна шүү. Байнгын хорооны дарга биш төслүүдийн талаарх би нөгөө Байнгын хорооны дарга унших гэж байна гэж ойлгоод байна.

Төслүүдийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна. Индэрт урья.

Да.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 2, 3-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хууль санаачлагч хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эмэгтэй эсхүл бага насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан болон хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах зарчмыг баримтлан гэр бүлийн харилцааг олон улсын жишигт нийцүүлэх, шинээр үүсэж байгаа харилцааг зохицуулах, орхигдсон буюу хийдлийг арилгах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хууль санаачлагч хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад 1 жилд нийт 834 сая төгрөгийн хүний нөөцийн зардал нэмэгдэх бөгөөд хэрэгжүүлэгч агентлагуудад 248 сая төгрөг, шүүхэд 585 сая төгрөгийн зардал гарахаар тооцжээ.

Мөн 1 удаагийн нэмэлт зардалд 4 тэрбум 310 сая төгрөг, орон тооны бус зөвлөлийн жилийн цалин 90 сая төгрөг байхаар, иргэд гэрлэлт бүртгүүлэхтэй холбоотой сургалтад хамрагдах, лавлагаа авах, ДНХ-ийн шинжилгээ өгөх зэрэг үйл ажиллагаанд дунджаар 285 минут зарцуулж, 1 тохиолдолд 62 мянган төгрөгийн зардал гарах бөгөөд нийт тохиолдлоор авч үзвэл 993,3 сая төгрөгийн зардал үүсэхээр тооцоолсон бол хуулийн этгээд аливаа зардал үүсэхгүй гэж тооцсон байна.

Уг хуулийн төслийг D-Parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир гэр бүлийн үнэ цэн, эцэг эх байхын ач тус, үүрэг хариуцлагын талаар ерөнхий боловсролын сургууль болон их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрүүдэд ямар хичээл сургалт орж байгаа талаар, одоо мөрдөгдөж байгаа хуульд энэ асуудлыг хэрхэн зохицуулж байгаа талаар, мөн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хэрхэн тусгагдсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа хуулийг төслийн зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд шүүх шат дамжлага, хугацааг хэрхэн тодорхойлсон талаар, шүүхийн маргаан эцэслэх хүртэлх хугацаанд хүүхэд ямар нөхцөлд байх талаар, асрамжийн үйлчилгээний зардлыг хэн, ямар эх үүсвэрээр санхүүжүүлэх талаар, Монгол Улсад шаардлагатай шинжээч боловсон хүчин бэлэн байгаа эсэх, гэрлэлт бүртгүүлэхэд эрүүл мэндийн шинжилгээг ямар байгууллага, ямар журмаар хийх, иргэдэд ямар хэмжээний зардал, ачаалал үүсэх, төрөөс санхүүжүүлэх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Сайнзориг ургийн овгийг замбараагүй, буруу бүртгэгдсэн байдал түгээмэл байгаа нөхцөлд овгийг 1 удаа улсын хэмжээнд цэгцлэх зохицуулалтыг хүн амын тооллогын архивын мэдээлэлд тулгуурлан үнэн зөв тогтоох асуудлыг дагаж мөрдөх журмын хуулиар зохицуулах боломжтой эсэх, тээгч эхээс төрж буй хүүхдийн тоо, түүнтэй холбоотой эрх зүйн маргаануудын статистик судалгааны талаар, тээгч эхтэй холбоотой өв залгамжлал, эцэг эхийн эрхийн онцгой зохицуулалтыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар, гэрлэлтийн гэрээний ач холбогдлыг олон нийтэд ойлгуулах талаар хуульд хэрхэн тусгасан талаар, асралт гэр бүлд тавигдах шаардлагуудын талаар, хамтран амьдрагчийн харилцааг гэр бүлийн хуулиар зохицуулсан нь оновчтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал НҮБ-аас 2015 онд өгсөн Гэр бүл,

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн талаар 37 дугаар зөвлөмжийг хуулийн төсөлд тусгасан эсэх, сэтгэцийн болон оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг 1 ангилалд багтаан гэр бүл зохиох, хүүхэдтэй болох, хүүхэд үрчилж авах эрхийг хориглосон зохицуулалтын талаар, гэр бүл болон янз бүрийн хэлбэрүүдийг хуулийн төсөлд ямар хэмжээнд хүлээн зөвшөөрч, хамгаалж байгаа талаар, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хэрхэн тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл Гэр бүлийн шүүх байгуулах үйл ажиллагаа, өнөөгийн нөхцөл байдлын талаар, гэр бүлийн маргааныг тусгай процессын хуулиар шийдвэрлэх нь ямар давуу тал, ач холбогдолтой болох талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар гэрлэлт бүртгүүлэхээс өмнө эрүүл мэндийн шинжилгээ өгөхийг заавал үүрэг болгох нь зөв эсэх, удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй эсэх шинжилгээг ДНХ-ийн шинжилгээтэй хамтатган хийх боломжтой эсэх, ургийн бичиг хөтлөх үүргийг биелүүлэхгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа Гэр бүлийн тухай хууль нь хүн бүрд хамааралтай, өмнөх 4 жилийн парламентын хугацаанд батлагдаагүй тул энэ заавал батлагдах шаардлагатай бөгөөд гэр бүл салалтын талаар дараах хүүхдийн эрхийг хамгаалах тэтгэмжийн асуудлыг шуурхай шийдвэрлэх эрсдэлийн сан байгуулж, тодорхой хугацаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, үүргээ биелүүлээгүй этгээдэд хариуцлага тооцох, шийдвэр гүйцэтгэлийг сайжруулах зэрэг олон улсын туршлагад нийцсэн зохицуулалтуудыг тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Гэр бүлийн тухай хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа бөгөөд нэр томьёог нь шинжлэх ухааны үндэслэлтэй хэрэглэх, ургийн овгийг цэгцлэх, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх, технологийн шийдэл судлах, хамтын амьдрал, харилцаанд хугацааны зохицуулалтыг бодит нөхцөлд нийцүүлэх, хүүхдийн эрх хамгаалалт, эд хөрөнгийн маргаанд төрийн оролцоог нэмэгдүүлэх холбогдох бусад хуулиудтай уялдуулан санхүүжилт механизмын зэрэг асуудлыг шийдэх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал НҮБ-ын зөвлөмжид тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн асуудлаар анхаарах, дотуур байрны хүүхдийн асран хамгааллын зохицуулалтыг нарийвчлах, гэр бүлийн олон янз байдлын төсөлд тусгах хууль тогтоомжийн уялдаа иргэдийн нийгмийн оролцоог хангах, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хуулийн төслийг дэмжиж байгаа бөгөөд Гэр бүлийн тухай хууль 1999 онд батлагдсан. Батлагдсанаас хойш Монголын нийгэм ардчилсан зах зээлийн тогтолцоонд шилжиж хөгжлийн шинэ шатад өмнө гарч, өмнөх зохицуулалтууд амьдралын бодит шаардлагад хүрэхгүй хоцрогдсон зүйлүүд олон байх тул энэ хууль, суурь хуулийг боловсруулж батлах үйл явцад Байнгын хорооны гишүүд идэвхтэй оролцож, санал бодлоо илэрхийлэн ажиллах нь чухал талаар тус тус үг хэлж, байр сууриа илэрхийллээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасны дагуу санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг үзэл баримтлалын хүрээнд 80 хувиар дэмжиж, холбогдуулан боловсруулсан 2 хуулийн төслөөс бусад хуулийн төслүүдийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийг хүчингүй болгосонд тооцох тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцсэн эсэх талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Цогтбаатар гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Бямбацогт, Пунцагийн Золзаяа Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Бадамдоржийн Мандалбаяр Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын шүүгч, Нэргүй Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ядамдоржийн Жавхлан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Оюунбаатарын Оюунзул Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батбаатарын Дашдаваа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Банкны төлбөр барагдуулах газрын дарга, Батсайханы Тэнүүн Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын Лабораторийн эрхлэгч, цагдаагийн хошууч, Коллегийн Нямдаваа Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Очирбатын Амарсанаа Олон улсын Улаанбаатар их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, Хууль зүйн доктор, дэд профессор, Мангалсүрэнгийн Цогтбаатар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын ахлах шинжээч. Ажлын хэсгийг танилцууллаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэл, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууна.

Г.Тэмүүлэн: Засгийн газраас Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг оруулж ирж байна. Энэ хуулийн төсөл дээр бас дэвшилттэй харилцаануудыг, зохицуулалтуудыг, заалтуудыг бас оруулж ирсэнд талархалтай байгаа. Энэ дотроо нэг талдаа энэ хуулийн төслийн 5.5 дээр үндсэндээ цус ойртолтоос сэргийлэхтэй холбоотой, удмын сангийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой зохицуулалтууд бол орж ирсэн байгаа. Би энэ дээрээс 1 зүйлийг бас онцолж хэлэх гээд байгаа зүйл маань яах вэ, хууль гарч байна манайд. Хууль гараад, хууль нь өөрөө хэрэгждэггүй. Засгийн газраас болоод тэр дундаа Улсын Их Хурлаас, тэр дундаа гишүүдээ оруулж ирж санаачилж батлуулсан хууль тогтоомжууд хэрэгжилт үндсэндээ бас байхгүй байна. Би үүний бодит нэг жишээг нь авч хэлэх гээд байгаа зүйл маань бол 2022 оны 1 сарын 14-нд буюу Улсын Их Хурлын 1 дүгээр тогтоолоор энэ удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн

амын өсөлтийг дэмжих тухай тогтоолын төслийг бас нэр бүхий гишүүд, миний бие бас өөрөө санаачлаад батлуулсан юм.

Ингээд яг 3 дахь жилийнхээ нүүрийг 4 дэх жилийнхээ нүүр лүү орох гэж байна. Энэ дээр бид нар тодорхой зүйлүүдийг зааж өгсөн юм. Тэгээд энэ асуудлуудын хэрэгжилт ерөөсөө үндсэндээ байхгүй байгаад байна. Би зүгээр хамгийн энгийн жишээний асуудал бол бид нар ер нь зөвхөн зүгээр удмын сан гэхээсээ илүүтэй шинжлэх ухааныхаа салбарыг дэмжих, дээрээс нь юу гэдэг юм ер нь бүхий л чиглэлээр генетикийн оношилгоо болоод яг орчин үеийн техникийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх энэ асуудлуудыг хүртэл тусгаж оруулж ирсэн. Энэ өөрөө бас хэрэгжиж байгаа зүйл байхгүй байгаад байна.

Би тэгэхээр энэ дээр онцолж хэлэх гээд байгаа зүйл маань ер нь юу юм бэ гэхээр энэ гэр бүлийн эрх зүйн тогтолцоо дээр бид нар хувь хүний хөгжлийг дэмжих, хувь хүнийг хамгаалах, тухайн хүний эрүүл мэндийн аюулгүй байдалтай холбоотой, удмын сангийн аюулгүй байдалтай холбоотой асуудлууд маань өөрөө суурь харилцааны нэг болчихоод байгаа юм. Ингээд аваад үзэхээр хамгийн сүүлд Монгол Улс чинь хүнээ ерөөсөө судлахаа больчихоод байдаг. Энэ талаараа түүвэрчилсэн судалгаанууд хийхээ больчихоод байдаг. Цус ойртолтын түвшнийг нь аваад үзэхээр улсын хэмжээнд магадгүй энэ алсуур 6,5 хувьтай болчихсон ч гэдэг юм уу, нийт хүн амын чинь 80 хувь нь 4 ба түүнээс дээш үеэ мэддэггүй болчихсон. 88,5 хувь нь ургийг ч хөтөлдөггүй. Мөн юу гэдэг юм тухайн овог нэршлийг нь аваад үзэхэд нийт 702 мянган хүн 1 овогтой байдаг. Эргээд гэр бүл салалтын түвшин ч гэдэг юм уу том энэ эрх зүйн тогтолцоо тогтолцоо талаасаа аваад үзэх юм бол 2002 онд гэр бүл салалт өөрөө 3,2 байсан бол өнөөдөр 2020 онд 23,2 буюу бараг 10 дахин өссөн асуудал байгаад байгаа юм. Өнөөдөр 2025 онд энэ тооцоо судалгаа хэд болсон гэр бүл салалтын түвшин.

Нөгөө талдаа энэ удамшлын өвчин болоод тухайн юу гэдэг юм эрүүл мэндтэй холбоотой, хувь хүний эрүүл мэндтэй холбоотой асуудлууд бас нэлээн нэмэгдээд байдаг. Тэгэхээр энэ болгон дээр бид нар уг нь зохицуулалтуудыг нь хийх, хүнээ хамгаалах, тухайн тэр улс орны тусгаар тогтнолын баталгаа болсон удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах энэ зохицуулалтуудыг бас ингээд хууль дээр хийж өгсөн боловч зүйл заалт болгоноор нь аваад үзэхээр хэрэгжсэн заалт ерөөсөө байхгүй. 7 заалт байгаа. 7 заалт дотроосоо бид нар 1 талдаа энэ саяын тэр генетикийн лабораторийг ч байгуулах асуудал, Монголын төр өөрөө хүнийхээ энэ чиглэлээр, гений аюулгүй байдлын сангийн чиглэлээр ч гэдэг юм уу тодорхой хууль, генетикийн оношилгоо, эмчилгээ, гений аюулгүй байдлын чиглэлээр холбох хуулийн төслүүдийг боловсруулж оруулж ирэх хугацаа зааж өгсөн. Энэ хэрэгжиж байгаа зүйл, заалт бас байхгүй байгаад байдаг. Цус ойртолтоос сэргийлэх, ургийн бичиг хөтлүүлэх, мөн дээрээс нь овог нэршилтэй холбоотой асуудлуудыг зохицуулах энэ асуултууд бас байхгүй байгаад байдаг. Хугацаанууд нь бас өнгөрчихсөн байдаг.

Мөн энэ эрсдэлээс сэргийлэх, төрийн бодлого хэрэгжих удирдлага, зохион байгуулалтуудыг нь сайжруулах гээд эдгээр асуудлууд байхгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр хууль оруулж ирж байгаа..../минут дуусав/

Н.Учрал: Хэн хариулах вэ. Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Тэмүүлэн гишүүн бас маш чухал асуудал хөндөж байна. Тэгээд хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бол Засгийн газарт байдаг. Сая бас таны ярьж байгаа асуудлууд дээр анхаарч хаана, яагаад хэрэгжилт нь удааширчхав, саатчихав гэдэг дээр бас тодруулж танд бас хариу мэдээлэл өгье.

Гэр бүлийн тухай хуульд сая таны ярьсан цус ойртолттой холбоотой, хамаатан саднаа бас тодруулахтай холбоотой тодорхой зохицуулалтууд орсон байгаа. Яалт ч үгүй энэ 1999 онд батлагдсан хууль, 8 удаа жижигхэн найруулгын шинжтэй өөрчлөлт орсон. 2016 оноос Гэр бүлийн тухай хуулийг бас шинэчилж найруулж, Их Хурлаар оруулах гэж үе үеийн Засгийн газар бас оролдож, Их Хуралд оруулж ирж буцаагдаж байсан. Ийм бас чухал ач холбогдолтой хууль. Өнөөдөр үндсэндээ гэр бүлийн үнэ цэн, ялангуяа гэр бүл салалтаас болж хүүхдүүд хохирч байгаа асуудал. Нийгмийн хөгжил, дэвшилтэй холбогдоод гэр бүлийн харилцаанд үүсэж байгаа олон чухал харилцаануудыг зохицуулах ийм шаардлага үүсчхээд байгаа юм.

Тэгээд Монгол Улсын Үндсэн хуульд гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоогдсон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй 2-ын тэгш эрх, сайн дурын харилцаан дээр үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална. Мөн хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө төр хүлээнэ гэсэн ийм Үндсэн хуулийн заалтууд байгаад байдаг. Гэсэн мөртөө амьдрал дээр бодит байдал дээр хэрэгждэггүй. Хэрэгждэггүй.

Мөн бас Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримтад хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих, идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ гээд заачихсан. Тэгээд ийм бас бодлогын олон бичиг баримтуудад тусгагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр хүртэл бид бүхэн бас Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн батлуулж, чанартай амьдрал гэр бүлийн гишүүний оролцоог дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гээд заачихсан байгаа юм. Энэ хүрээнд энэ хуулийн төсөл орж ирж байгаа. Тийм болохоор саяын ярьж байгаа гэр бүл салалт болон нэлээд олон чухал харилцаануудыг зохицуулж байгаа. Тэгээд цус ойртолтыг нөгөө ДНХ-ийн шинжилгээ өгөөд тогтоолгох бололцоо нь энэ хуулиар нээж өгсөн. 5.5 дээр. Өнөөдөр Монгол Улсын нийт хүн амын 6,1 хувь нь цус ойртолттой байна гэсэн ийм судалгаа гардаг. Энэ бол Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, цаашлаад хүн амын удмын сан гээд бас ноцтой учраас энэ дээр зайлшгүй энэ хуульд оруулж өгсөн. Мөн хамаатан садан мөн үү, биш үү гэдгээ тогтоолгохыг өөрсдөө сайн дураар тогтоолгох ийм бас боломжийг бас энэ хуульд бас зохицуулж өгсөн байгаа. Тийм болохоор таны санаа зовж байгаа эдгээр асуудлуудыг энэ хуульд урьд нь зохицуулагддаггүй байсан бол зохицуулахаар тусгасан байгаа гэдгийг хэлье.

Н.Учрал: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн тодруулна.

Г.Тэмүүлэн: Энэ заалтуудаас би гол үндсэн 7 асуултаас гол үндсэн юм нь юу байгаад байгаа юм. Энэ генетикийн судалгааг хөгжүүлэх асуудал байгаад байгаа юм. 2022 онд батлагдсан энэ асуудал дээр бид нар генетикийн лабораторийг байгуулаач ээ, энэ чинь зөвхөн хүнтэй холбоотой асуудал биш ээ. Үндсэндээ дэлхийн зах зээл дээр жил бүр юу гэдэг юм 8 тэрбум ам.долларыг юу гэдэг юм зах зээлийнх нь судалгаанд нь зарцуулаад байгаа байхгүй юу. Генетикийн чиглэлээр. Тэгэхээр энэ чинь Монгол Улсын цаашдын ирээдүйн хөгжил, энэ хөдөө аж ахуйн салбар дээр, байгаль орчин дээр, түүх археологи дээр, мөн том зургаар авч үзэх юм

эрүүл мэнд энэ юунаасаа гадна зөвхөн зүгээр шинжлэх ухааны дэвшлийг нь Монгол Улсад нэвтрүүлэхтэй холбоотойгоор бид нар чинь генетикийн лаборатори хэрэгтэй байна гэдэг асуудлыг яриад байгаа юм. Үүний цаана бол том бодлогын асуудал нь бид нар хүнээ хамгаалах бодлого нь бас давхар явж байгаа асуудлууд байгаад байгаа юм. Энэ хөдөө аж ахуйн салбар болон бүх салбарууд дээр бид нар шинэ технологийг нэвтрүүлж гэвэл бид нар судалгаа шинжилгээ байхгүйгээр, шинжлэх ухаанчаар хандахгүйгээр, лабораторийг нь байгуулахгүйгээр, генетикийн судалгааг хөгжүүлэхгүйгээр бид нар хөгжихгүй болчихоод байна шүү дээ. Тэгэхээр бид нар энэ дээр ер нь ямар бодлого байгаад байгаа юм. Яг энэ хуулийн хэрэгжилт яагаад хэрэгжихгүй байна.

Н.Учрал: Ажлын хэсгээс нэмж тодруулж хариулъя. Хэн хариулах вэ. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон.

Б.Тэнүүн: Сайн байцгаана уу. Шүүх шинжилгээний ерөнхий газрын ДНХ-ийн лаборатори эрхлэгч, цагдаагийн хошууч Тэнүүн байна. Тэгээд Шүүх шинжилгээний ерөнхий газрын ДНХ-ийн лабораторийн талаар бас ерөнхий ойлголт өгье гэж бодож байна. Манай лаборатори болохоор ерөнхийдөө 2025 он энэ онд гэхэд 3400 орчим шинжилгээ, 10 мянга гаруй объектод шинжилгээ хийж ингэж ажилласан байна. Тэгээд манайд 15, 16 хүмүүс бол ажилладаг. Тэгээд Эрүү, иргэний холбоотой хэргүүд дээр ажиллаж байгаа. Тэгээд яг энэ шинэ асуудалтай холбоотой гэр бүлийн төрөл садны хамаарал тогтоох шинжилгээг болон яг эцэг тогтоох шинжилгээний журмаар бол хэрэгжүүлээд явчих бололцоотой гэж үзэж байгаа. Шүүх шинжилгээний байгууллагын 21 аймаг, 8 хэсэг .../минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут 4 дүгээр микрофон.

Б.Тэнүүн: 21 аймаг, 8 хэсэг, 5 бүсийн төв байгаа. Энэ бүсийн төвүүдээрээ дамжуулаад шинжилгээний дээжүүдийг гэр бүлийн гэрлэгч хосуудаас аваад, тэгээд удам төрлийн хамаарлыг тогтоох шинжилгээг бол хийх бололцоотой байгаад байгаа. Сайн дураараа. Тэгээд мэдээж нөгөө суурь судалгаа бас хийгдэх зайлшгүй шаардлага байгаа. Монголын хүн амд статистик тоон өгөгдлөөрөө болохоор хүн амын 1 хувьд нь заавал статистик шинжилгээ хийж байж генетик давтамжийг тогтоож, хосуудын генетик зай ойртож байгаа эсэхийг бол судалж болно.

Н.Учрал: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууна. Тэмүүлэн гишүүн тодруулах юм уу. Тэмүүлэн гишүүн тодруулъя.

Г.Тэмүүлэн: Уг нь сайд аа, би яг л бодлогын асуудал асуугаад байгаа шүү дээ. Шинжлэх ухааны салбарын асуудал, генетикийн судалгааны асуудлыг асуугаад байдаг. Зүгээр энэ лаборатори өнөөгийн түвшин маань ямар түвшинд байгааг би асуугаагүй. Тэгэхээр бодлогын түвшинд хариулах хүн нь байна уу. Энэ асуудал хариуцсан сайдууд нь байна уу. Асуудал дээр хариулмаар байна.

2 дугаарт энэ тогтоолын 7 дугаар заалт дээр чинь бид нар юу гэдэг юм хүн амынхаа өсөлт болоод гэр бүлийнхээ тогтвортой хөгжлийг дэмжих үүднээс энэ жирэмсэн эх болоод эх хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, асаргаа сувилгааны асуудлыг, чанар хүртээмжийн асуудлыг хүртэл хуульчилж зааж өгсөн. Энэ хуулийн заалтууд ерөөсөө хэрэгжээгүй байгаад байдаг. Өнөөдөр бид нар үндсэндээ тэр гэр бүлийн харилцаа болсон тэр дөнгөж шинэ төрсөн хүүхэд болоод эхийн асаргаа, сувилгааны чинь шинэ тогтолцоо бид нарт бас хэрэгтэй байна. Энийг олон улсын

стандартад нийцсэн үйлчилгээ, чанар хүртээмжүүдийг дээшлүүлэх юм бий болгомоор байна гэсэн асуудлууд байгаа. Тэгэхээр энэ 7 заалтаас хэрэгжсэн заалт байхгүй учраас энэ дээр яах вэ гэдэг асуудлыг анхаармаар байгаа юм.

Н.Учрал: Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Сая тэр цус ойртолттой холбоотой ДНХ шинжилгээ хийх боломж бол байгаа гэдгийг шүүх шинжилгээний байгууллага хариуллаа. Энийг нь олон улсын практик жишгээрээ ч гэсэн бол сайн дураараа хийгддэг. Монголд ч гэсэн бол сайн дураараа гэрлэх гэж байгаа хосууд хийлгэх бололцоотой. Гэрлэсэн байгаа иргэд ч гэсэн өнөөдөр хэн ч гэсэн хийлгэх бололцоотой. Энийг хийх лаборатори нь байгуулагдчихсан. Сайн дураар бас очоод хийлгэх бололцоотой байгаа.

Таны ярьж байгаа тэр Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал бол яг өнөөдөр Их Хурлаар ярьж байгаа Гэр бүлийн тухай хуультай хамааралгүй асуудал байна. Гэхдээ би танд албан ёсоор дараа нь бичгээр тэр Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт иймэрхүү шатдаа явж байна, иймэрхүү байдалтай байна, цаашдаа ийм зүйл дээр нь анхааръя гэдгийг холбогдох яамных нь сайдаар албан ёсоор бичгээр танд бас хариултыг өгүүлье.

Н.Учрал: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууна.

Х.Тэмүүжин: Танай намынхныг хууль санаачлах тэр дундаа Гэр бүлийн хууль санаачлахад би жоохон болгоомжтой хандаад байгаа юм. Өргөн барьсан хууль хэлэлцэхээс өмнө нийгэмд явж байгаа уур амьсгал, тэгээд танай намаас энд тэнд алба хашиж байгаа хүмүүсийн амнаас гарахаар ариун гэр бүл, жинхэнэ хайр гэх мэтчилэн ер нь хуулиар зохицуулагдахгүй хувь хүмүүсийн өөр хоорондын дотоод асуудлыг ер нь улс төрийн нийтийн асуудал болгоод нэг хүний нүдээр дээрээс нь харж байгаад шийдчих санаатай үг, өгүүллүүд их гараад байсан. Тэгээд болгоомжлоод, сэрэмжлээд өргөн барьсан хуулийг уншсан. Харин харьцангуй гайгүй.

Ер нь бол гэр бүл гэдэг чинь энэ чөлөөт нийгмийн хамгийн төр орж болдоггүй, хувь хүмүүст өөрт нь боломж олгож байдаг, хувь хүмүүсийн өөрийнх нь дотоод мөрөөдөл ертөнцийг тэнд нь үлдээж байдаг тийм орчин, тийм зүйл. Төр болгоомжтой орох ёстой. Тэр дундаа улс төрчдийн нүдээр нэг ариун гэгээн бурхны нүдээр харж оруулж болдоггүй тийм орон зай. Дэлхий нийтээрээ Гэр бүлийн хуулийг хийхдээ ерөөсөө 3 зүйл дээр л санаа зовж байгаа юм. Хүүхдийн эрхийг яах юм. Өмчийн маргаан гарвал яах юм. 1 нэгнийгээ хайрладаг хамгийн дотно хүмүүс эд хөрөнгөөс болж маргавал тэр маргааныг нь яаж шийдэх юм. Тэгээд хөндлөнгийн оролцоог яаж хязгаарлах юм. Энэ хөндлөнгийн оролцоо гэдэг дээр төрийн оролцоо өөрөө ч гэсэн байгаа байхгүй юу. Энэ чинь сайн дурын үндсэн дээр бий болдог. Энэ иргэний нийгмийн хамгийн суурь, улс төрөөс ангид, эдийн засгийн дарамт шахалтуудаас бас нэг хамааралгүй багатайнхан шиг, тэр дундаа үзэл суртлаас, дарга нарын хувийн бодлоос хамгийн эрх чөлөөтэй байх ёстой тэр орон зай нь.

Тэгээд одоо энэ 3.2 дээр заачихсан байгаа нэг зүйлийг та хэдэд уншаад өгөөдөхье. Гэрлэгчид гэр бүлийн харилцаанд жендерийн эрх тэгш байдлыг хангаж гэж байгаа байхгүй юу. Яаж хэмжих гэж байгаа юм. Жендерийн эрх тэгш байдал нь тэгээд юу байх юм. Нийтийн эрх зүй нийтийн харилцаанд хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах гэдэг бол улс төрийн шийдлийн хамгийн чухал зүйл. Гэр бүлийн

дотор жендерийн эрх тэгш байдлыг хангахын тулд яах юм. Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн тоо тэнцүү байх юм уу. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэрийнхээ юу гэдэг юм айл хэсэгт адилхан сууна гэх юм уу. Гэр бүл дотор жендерийн тэгш байдал чинь яаж хангагдах гэж байгаа юм. Яаж хэмжигдэх гэж байгаа юм. Ард нь дахиад энэ юман дээр жоохон болгоомжтой хандахгүй бол улс төрийн намд ийм шаардлага тавих бол зөв. Төрийн байгууллагад ийм шаардлага тавих бол зөв. Нийтийн орчинд жендерийн тэгш эрхийг хангах шаардлага байх нь зөв. Гэр бүл дотор яаж шийдэх гэж байгаа юм. Нөгөө жендерийн хороо чинь ороод гэр бүлийг дотор нь ороод самрах юм биш биз дээ. Сандал суудлаас нь эхлээд ор дэрийг нь үзээд. Айн.

Одоо дахиад 13.8 дээр шүүх хүүхдийн асрамжийг шийдвэрлэхдээ гэж байгаад ёс суртахууны байдлыг харж үзнэ гэнэ гэр бүлийн. Гэр бүл чинь шашинлаг байна. Ёс уламжлалд итгэл үнэмшилтэй ханддаг төрлийн гэр бүл байна. Шинжлэх ухаанч гэр бүл байна. Урлаглаг гэр бүл байна. Гэр бүл янз бүр шүү дээ. Гэр бүлийн дотоод ёс суртахуун чинь бас өөр шүү. Ямар шашин шүтэж байгаагаасаа л шалтгаалаад эсвэл ямар уламжлалтай яс үндэстэн байгаагаасаа шалтгаалаад гэх мэтчилэн тэр ёс суртахууныг ойлгох ойлголтууд бас тэс өөр шүү дээ. Тэгээд шүүх энийг чинь яаж хэмжих юм. Зан суртахууны тухай ярьж байж магадгүй. Жоохон харгис, дээрэнгүй эсвэл юу гэдэг юм хүүхдийг үл тоодог, архи, тамхины хэрэглээ өндөртэй, хамааралтай..../минут дуусав/

Н.Учрал: Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Тэмүүжин гишүүнд бас баярлалаа. Гэр бүлийн тухай хуулийг улс төрийн нүдээр хараагүйд. Энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон. Монгол Улсын Үндсэн хуульд энэ гэр бүлийн харилцаатай холбоотой тусгагдсан заалтаа бас илүү хэрэгжүүлэх, хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүний үндсэн эрх, эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай хүмүүс адил тэгш эрхтэй. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд байдаг, Үндсэн хуульдаа байдаг энэ гэр бүлийн харилцааны асуудал үнэхээр бас сүүлийн үед тулгамдсан асуудал болчихсон байгаа. Үүнийг зохицуулах зорилгоор л ямар нэгэн улс төрийн өнцгөөр харж энэ Засгийн газар энэ хуулийн төслийг боловсруулаагүй. Гэр бүлд ямар нэгэн тийм улс төржих явц байхгүй гэдгийг бас эхний ээлжид хэлье.

Тэгэхээр жендерийн харилцааны асуудал дээр бидний уламжлалт нэг ойлголт байдаг шүү дээ. Гэрийн эзэн, өрх гэрийн тэргүүн эрэгтэй хүн бол илүү жоохон давуу эрхтэй. Эмэгтэй хүн бол гэрийн хүн, гал тогооны хүн тэгээд бас ер нь жоохон дутуу эрхтэй гэдэг тийм Монголчуудын уламжлалт хандлага байдаг. Энэ уламжлалт хандлага л байж болохгүй юм шүү. Цаашдаа эрэгтэй, эмэгтэй хоорондоо харилцан зөвшөөрөөд, тохиролцоод гэр бүл болсон бол тэгш эрхтэй байх ёстой. Адил үүрэгтэй байх ёстой. Эцэстээ гэр бүл салах юм бол бас яг адилхан эрхтэй гэр бүл салалт зохицуулах ёстой гэдэг асуудлыг л үндсэндээ тодотгож, энэ хуульд бас суулгаж өгсөн юм байна лээ. Энэ тал дээр манай ажлын хэсгээс нэмээд бас хариулаад өгчих нь зөв байх. Тэгэхгүй бол нөгөө гэр бүл салахдаа хүртэл юу гэдэг юм өрх гэрийн эзэн илүү орлого байл олдог байсан, 1 нь гэртээ ажилгүй байдаг байсан тийм болохоор гэдэг хандлага одоо хүртэл байдаг. Энийг л илүү юу гэдэг юм эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй. Гэр бүл болж, гэр бүл зохиохдоо ч тэгш эрхтэй, оролцоотой, үүрэг гүйцэтгэхдээ ч тэгш эрхтэй, эцэстээ салахдаа ч гэдэг юм уу гэр бүлийн 2 эрэгтэй, эмэгтэй хүмүүст тэгш эрхтэй байх ёстой гэдэг агуулгаар л оруулсан юм байна лээ. Энэ дээр бас манай ажлын хэсгээс нэмээд хариулаад өгчих.

Н.Учрал: Ажлын хэсгээс нэмж хариулъя. Мягмар дарга 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Тэмүүжин гишүүний асуултад тодруулж хариулъя. Гэр бүлийн хууль маань бас дан ганц Монгол Улсын иргэд хоорондын гэр бүлийн харилцааг зохицуулж байгаа хууль биш. Үүний бас үйлчлэлийн хүрээнд олон улсын шинжтэй гэр бүлийн харилцааны зохицуулалт бас орж ирж байгаа юм. Монгол Улсын иргэд гадаад иргэнтэй гэр бүл болох, түүнийгээ бүртгүүлэх гээд. Тэгэхээр энэ гэр бүлийн харилцаанд олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргийнхээ хүрээнд Монгол Улсын хуульд бол энэ жендерийн эрх тэгш байдал, гэрлэгчдийн эрх тэгш байдал гээд энэ зохицуулалтуудыг бол одоо байгаа зохицуулалтыг болон олон улсын гэрээ конвенцтой нийцүүлж энэ зохицуулалтыг оруулж ирж байгаа юм.

Тэгээд нөгөө талаасаа энийгээ гэр бүл цуцлахдаа хүртэл энэ гэр бүл дэх орчин нөхцөлийг нөхцөл байдлын шинжээч судлахдаа гэр бүлийн энэ гэрлэгчдийн хооронд зан харилцаа, бусад байдлаараа хүүхдийн асрамж, тэтгэлгийн асуудлыг шийдэхэд энэ зүйлүүдийг харгалзаж үзэж .../минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут өгье.

Н.Мягмар: Тэгэхээр энэ гэр бүлийг цуцлахад гэр бүлийн дотоод уур амьсгал, гэр бүлийн доторх гэрлэгчдийн бие биедээ хандах хандлага, хүүхдээ асран тэжээх, асрамж хамгаалалтыг шийдвэрлэхэд бол энэ дотоод гэр бүлийн орчин, соёлын болон энэ нөхцөл байдлуудыг харгалзаж үзэх нөхцөлийг шүүхэд бол олгосон ийм зохицуулалт орж ирсэн байгаа.

Н.Учрал: Тэмүүжин гишүүн тодруулна.

Х.Тэмүүжин: 3.1 дээр гэрлэлт хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй8 эмэгтэй 2-ын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ гээд нөгөө тэгш эрхийн чинь заалт бол байгаа байхгүй юу. Үнэхээр энэ сайн дурын үндсэн дээр гэрлэж байгаа 2 тэгш эрхтэй байх тухай зохицуулалт бол байна. 3.2 дээрээ жендерийн эрх тэгш гэдэг үг биччихээр энэ жендерийн бодлого чинь улс төрийн бодлого шүү дээ. Гэр бүл дотор улс төрийн бодлого оруулж ирж байгаа юм уу. Нийгэм дотор эрэгтэй, эмэгтэй хүйсийн ялгаварлал гараад байгаа учраас тэрийг шийдэхийн тулд улс төрийн бодлого гаргаж ирж байгаа байхгүй юу. Жендер гэж. Тэгсэн чинь та хэд одоо гэр бүл рүү оруулж ирж байгаа юм байна. Сая тайлбар хэллээ. Үгүй ээ, гэр бүл энэ 2 сайн дурын үндсэн дээр нийлж байгаа 2 чинь өөрсдөө хүсээд монгол уламжлалаа дагая гээд нөгөө /минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут Тэмүүжин гишүүнд өгье. Тэнд би нэг мэндчилгээ дэвшүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийн урилгаар Техник, технологийн их сургууль, Барилгын политехникийн коллежийн багш, оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцлаа. Та бүгдэд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилт хүсье. Баярлалаа.

Тэмүүжин гишүүн нэмэлт тодруулга.

Х.Тэмүүжин: 4 хүү төрүүлбэл дархан бэр гээд Монголын уламжлал байхгүй юу. Тэгэхээр энэ жендерийн бодлогоор чинь ядаж Сонгуулийн хууль шигээ 30 хувь

нь эмэгтэй байх ёстой гэж хуульчлах юм уу яах юм. Энэ бол нээрээ онигоо шүү. Гэр бүл доторх гэрлэгчдийн тэгш эрхийн тухай яриа бол зөв. Хүчирхийллээс ангид байх бол зөв. Эсвэл ингээд дахиад өөр юм яривал зөв байхгүй юу. Энэ дотор ингээд улс төрийн бодлого шиг гэр бүл дотор жендер гэдэг ийм юм босож ирвэл нөгөө сайн дурын үндсэн дээр тэгш эрхтэйгээр гээд нөгөө суурь зарчмаа та хэд маань нөгөө түр зуурын зохицуулалт гэдэг шиг өөр юм болгож хувирах гээд байгаа байхгүй юу.

2-т нь энэ дээр ёс суртахуун гэдэг үг хэрэглэж болохгүй шүү. Яагаад гэвэл ёс суртахуун гэдэг чинь өөрөө хамгийн субъектив бөгөөд олон талтай ойлголт байдаг. Зан суртахууны тухай ярьж болно. Архины хамааралтай .../минут дуусав/

Н.Учрал: Бямбацогт сайд хариулна.

С.Бямбацогт: Тэгэхээр жендер гэхээр эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа 50/50 тэнцүү байх ёстой гэдэг ойлголтоор та бас тайлбарлаад яах шиг байна. Тийм зүйл байхгүй. Ерөөсөө л тэгш эрхийн асуудал байж байгаа. Хуулийн нэр томьёоны тайлбар дээр 4.1.1 дээр жендер гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон түүхэн явцад хувьсан өөрчлөгдөх ойлголт үзэл хандлагыг хэлнэ гээд. Энд жендер гэдэг нь юм уу 3 хүүхэдтэй байх, адилхан 3, 3 хүүхэдтэй эрэгтэй, эмэгтэй хүүхэдтэй байх ёстой гэсэн шүү томьёолол байхгүй. Ерөөсөө эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй байх ёстой шүү гэдгийг л томьёолж тодорхойлж өгсөн байгаа. Энийг та бас ингээд ойлгоод аваарай. Битгий мушгиж тайлбарлаарай гэдгийг бас танд хэлье.

Н.Учрал: Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуулт асууна.

Н.Алтаншагай: Гэр бүлийн тухай хууль шинэчлэгдээд орж ирж байна. 1999 онд батлагдсан хууль. 8 удаагийн шинэчлэлт өөрчлөлт хийгдсэн гэж байгаа боловч салбарын харилцааг зохицуулсан буюу бусад хуулийн шинэчлэлийг даган өөрчлөлт оруулсан ийм хууль байгаа. Энэ хуульдаа Улсын Их Хурал 5 удаагийн парламентаар ажлын хэсэг байгуулагдаад, гар дүрж өөрчлөлт хийж чадаагүй. Өнөөдөр ингээд орж ирж байгаад бас баяртай байна. Тэгээд шинээр бий болж байгаа нийгмийн зарим харилцаа гэсэн асуудал сүүлийн үед нэлээн хүчтэй яригдах болсон. Тэр дотроо бол тээгч эх, үр шилжүүлэн суулгах, өв залгамжлалын тухай гээд энэ заалтуудыг яг энэ хууль дээр нарийн тусгагдсан зүйлүүд бий юу.

Мөн гишүүд их ярьж байгаа. Цус ойртолттой холбоотой асуудал бас нэлээн сэтгэл эмзэглүүлэн асуудлууд байгаа юм. Тэгэхээр энэ хууль дээрээ яг тусгайлан зааж, гэр бүл бологсод нь ургийн бичиг буюу угийн бичгийг хөтөлнө гэсэн ийм заалтыг бас зайлшгүй оруулах шаардлагатай юм болов уу гэсэн ийм бас зүйл байна.

Энэ тээгч эхийг бол бас их онцгойлон авч үзэх нэн шаардлагатай юм билээ. Одоо бол журмаар зохицуулагдаж байгаа. 2018 оны эрүүл мэндийн сайдын гаргасан журмаар зохицуулагдаж байгаа. Тээгч эх, донор, өв залгамжлалын энэ асуудлуудаа журмаар зохицуулна гэж. Тэгэхээр энэ хуульдаа бүр нарийвчлаад оруулж өгөх нь бас зөв байх.

Европын болон Азийн орнууд харилцан адилгүй байна. Энэ тээгч эх дээ. Европын зарим орнууд бол энэ тээгч эхийн татвар өндөр. Төсөв бүрдүүлэхэд хүртэл орлого оруулдаг ийм заалтууд байсан. 2024 оны 12 сараас Европын зарим орнууд

энэ тээгч эхийг хуулиар хориглож байгаа юм. Тэгэхээр энэ дээр бас яг ямар байр суурьтай байгаа вэ. Хууль боловсруулагчид маань. Энэ дээр бас тайлбар авъя. Эцэг эх, гэр бүл болж байгаа хосуудад энэ соён гэгээрүүлэх, эцэг эхийн яг ариун үүргийг бас ямар байхыг бас хуульчилдаг юм уу, зааж оруулдаг юм уу уламжлалаараа л явдаг шүү дээ. Энэ дээр яг ийм нарийн зохицуулалт орж ирсэн үү. Энэ дээр тайлбар авъя.

Н.Учрал: Бямбацогт сайд хариулна. Маш чухал асуулт асууж байна. Тэгээд үнэхээр сүүлийн асуултаас нь эхлээд хариулахад бид нар чинь нөгөө уламжлалт зан заншлаараа бол аав ээж удам судар үзээд, тэгээд бас хоорондоо танилцаад нэлээн үерхэж байгаад тэгээд гэр бүл болдог. Сүүлийн үед нийгмийн хөгжлөө дагаад бас гэр бүл болохдоо ерөөсөө тэгээд л оюутан байхдаа, 10 жилд сурч байхдаа тэгээд дурлаад, шохоорхоод гэр бүл болчихдог. Үүнээсээ болоод юу гэдэг юм гэр бүл салалт нэмэгдэх барих гээд олон асуудал үүсдэг. Тийм болохоор бас ингээд өөрөө хүн болж төлөвшиж, иргэн болж чадаагүй байж байгаад бараг хүүхдээрээ шахуу гэр бүл болоод, эцэстээ үр хүүхэдтэй болоод гэр бүлийн эцэг эх байх үүргээ биелүүлэхэд өөрийнх нь тухайн амьдралын туршлага, мэдлэг чадвар дутаад асуудал үүсдэг. Үүнээс болж гэр бүл салдаг их олон тохиолдлууд байдаг юм байна лээ.

Тэгээд энийг бас зохицуулах ёстой гэдэг үүднээс гэр бүл болох гэж байгаа хүмүүс анх удаа гэрлэж байгаа бол заавал бас гэр бүл зохиох, гэр бүл болоход эцэг эхийн үүрэг ямар байх юм. Гэр бүлийн эхнэр нөхрийн бас үүрэг, оролцоо ямар үүрэгтэй байх юм. Эрхтэй байх юм гэдэг талаар бас ингээд гэр бүлийн болох сургалтад хамруулдаг байхаар энэ хуульд бас тусгаж өгсөн байгаа. Тийм болохоор бас энийг Гэр бүлийн тухай хуулийн гол зохицуулалт нь бол хэвээрээ үлдсэн гэдгийг 1 дүгээрт хэлье.

2 дугаарт нь нөгөө амьдрал дээр үр хүүхэд төрүүлэх боломжгүй, яах аргагүй нөгөө эмнэлгийн үзлэгээр тогтоогддог ийм тогтоогдсон эмэгтэйчүүд маань хүүхэдтэй болохыг хүсдэг. Нөхөр нь бас хүснэ, өөрөө хүснэ. Энэ үед бас тээгч эхийг ашиглах явдал бол сүүлийн үед дэлхий нийтээрээ Монголд ч гэсэн бас нэлээд бий болж байгаа. Энийг зохицуулсан харилцаа байхгүйгээс болоод тухайн үедээ ингээд тохироод тээгч эх болоод хүүхэд төрүүлчихдэг. Дараад нь төрснийх нь дараа миний хүүхэд, алиных нь хүүхэд вэ гээд бөөн асуудал үүсдэг. Гэр бүлийн хооронд. Гэр бүл дотор болон тээгч эхийн хооронд. Тэгээд үүнийг гэрээгээр зохицуулна. Гэрээгээр зохицуулсан харилцааных нь хүрээнд энэ асуудлыг шийднэ гэдэг байдлаар бас хуулийн төсөлд бас тусгаж өгсөн байгаа юм байна лээ. Тийм болохоор бол гэрээгээр зохицуулаад, гэрээгээр үндсэндээ тэр захиалж байгаа тээгч эхэд тодорхой харилцаан дээр төлбөр байдаг юм уу, юу байдаг юм, тохироо хийгээд, тэр тохирооныхоо хүрээнд л үр хүүхдээ өөрийн албан ёсны үр хүүхэд болгох боломжтой байхаар энэ хууль дээр зохицуулалт сууж өгсөн байгаа гэдгийг бас танд бас хэлье. Нэмээд манай ажлын хэсгээс хариулах бол бас хариулчхаарай.

Н.Учрал: Ажлын хэсэг нэмж хариулъя. Мягмар дарга 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Алтаншагай гишүүний асуултад тодруулж, нэмэлтээр хариулъя. Гэр бүлийн хууль дээр бол тэр удмын сан, угийн бичиг хөтлөхтэй холбоотой энэ зохицуулалтыг гэрлэгчдийн эрх, үүргийн хэсэгт оруулж өгсөн байж байгаа. Угийн бичгээ хөтлөх, түүнийгээ өвлүүлэх гэдэг энэ агуулгаар орж ирсэн байж байгаа. Мэдээж бол ургийн овгийн асуудлыг бас одоогийн гэр бүлийн бүртгэлийн хуулиар

Улсын бүртгэлийн ерөнхий газар дээр ургийн овог болон эцэг эх өөрийн нэрээ бүртгэж явдаг энэ лавлагаа мэдээллийг гаргаж явдаг. Ургийн овгийг цаашид хөтлөх энэ асуултыг бол гэрлэгчдийн эрх үүрэгт оруулж өгсөн байгаа. Нэмэлтээр хэлэхэд бол ийм байна. Тэгээд тээгч эх болон бусад асуудлыг сайд хариулчихсан учраас .../минут дуусав/

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн урилгаар хүүхэд залууст эх оронч үзэл, эв нэгдлийг түгээн дэлгэрүүлэх зорилготой “Зэв” холбооны гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд ажил хөдөлмөрийн өндөр амжилт хүсье. Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууна.

М.Мандхай: Энэ өдрийн мэндийг хүргэе. Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулга бол яг өмнө нь одоо мөрдөж байгаа хуультай харьцуулах юм бол тодорхой түвшинд бол сайжирч орж ирсэн байна гэж харсан. Тэгээд энэ дээр 5 асуулт байна.

Хуулийн 24.3 дээр хүүхдийн эцэг эх нь хэн болох нь тодорхойгүй бол асрамждаа авч байгаа этгээд эсвэл улсын бүртгэлийн байгууллага хүүхдэд нөгөө нэр овог өгч байгаа энэ жишиг бол ерөнхийдөө хэрэв хүүхэд асрамжийн газар луу явах юм бол асрамжийн газрын байгууллага нь өөрөө мэдэж нэр өгдөг. Ихэнх тохиолдолд юу гэдэг юм, асрамжийн байгууллагад Олдох гэдэг нэр өгдөг. Ингээд дараа нь тэр хүүхэд өөрөө том хүн болоод хүүхэдтэй болоход овоглохдоо “Олдох”-ын тэр, “Олдох”-ын гэдэг овгоор овоглоод яваад байдаг. Энийг бол юу гэж харж байгаа вэ гэхээр энэ “Олдох”-ын гэж нэр бол өөрөө нэрлэсэн нь 1 дүгээрт бас хүүхдийн эрхийг зөрчсөн ийм үйлдэл бол гараад байгаа. Тэгэхээр энэ нэр олгохтой холбоотой асуудлыг яаж илүү хүний эрхийн мэдрэмжтэй байдлаар зохицуулж өгөх вэ. Энэ дээр тодорхой хэмжээний хуулийн зохицуулалт байгаа юу гэдгийг асуумаар байна.

2 дугаарт энэ бол түгээмэл тохиолдол. Эцэг эх нь хамтран амьдарч байгаа хэдий ч гэсэн бүртгүүлээгүй тохиолдлууд их байдаг. Шинэ гэр бүлийн хувьд бол бүртгүүлж амжаагүй байж байтал хүүхэд нь гараад ирдэг. Ингээд яадаг вэ гэхээр эхийнх нь нэрээр нь овоглоод явчихдаг. Тэгэхээр одоо энэ гэрлэлтээ батлуулах өөрөө процесс бол сайн дурын шинжтэй. Гэхдээ энэ хүүхдээ эцгээр нь овоглодог боломжийг бий болгож болдоггүй юм уу. Яагаад ингээд автоматаар ээжээр нь овоглодог. Магадгүй зарим тохиолдолд 2 дахь удаагийн гэр бүл боллоо гэж бодоход гэрлүүлэхээ яараагүй байх тохиолдлууд бас байгаа. Тэгэхээр энэ дээр эцгээр нь овоглодог ийм зохицуулалт механизм байж болдоггүй юм уу гэдгийг бас асуумаар байна.

3-д нь болохоор 9.5 дээр энэ хуулийн 9.3.4-д заасан угийн бичиг хөтлөх энэ журам дээр Соёлын яам энэ асуудал эрхлэх дээр нь орсон байгаад байгаа юм. Энэ Соёлын яам угийн бичигтэй яг ямар хамаатай юм бол. Яагаад Соёлын яамыг оруулсан юм бол гэдгийг тодруулж өгөөч.

Тээгч эхтэй холбоотой бас асуулт байгаад байгаа юм. Энэ тээгч эх хэрэв захиалагч талын хооронд байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус болох тохиолдол гарахыг үгүйсгэхгүй. Эсвэл маргаантай ийм тохиолдолд шүүх ямар зарчмаар шийдвэр гаргах вэ. Магадгүй гэрээний эрх чөлөө юу эсвэл хүүхдийн эрх талдаа юу, тээгч эхийн эрх юм уу. Алийг нь дээдлэх вэ гэдэг ийм асуулт гарч ирж байгаа юм. Тэгэхээр хүүхэд төрөлхийн хэрэв гажигтай тохиолдолд яах вэ. Хөгжлийн

бэрхшээлтэй төрвөл захиалагч тал хүүхдээсээ татгалзах эрх байгаа юу. Тээгч эх эсвэл хүүхэд хэний хариуцлагад нь үлдэх вэ гэдэг ийм тодорхойгүй асуудал бол байгаа учраас энэ дээр хууль хэрхэн зохицуулж байгаа вэ.

Хамтран амьдрагчийн хувьд бол 4 нөхцөл бол бүгд биелсэн юм байна гэж харж байгаа. Хэн нь ч өөр хүнтэй гэр бүл болоогүй, доод тал нь 5 жил тогтмол хамт амьдарсан байх ч гэдэг юм уу ингээд 4 нөхцөлүүдийг бол тусгаж өгсөн байна. Гэхдээ зарим тохиолдолд магадгүй 2 дахь юм уу, 3 дахь гэрлэхээд, тэгээд ерөнхийдөө гэрлэхгүй ч гэсэн хоёулаа хамтын амьдралыг бүтээгээд ингээд насны эцсийг хамтдаа байя гээд шийдвэр гаргаад явсан. 1 нь ингээд нас барлаа гэж бодъё. Тэгэхэд өмчлөлийн асуудал байгаа. Өв залгамжлалын .../минут дуусав/

Н.Учрал: Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Мандхай гишүүн Олдох нэртэй чинь бас гоё нэр шүү дээ. Олдох нэр чинь. Тэгээд хүүхэд олдохгүй олон жил болж байгаад, хүүхэд олоод олдохоороо тэгээд бас Олдох гээд өгсөн байж болно. Олон янзын шалтгаанаар эцэг эхчүүд бол хүүхдүүддээ нэр өгдөг. Зөвхөн юу гэдэг юм эцэг эх нь тогтоогдохгүй олдсон хүмүүсийг “Олдох” нэртэй гэж бас арай ярьж болохгүй байх. Хэрвээ тэгэх юм бол “Олдох” нэртэй олон хүмүүс гомдож магадгүй. Тийм болохоор тэр эцэг эх нь олдохгүй байж байгаад тэгээд энэ дээр нэрээ солих энэ эрх нь 16 нас хүртлээ нэрээ 1 удаа солих эрх нь хүүхдэд байж байгаа. Мөн эцэг эхчүүд нь бас байгаа. Эцэг эхчүүд нь. Тийм болохоор үүний дагуу юу гэдэг юм нэрээ солих ийм боломж бас байдаг гэдгийг бас танд хэлъе.

Мөн тэр бас эхээр нь овоглогдгийг болих дээр ч гэсэн одоо бас хуулиар зохицуулагдсан. Иргэний бүртгэлийн тухай хуулиар зохицуулагдчихсан байдаг. Энэ дээр Иргэний бүртгэлийн тухай хуулийн гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг эх тус тусдаа өргөдлөө гаргаагүй, эцэг тогтоосон тухай эрх бүхий байгууллагын шийдвэр байхгүй эсвэл эцэг эх хэн нэгний гэрлэлт дуусгавар болоогүй бол хүүхдийн эхийн овог нэрээр бүртгэл бүртгэнэ гэж бичсэн байгаа болохоос ерөнхийдөө хүүхдээ хэнээр овоглуулах нь үндсэндээ бол болохоор ээж аавынх нь, өвөө эмээгийнх нь бас эрх байдаг. Энэ бол хуулиар бас зохицуулагдсан байгаа. Энэ бол нээлттэй байгаа шүү гэдгийг бас хэлъе.

Тэр тээгч эхтэй холбоотой тэр, соёлын өвтэй холбоотой асуудлууд дээр манай ажлын хэсгийнхэн маань бас нэмээд хариулчих уу.

Н.Учрал: Тээгч эхийг ажлын хэсэг хариулсан нь дээр байх. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Мандхай гишүүний асуултад хариулъя. Донорын тухай одоогийн хүчин төгөлдөр хуулиар бол нөхөн үржихүйн туслах арга болох донор бэлгийн эсийг ашиглах болон тээгч эхийн асуудлыг зохицуулсан байж байгаа. Энийг одоогийн хүчин төгөлдөр хуулиар Эрүүл мэндийн сайд гэрээний загвар, холбогдох журмыг нь бол баталчихсан. Гэр бүлийн хуулийн одоогийн бидний оруулж ирж байгаа шинэчилсэн найруулгаар энэ хуулийн дагуу эцэг эх нь хэн байх юм бэ гэдгийг нь тодорхой болгож өгч байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол захиалагч буюу гэрээ байгуулсан этгээд маань хүүхдийн эцэг эх байна. Тээж байгаа төрүүлсэн эх бол эх нь байх гэдэг юм уу. Донор, бэлгийн эсийн эцэг байна гэдэг нэхэмжлэл гаргахгүй шүү. Энийг захиалсан этгээд нь эцэг, эх байна гэдгийг нь тодорхой хуульчилж өгч

байгаа. Нөгөө талаасаа эм бэлгийн эсээ донор болгосон энэ хүмүүс .../минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут Мягмар дарга.

Н.Мягмар: Нөгөө талаасаа энэ захиалж авсан хүн маань төрснийх нь дараа тэр хүүхдийг би авахгүй гэх эерэг нэхэмжлэл гаргах гэдэг юм уу ийм хүсэлт гаргах ийм боломж байхгүй шүү гэдгийг хориглож өгч байгаагаар энэ Гэр бүлийн хууль дээр тээгч эх болон донорын бэлгийн эстэй холбоотой зохицуулалтыг зохицуулж өгч байгаа.

Угийн бичгийн асуудал дээр угийн бичиг бол өөрөө соёлын биет бус өвдөө ордог учраас энийг хөтлөхтэй холбоотой журам дээр Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн маань бол хамтран батлахаар ийм эрхийг оруулж ирсэн байж байгаа.

Н.Учрал: Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Би хариултаа дахиад авъя. Сүүлийн асуултад хариулаагүй байна. Хэрэв хамтран амьдрагч амьдраад өв залгамжлалын эрх байхгүйгээр хуульд тусгасан байсан. Тэгэхээр энэ асуудлыг яах вэ. Хэрэв үнэхээр 2 дахь амьдралаараа хамтдаа амьдраад, тэгэхдээ гэрлэхгүйгээр шийдээд, ингээд насны эцсийг хоёулаа барна гээд амьдарлаа гэж бодъё. Магадгүй 10, 20 жилийн дараа ч гэдэг юм уу, 30 жилийн дараа 1 нь өнгөрөхөд өв залгамжлалын асуудлын эрх энд тусгагдаагүй байна. Тэгэхээр ийм тохиолдол маргаан зөндөө гарна. Тэгэхээр энийг яах вэ гэдэг асуудлыг магадгүй би хуульд нарийн зохицуулалтыг нь бас хараагүй байж магадгүй. Энэ дээр бас хариулт авчихъя.

2 дугаарт түрүүн тээгч эхийн асуудал. Гэрээгээр хэрэв тээгч эхээс гарсан хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй эсвэл төрөлхийн гажигтай ч гэдэг юм уу хүүхэд гарлаа гэж бодоод захиалагч тал өөрөө татгалзах ийм.../минут дуусав/

Н.Учрал: Ажлын хэсэг хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Энэ гэрээн дээрээ бол юу гэдэг юм хүүхдийг тээж байх үедээ янз бүрийн хөгжлийн бэрхшээлтэй болох нөхцөл байдлыг үгүйсгэхгүй байх ийм үүргүүдийг бол гэрээндээ тусгаж явах юм. Зүгээр эрүүл мэндийн шалтгаанаар янз бүрийн юу гэдэг юм эсийн өөрчлөлт гэх юм уу тийм зүйлийг гэрээ байгуулахаасаа өмнө шинжилгээ судалгаагаараа энэ донорынхоо хуулиараа зохицуулагдаад, тэр гэрээ дээрээ талуудад хүлээх үүрэг, хариуцлагыг бол зохицуулаад өгчихсөн явж байгаа.

Юуны хувьд хамтран амьдарч байгаад өв залгамжлалын асуудал бол хамаарахгүй гэсэн энэ зохицуулалтын хувьд яах вэ, гэрлэлттэй адилтгах харилцаан дээр тодорхой 5 жилийн хугацаанд хамтран амьдарсан, өөр хүнтэй гэрлэлт бүртгүүлээгүй байх энэ тэр гэсэн энэ 4 нөхцөлийг хангасан тохиолдолд хамтран амьдрах хугацаанд дундаа үүсгэсэн хөрөнгийн асуудал дээр эд хөрөнгийн маргаан гарах тохиолдолд энийг гэрлэлттэй адилтгах харилцаа гэж үзэж дундын эд хөрөнгийг хуваах асуудал дээр .../минут дуусав/

Н.Учрал: Хариулт болсон уу. 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Гэрлэлттэй адилтгах харилцаан дээр яг энэ хамтын амьдралын хугацаандаа үүссэн дундын маргаан дээр нь бол гэр бүлийн дагнасан шүүх маань энэ хөрөнгийн маргааныг нь бол шийднэ гэсэн явж байгаа. Тэрнээсээ өмнө өөрсдийн хуваарьт хөрөнгөөрөө бий болгосон хөрөнгө, энийгээ өв залгамжлалаар үлдээх асуудал бол иргэний ердийн шүүхийнхээ журмаар энэ шийдвэрлэгдээд явах юм байгаа юм.

Н.Учрал: Бадарчийн Хэрлэн гишүүн байхгүй байна. Сархатын Зулпхар гишүүн байхгүй байна. Лутаагийн Энхнасан гишүүн асуулт асууна.

Л.Энхнасан: Баярлалаа. Энэ өдрийн амар амгаланг айлтгая. Шинэ төслийг дэмжиж байгаа. Төсөлд бол гэрлэлт, гэрлэлтийн гэрээ, гэрлэлт цуцлах, үрчлэлт, нөхөн үржихүй гээд хүүхдийн эрх, гэр бүлийн харилцаа гээд олон асуудлууд бол орчин цагийн гэр бүл нийгмийн харилцаанд нийцүүлэн нарийн нарийвчлан зохицуулсан байгаа. 2, 3 асуулт байна.

Энэ шинэ хуулийн төсөл цөөнхийн нийтлэг бус үндэсний цөөнхийн эс үгүй бол ЛГБТ-ийн гэх мэт албан бус бүлгүүдийн эрхийг тусгайлан хамгаалсан ийм заалтууд тусгасан эсэх нь жоохон бүрхэг байгаад байна. Энд ямар заалтууд тусгагдсан бэ.

2 дугаарт хүүхэд үрчлэх боломжтой гэр бүл гээд энэ Монгол Улсын хуулийн дагуу бүртгэлтэй байх гэж заасан байна. Харин энэ нас нь ер нь заагдсан байгаа юм уу. Жишээлбэл нөгөө олон улсад бол 25-50 насны гэр бүл гэж заасан байдаг. Энэ насны хязгаарлалтыг зааж болох уу. Яагаад гэвэл энэ бас нөгөө хүүхдийн тэжээгчээ алдсан тэтгэмжийг бас авах зориуд авахаар ингэж гэр бүл бас хүүхэд үрчилж авдаг ийм тохиолдлууд их гардаг.

3 дугаарт нөгөө сая шүүх дээр нэг ийм тохиолдол гарсан байгаа. Шүүх дээр 123.3 болон 129.4-д гээд үндэслэн шийдвэр гаргасан байгаа. Тэгээд энэ 129.4-ийг хэрэглэхдээ эхнэрийн хөдөлмөр оролцоог 0-3 насны хүүхэд асрах чөлөөтэй байсныг харгалзаж түүнд оногдох хөрөнгийн хэмжээг багасгасан. Гэтэл энэ 129.3-ыг баримталсан боловч эхийн асрамжид үлдсэн 2 хүүхдэд хөрөнгөөс нь хувь олгоогүй. Ер нь яах вэ хүүхдийн ашиг сонирхлыг харгалзах учир хөрөнгөөс нь хувь олгож өгөөч ээ гээд гомдол гаргаад бараагүй гэж байгаа юм. Тэгэхээр ер нь 0-3 настай хүүхдээ асарч байгаа эхийн хөдөлмөрийг оролцоог яаж үнэлж байгаа вэ. Ер нь яаж үнэлнэ гэж бодож байгаа вэ. Ийм 3 асуулт байна. Тэгээд тодруулъя.

Н.Учрал: Ажлын хэсгээс хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар. 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Энхнасан гишүүний асуултад хариулъя. ЛГБТ зэрэг хүмүүсийн асуудалтай холбоотой асуултад энэ Гэр бүлийн хууль бол Монгол Улсын Үндсэн хуульд зааснаараа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийн сайн дурын харилцааны үндсэн дээр бий болохоор ингэж зохицуулсан байдаг. Тийм учраас энэ Үндсэн хуулийн зарчимдаа нийцүүлж Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулга, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар ч гэсэн эрэгтэй, эмэгтэй гэдэг энэ хүйсийн, эсрэг хүйсийн гэрлэлтийг хүлээн зөвшөөрч байгаа. Бусад энэ чиглэлийн гэдэг юм уу сүүлийн үеийн хүмүүсийн практикт гардаг, олон улсад бас гарч байгаа энэ зүйлээр хүйс солиулах асуудал гардаг. Тэгэхээр хэрвээ мэс заслын аргаар энэ хүйс солиулсан тохиолдолд одоогийн хуулиар бол гэр бүлийг дуусгавар болгох асуудлыг бол бүртгэхдээ заавал шүүхээр шийдвэрлэсний дараа бүртгэгддэг байгаа бол энэ

шинэчилсэн найруулгаар бид нар Үндсэн хуулийнхаа агуулга, үзэл баримтлалд нийцүүлээд автоматаар дуусгавар болох энэ зохицуулалтыг хийж өгч байгаа.

Өөрөөр хэлэх юм эрүүл мэндийн мэс заслын аргаараа хүйсээ солиулсан гэдгийг эмнэлгийн лавлагаа, мэс заслын тодорхойлолтоор нь бол ингэж бүртгэх ийм бололцоо бүрдэж байгаа.

Хүүхэд үрчлэлттэй холбоотой зүйл дээр бол яах аргагүй Энхнасан гишүүний асууж байгаа асуулттай холбоотой бас тодорхой зорилго, халамж авах зорилгоор ч гэдэг юм уу хүүхдээ өндөр настай хүнд үрчлүүлээд, тэр хүн нь нас барсан тохиолдолд халамж авдаг ийм бас буруу жишиг, практик байгаа нь үнэн. Тэгээд энийг захиргааны журмаар хүүхэд үрчлэлтийг шийддэг байсныг шинэчилсэн найруулгаар бол шүүх шийддэг болж байгаа. Тийм учраас үрчлүүлэх үндэслэл хэрэгцээ шаардлага нь юу байна. Үрчлэн авах гэж байгаа хүмүүсийн нөхцөл байдал юу байна гэдэг энэ асуудлаар бол Засаг даргын дэргэдэх үрчлэлтийн орон тооны бус зөвлөл гэж энэ хуулийн зохицуулалтаар орж ирж байгаа. Энэ зөвлөлийн дүгнэлтийг үндэслэж шүүх шийдвэрлэх энэ боломжийг оруулж ирж байгаа. Тэгэхээр энэ зохицуулалт үйлчлээд эхлэх юм бол саяын буруу жишиг, зүйлүүд бас таслан зогсоогдох байх гэж ингэж харж байгаа.

0-3 насны хүүхдийн тэжээж тэтгэж байгаа эхчүүдтэй холбоотой асуудал дээр хэлэхэд ер нь яах вэ манай хуулиар 0-3 насны хүүхэдтэй ийм тохиолдолд гэр бүлээ цуцлуулахгүй байх энэ зохицуулалтуудыг оруулж өгч байгаа. Зүгээр яг эхийг тэтгэх, урамшуулах гэдэг юм уу үүнтэй холбоотой асуудал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулж байгаа Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль дээр энэ зохицуулагдаж орж ирэх юм байгаа юм.

Н.Учрал: Энхнасан гишүүн тодруулна.

Л.Энхнасан: Тэгэхээр тэр цөөнхийн гэр бүл бол хүүхэд үрчлэх, эсвэл нөхөн үржих эрх бол ямар нэгэн байдлаар тусгагдаагүй гэж ойлгож болох уу. Эсвэл энэ хязгаарласан байгаа юм уу.

Н.Учрал: Ажлын хэсэг хариулна.

О.Оюунзул: Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг гүйцэтгэгч Оюунзул. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар зөвхөн эрэгтэй, эмэгтэй эсрэг хүйстний сайн дур, тэгш эрхийн чөлөөтэй харилцаанд үндэслэн гэр бүлийг бүртгэдэг. Тэгэхээр Гэр бүлийн тухай хуулиар бол зөвхөн ижил хүйстний биш эсрэг хүйстний гэрлэгчдийн харилцааг бүртгэх, гэрлэлт дуусгавар болох, цуцлах, хүүхдийн тэтгэлэг, асрамж, үрчлэлт, асран хамгаалалт, харгалзан дэмжлэг гэсэн эдгээр харилцааг бол зохицуулах ийм хувийн эрх зүйн шинжтэй хууль байгаа юм.

Харин Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам яг энэ бэлгийн цөөнх дээр ямар бодлого барих вэ, дээрээс нь энэ манай хувийн эрх зүйн чиглэлээр боловсруулж байгаа Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөс гадна Гэр бүлийн хөгжлийг дэмжих .../минут дуусав/

Н.Учрал: 1 минут өгье.

О.Оюунзул: Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр зөвхөн хувийн эрх зүйн түрүүн дурдсан харилцааг зохицуулж байгаа. Харин гэр бүлийн хөгжлийг төрөөс яаж дэмжих вэ, боловсрол олгох, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, community center буюу гэр бүлд чиглэсэн бүхий л мэдээллийг өгөх, дээрээс нь төрөөс орон сууцын зээлд тэргүүн ээлжид хамруулах, татварын хөнгөлөлт үзүүлэх, мөнгөн дэмжлэгүүд үзүүлэх зэрэг энэхүү харилцааг Гэр бүл хөгжлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслөөр зохицуулах бөгөөд энэ хуулийн төслийг бол Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас одоогоор боловсруулж байгаа. Тэгэхээр манай хуулийн төслөөр яг гэрлэлт бүртгэх харилцаа, гэрлэлт цуцлах харилцаа, тэгээд гэрлэлт нь бол Монгол Улсдаа ижил хүйсийн гэрлэлтийг бол хүлээн зөвшөөрөхгүй байгаа юм.

Н.Учрал: Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Асуултуудыг бас давхцуулахгүйгээр асууя. Энэ хуулийг хэлэлцэхийг бол дэмжиж байгаа. Энэ техник технологи бас давуу талууд авчирч байгаа. Энэ эргээд бас шинжлэх ухааны ололтууд бас энэ гэр бүлийн харилцаан дээр бас нэлээн олон өөрчлөлтийг авчирч байна. Хүйс солиулснаас бас гэр бүлийн харилцаан дээр үр дагаврууд авчирч байна. Тээгч эхийн асуудал ч гэдэг юм уу, маш олон зүйлүүд дээр бас энэ Гэр бүлийн хуулийг шинэчлэх хэрэгцээ шаардлага нийгэмд бол үүссэн. Энийг бол бид хүлээн зөвшөөрөх ёстой.

2 дугаарт яах вэ, энэ хуулийг харахаар эцэг эх байх эрхийг хасах. Ингэсэн тохиолдолд мэдээж ах дүү нарт нь үрчлүүлэх, магадгүй асралт гэр бүлд байлгах, асрамжийн газарт хүргүүлэх ч байдаг юм уу ийм үе шаттай харилцаанууд байна. Нөгөө талдаа бас гэрлэлтээ бүртгүүлэх гэж байгаа хүмүүс сургалтад суух ч гэдэг юм уу энэ бүх асуудлуудын зардал, энийг зохион байгуулах, удирдлага зохион байгуулалт, менежментийн асуудлуудыг хариуцах асуудал энэ хууль дээр ерөөсөө тодорхой харагдахгүй байгаа. Сая Хууль зүй, дотоод хэргийн яамны хэлтсийн даргын хариулт бол яг энэ буюу тэр Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль яаралтай орж ирэх ёстой юм. Тэгэхээр энэ Гэр бүлийн хуулийг хэлэлцэхдээ энэ Гэр бүлийн хөгжлийг дэмжих хуультай бол зэрэгцүүлж яг бас авч явах ёстой гэдэг зүйлийг 1 дүгээрт энд хэлье.

2 дугаарт яах вэ, би энэ Гэр бүлийн хуулийг хэлэлцэж байгаа дээр нэг олзуурхаж байгаа зүйл бол ургийн овгийн асуудлыг шийдье. Энэ ургийн овгийн асуудлыг Монголчууд ерөөсөө ойлгодоггүй юм байна. Энэ ерөөсөө ингээд 1 гаднын иргэнийг Монгол хүн болгох гээд байгаа ч юм шиг ингэж ойлгодог зүйл юм байна гэж ойлгоод байгаа боловч энэ чинь эцэг эхийн нэрээс өөр. Энэ ургийн овгийн анхнаасаа хэрэглэж ирсэн түүх нь ерөөсөө л цус ойртолтоос сэргийлэх. Тэгэхээр энэ цус ойртолтоос урьдчилан сэргийлэх ажил дээр Монголын түүх уламжлал бол үнэхээр хосгүй байсан нь мэдэгдээд байгаа юм. Тэгээд 1923 онд тухайн үеийн шийдвэрээр ургийн овгийг хэрэглэхийг хориглоод, эцгийн нэрийг хэрэглэхээр болсон. Үүнээс шалтгаалаад өнөөдөр Монгол Улсад цус ойртолт маш өндөр түвшинд хүрсэн. Гишүүд ээ, би асуулт асуугаад байгаа юм. Давхцахаар их хэцүү байна.

Тэгээд 2 дугаарт өнөөдөр Монгол Улсын 21 аймаг, 330 сумд, ялангуяа сумын түвшинд, багийн түвшинд энд тэнд амьдарч байгаа хүмүүсийн 85 орчим хувь нь 3 дахь, 4 дэх үе дээрээ хоорондоо гэрлэж байна. Энэ цус ойртолт чинь өөрөө эргээд энэ хавдрын суурь болдог юм байна. Энэ хавдар залуужаад байгаагийн шалтгаан

чинь цус ойртолт юм байна. Дээрээс нь оюуны хомсдол болон маш олон ургийн гажгийн өөрчлөлтүүд чинь цус ойртолтоос болж байгаа юм. Тийм учраас энэ ургийг овгийг өөрчлөх асуудлыг цэгцтэй, яг архивын баримт дээр тулгуурлаж өөрчлөх асуудлыг төр зохион байгуулъя гэж байгаа юм. Би яагаад ингэж хэлж байна гэхээр энэ хүн амын тооллогын материалууд төрд байгаа. 1929, 1933, 1944, 1956, 1988, 2000, 2010 онд хүн амын тооллого хийсэн. Сая 2025 онд Польш Улсаас авч ирсэн баримт ирлээ. Өөрөөр хэлэх юм бол Монгол Улсын хүн амын 1915 онд хийсэн тооллого олдсон. Энэ тооллогын баримт дээр маш нарийн деталь буюу тухайн айл өрхийг бүр гэртэй, гэргүй, ямар аж ахуй эрхэлдэг, жилдээ хэчнээн тонн хадлан бэлтгэдэг, ер нь статусын хувьд ямар мэргэжилтэй хүмүүс байсан юм. Гаднын хошуунаас ирсэн үү, үгүй юу буюу яг удам судрын хувьд хэн бэ гэдэг зүйлийг ч тодруулж болох хэмжээний ийм материалыг Польш улсаас авчирч Монгол Улсын түүхийн зарим эрдэмтэд хэвлүүлсэн байна. 9 боть ном.

Тийм учраас төр засгаас энэ асуудлуудыг менежментийн хувьд зохион байгуулаад, ураг төрлөөрөө нэгдээд, энэ ургийн овгоо шинэчлэх асуудал дээр ингэж тусгайлан бас хялбаршуулсан байдлаар тогтоогоод өгөх энэ бололцоог нь бүрдүүлж өгөх ёстой юм. Тэгэхээр энэ асуудлуудыг уг нь дагаж мөрдөх журмын хууль болон зохион байгуулалтын хуульд шийдмээр байгаа. Архивын ерөнхий газар дээр материалууд чинь ерөөсөө 20 хувь цахимжсан байна. Тийм учраас энэ хүн амын тооллогыг чинь бүрэн ашиглаж чадахгүй байгаа байхгүй юу хүмүүс. Тэгэхээр энэ асуудал дээр ямар байр суурь бодлого байгаа вэ. Тэгээд миний өмнөх 2 асуудал дээр .../минут дуусав/

Н.Учрал: Ажлын хэсэг хариулъя. Мягмар дарга 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Ургийн овогтой холбоотой асуудал. Гэр бүлийн хууль дээр энэ ургийн овгийг хөтлөх, өвлүүлэхтэй холбоотой гэрлэгчдийн эрх, үүрэг дээр оруулж ирсэн явж байгаа. Тийм учраас яах арга байхгүй таны хэлж байгаагаар энэ цус ойртолтыг сэргийлэх Монголын уламжлалт энэ өв соёл бол энэ угийн бичиг, ургийн овгоо барьж явж байсан энэ бол соёл байгаа. Тэгээд энэ улсын бүртгэлд байгаа мэдээллээр бол таны хэлдгээр энэ Боржигон, сартуул ч гэдэг юм уу энэ янз янзын байдлаар ингэж яг үндэслэлтэйгээр ч гэдэг юм уу ургийн овгоо бичүүлээгүйгээс болж иймэрхүү асуудлууд бол замбараагүй болсон ийм хандлага байгаа. Тэгээд Иргэний улсын бүртгэлийн хуульд зааснаар бол иргэд энэ буруу хөтлөгдсөн, буруу бичигдсэн зүйлээ солих бол хууль, эрх зүйн боломж нь байгаа. Зүгээр яг хэлэлцэх эсэх нь дэмжигдээд, хэлэлцүүлгийн шатад энэ хууль маань шинэчилсэн найруулга учраас бас журмын зохицуулалттай холбоотой энэ зүйл, хэсэг оруулж ирээд, энэ дээр нь ургийн бичгийг цэгцлэх асуудалтай холбоотой зүйлийг хэлэлцүүлгийн шатад нь санал гаргаа дэмжүүлэх бололцоотой байх гэж харж байна.

Н.Учрал: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дэмжиж байгаад баярлалаа. Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр хувь хүн талаасаа боломж байгаа боловч 2018 онд хууль батлагдсанаас хойш буюу бүртгэлийн багц хуулиас хойш 712 иргэн л ургийн овгоо солиулсан. Энэ өөрөө нөгөө архивын лавлагаа баримт бичгийг авахад хүндрэлтэй байдаг. Тийм учраас энэ 8 удаагийн хүн амын тооллогыг яаралтай цахимжуулаад, энэ дээр family search буюу технологижуулаад энэ дээрээсээ бас яг ураг төрлөөрөө нийтээрээ ингэж бичилтийн болоод зөрүүтэй эсвэл

энэ зохиомол овог нь буруу байжээ гэдгээ тогтоолгоод явах ёстой. Энийг хийгээд ирэх юм бол маш олон Боржигон овог авсан хүмүүс ч бараг Боржигон биш болж хувирна л даа. Яг жинхэнэ удам судар нь гарах юм байгаа юм. Энэнээс харин айхгүйгээр бид нар тогтоох ёстой. Өнөөдөр 92 мянган овог байгаа. 1918 оны тооллогоор бол 1200 овог байсан юм. Тэгээд одоо ийм замбараагүй байдалд оччихоод байгаа. Энэ цус ойртолт чинь ерөөсөө ДЭМБ-ын маш олон суурь өвчнүүдийг авчирч байна гэдэг зүйлийг эрдэмтэд тогтоогоод байгаа байхгүй юу. Энэ үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс хийсэн судалгаагаар 10-д .../минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут өгье.

Д.Сайнзориг: Нийт энэ гэр бүлийн 9,2 хувь нь цус ойртолттой байна. 22 орчим хувь нь цус ойртсон байх магадлалтай байна. 30 орчим хувь дээр нь ямар нэгэн согогууд гарч байна гэж байгаа. Эндээс гарсан хүүхдүүд дандаа ямар нэг өвчтэй байгаа. Тэгэхээр энэ одоо тоглоом биш болсон.

2 дугаарт энэ асуудлыг шийдэхгүй бол олон улсын өвчний 10 дугаар ангиллын 19 бүлэг, 32 төрлийн хорт хавдраар өвчлөөд байгаа суурь шалтгаан чинь энэ цус ойртолт болчихоод байгаа. Тэгэхээр энэ зүйлүүдийг яг зохион байгуулалттайгаар Цахим хөгжлийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, бүртгэлийн байгууллага мэдээллийн сан үүсгээд, тусгай нэгж байгуулаад, яг ураг төрлөөрөө бас энэ ургийн овгоо шинэчилж, баталгаажуулж авах энэ асуудлыг шийдье.

1915 оны хүн амын тооллогыг оросууд аваад явсныг Польшоос бид нар олоод ирлээ. Энийг Чулуун доктор 9 боть ном хэвлүүлсэн байна. Энийг зохиогчтой нь ярьж байгаад эргэлтэд оруулаад, яг энэ ургийн овгоо баталгаажуулж, зөвөөр тогтоолгох, хэн хэн байсан бэ гэдгээ тогтоолгох асуудал баймаар байна. Энийг гадуур мушгиж Хятадуудыг овогжуулах гэж байна энэ тэр гээд .../минут дуусав/

Н.Учрал: Бямбацогт сайд 1 минут.

С.Бямбацогт: Ургийн овог уг нь бол Монголчуудын эрт дээр үеэсээ уламжлал соёл бол үндсэндээ нөгөө үр удмаа, овог удмаа цааш нь хадгалж явах, хоорондоо бас цус ойртохгүй, бас суухгүй байх гээд олон талын их ач холбогдолтой байсан юм байна лээ. Бид нар чинь бас хэсэг хугацаанд нөгөө ургийн овгийг ашиглахаа больсон. Сүүлийн үед ашиглаж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор үндсэндээ л овог, эцгийн нэр, өөрийн нэр гээд ингэхээр овог дээр ерөөсөө тэгээд л зайлшгүй бичих шаардлагатай болсон учраас тухайн үедээ тэгээд ихэнх нь бол Боржигон гээд л явчихсан. Тэгээд л дур дураараа овог өгөөд явчихсан. Иймэрхүү болчихсон. Одоо энийг буцаагаад хүний эрхтэй холбоотой асуудал учраас заавал эрт дээр удам судраа судалж байж ийм тийм овог өгөхийг шахах нь жаахан хязгаарлагдмал байх. Тийм болохоор юу гэдэг юм, энийг нээлттэй л шийдэхээс өөр аргагүй байгаа юм. Энийг бас зөв ойлгоорой. Энэ бол үндсэндээ овгийн нэр өгөх, цаашдаа .../минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут. Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Цаашдаа бас таны хэлж байгаа энэ цус ойртолттой холбоотой, үр удамтай холбоотой энэ асуудал дээр бас иргэдийн нөгөө иргэний үүргээ ухамсарлах хүрээнд бид нар мөн хуульдаа тодорхой зохицуулалт хийж ургийн бичиг, угийн бичиг хөтлөх, үүгээр бас хамаатан саднаа, эцэг өвгөдөө мэддэг. Одоо

бид нар чинь ихэнх нь бол 3 үеэс цааш мэдэхээ больчихсон байгаа. 5 үе, 7 үеэ мэддэг байвал хэрэгтэй. Цаашдаа энийгээ хөтлөөд, үр удамдаа үр ач зээ нартаа цаашлаад үлдээх юм бол бас аль алинд нь л хэрэгтэй байх л даа. Тэгээд тэр үүднээсээ бас энийг тодорхой зохицуулалтууд бол орсон байгаа. Энэ ургийн бичиг хөтлөх талаар. Энийг бас юу гэдэг юм овог авах тал дээр тодорхой хуульчлах боломж байхгүй.

Яг өнөөдөр Боржигон овогтой 600 мянган хүн байдаг юм байна. Боржигин гээд дахиад “о”, “и” 2 үсэг нь өөр тэгээд бас 200-аад мянган хүн байдаг юм. Сартуул овогтой гээд иймэрхүү хүмүүс өөрсдөө л дур дураараа овгоо өгч байгаа. Мэдээж таны хэлж байгаа тэр хятад .../минут дуусав/

Н.Учрал: Сайнзориг гишүүн асуулт асууж, хариулт авсан. Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан 13 цаг болсон тул завсарлаж байна. Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан 14 цагт эхэлнэ.

13.00 цаг.

ЗАВСАРЛАГА

Ж.Бат-Эрдэнэ: 2025 оны 12 сарын 4-ний өдрийн үдээс хойших хуралдааныг үргэлжлүүлье. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчдын илтгэл, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт, хариулт явж байгаа.

Ингээд цаашаа үргэлжлүүлье. Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя. Ганмаа гишүүний минутыг шинээр эхлүүлье.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу. Цөөн хэдэн асуулт байна. Хэнээс асуух вэ. Ажлын хэсгийнхнээс үү. Заалныхаа камерыг өгөөд хэн хэн байгааг харуулчих юм уу.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийнхэн орж ирсэн байна.

Д.Ганмаа: Хуулийн төслийн танилцуулга болон үзэл баримтлалаас харахад орхигдсон буюу хийдлийг арилгах зорилгоор энийг найруулсан. Шинэчилсэн найруулга танилцуулсан байна. Тэгэхээр энэ шинэ төслөөр өмнө хуульд байгаагүй, ямар орхигдсон, ямар хийдэлтэй харилцааг яаж нөхөж, юуг нь арилгаж орж ирсэн бэ гэдэг асуулт байгаа юм. Жишээлбэл, энэ танилцуулга, үзэл баримтлалаас нь харахаар гэр бүлийн гишүүдийн эрх, эрх чөлөөг хязгаарласан зохицуулалт болсон. Иймд хүчирхийллийн шинжтэй бол заавал нотлох баримт шаардахгүйгээр хүсэлтийг авч эвлэрүүлэн зуучлалаар орохыг шаардахгүй болгоно гэсэн ийм танилцуулга явж байгаа юм. Гэсэн атлаа энэ яг яаж хэрэгжүүлэх юм, арга зам нь юу юм. Процедурыг нь заагаагүй.

Дээрээс нь тухайлсан заалт огт ороогүй юм шиг харагдаад байна л даа. Бас энэ шинэ төслийн 14.1.1 дээр гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийллийн дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд, ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй эсвэл учирсан нь тогтоогдсон. Энэ дээр байнгын шинж гэдэг үг нь дахиад ороод ирчихсэн. Өмнөх хууль дээр ч гэсэн байнгын гэж байсан. Байнгын гэдэг шалгуур үзүүлэлт нь яг юу юм бэ гээд

харахаар зэрэг Улсын дээд шүүхийнхээ тайлбарын дагуу явдаг юм байна. Тэр нь 3 ба түүнээс дээш удаа үйлдэгдсэн тохиолдолд гэмт хэрэгт тооцох хандлагатай гэдэг. Тэгээд явчихаар яг практикт хэрэгжих дээ энэ нь тохиолдол тус бүрд янз янзаар үздэг юм байна. Жишээлбэл дүүргүүдийн шүүх дээр гарсан тохиолдол дээр 24 цагийн дотор 3 удаа зодсон үйлдлийг 1 шалтгаанаар зодсон учраас гээд байнгын гэдэг шинжийг хангахгүй гэж үзсэн тохиолдол гарсан байна. Эсвэл энийг гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг бус зөвхөн хүний биед гэмтэл учруулсан гэж үзэж шийдвэрлэсэн байна. Тэгэхээр ингээд практик тус бүр дээр өөр өөрөөр тайлбарлагдаж яваад, хохирогч улам хохирох ийм боломжтой байгаад байгаа юм. Энэ практикаас үзэхэд хүчирхийллийн хохирогч нь энэхүү байнгын гэсэн шалгуурыг хангахын тулд 3 буюу түүнээс дээш хүрэх тоогоо хүлээх, тэсэх, тоогоо гүйцээхийн тулд үргэлжлүүлэн зодуулах, харгис хэрцгий харьцаа, догшин авир үйлдлийг тэсэх ийм шаардлага үүсээд байдаг юм байна. Мэдээж энэ нь хялбар биш. Эцсийн эцэст хүн чинь нэг зодуулаад юм уу, 2 удаа маш гүнзгий хямралд орох, сэтгэл зүйн эсвэл биеийн ноцтой гэмтэл учрах, хохирол амсах ийм боломжтой байгаа. Тэгэхээр энэ хууль хэрэгжүүлэгч байгууллага яг энэ байнгын үйлдэх гэдэг шинжийгээ энэ хууль дээрээ хуульчлан зайлшгүй ийм тодорхойлох шаардлагатай санагдаж байна. 2 дугаарт.

Дараагийн асуудал нь энэ одоогийн гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийг эхний удаа 7-30 хоног баривчлах шийтгэл гэж оногдуулдаг юм байна. Энэ баривчлах шийтгэл нь ихэвчлэн хүчирхийлэл үйлдэгчдийг эсрэгээрээ өс хонзон санах баривчлагдаад гарч ирээд улам илүү хүчирхийлэлд өртөх тэр айдсыг тэр гэр бүлийн гишүүдэд төрүүлдэг. Ингэснээрээ нөгөө шүүх хуулийн байгууллагаас шийтгэхээсээ илүүгээр ингээд урьдчилан сэргийлэх юм уу эсвэл хүмүүжүүлэх арга хэмжээ нөлөөлөх боловсрол олгох юм уу, тийм урьдчилан сэргийлэх ер нь ямар арга хэмжээг бодож боловсруулж орж ирж байгаа юм. Болсон явдлын дараа биш өмнө гэсэн утгаараа ямар асуудлуудыг энэ дээр шинэчилж оруулж ирж байгаа гэдэг асуудал байна.

Энэ гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дараагийнх .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ. Ажлын хэсэг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар хариулах уу.

Н.Мягмар: Ганмаа гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар. Гэр бүлийн хууль 1999 онд баталсан хууль өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Тэгээд шинэ тутам үүссэн харилцааг бас энэ хууль маань зохицуулах зохицуулалт дутагдалтай байна гэж үзэж, шинэчилсэн найруулгыг боловсруулж, үүнээс өмнө 3 удаа өргөн мэдүүлж ингэж хэлэлцэж явж байсан. Ялангуяа тээгч эхтэй холбоотой гэдэг юм уу, гэрлэгчдийн хүйс солихтой холбоотой, мөн тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой, мөн саяын таны асуултад дурдаж байгаа гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэр бүл цуцлах, үрчлэлтийн асуудал гээд энэ харилцаануудыг нарийвчлан зохицуулж ирж байгаа. Мөн түүнчлэн Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх байгуулагдсантай холбоотойгоор энэ шүүхийн хэрэглэх гэр бүлийн хэрэг зөрчлийн хүүхдийн үйлдсэн хэргийг шийдвэрлэх шүүхийн процессын хууль буюу энэ хууль бас хэлэлцэх асуудлын 2 дахь асуудалд байж байгаа. Тэгээд таны зарим асуултад дурдагдаж байгаа нарийн шүүхээр шийдвэрлэх процессыг нь нөгөө хууль дээр тусгагдаад явж байгаа гэдгийг хэлье.

Одоо Гэр бүлийн хууль дээр таны дурдаж байгаа эвлэрүүлэн зуучлах зохицуулалтгүйгээр өөрөөр хэлэх юм бол одоогийн хүчин төгөлдөр Гэр бүлийн хуулиар гэр бүлээс өмнө эвлэрүүлэн зуучлах арга хэмжээг бол авах ийм зохицуулалттай явж байгаа. Тийм учраас энэ шинэчилсэн найруулгын 14.1 дээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсаны дараа шүүх иргэний хэрэг үүсгэнэ. Дараах тохиолдолд эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцалж болно гэдэг зүйл дээр хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой, эсхүл ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй эсхүл учирсан нь тогтоогдсон гээд энэ тохиолдолд шүүх эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэр бүл цуцлах асуудлыг шүүх дээр оруулж ирнэ гэдэг энэ зохицуулалт орж ирж байгаа. Үүний нарийвчилсан зохицуулалтууд нь нөгөө процессын хууль дээрээ бас тусгагдаад явж байгаа гэдгийг хэлье. Энэ дээр бас яг таны дурдаж байгаа удаа дараа гэдгийг Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааны 2025 оны 28 дугаар тогтоолоор 3 ба түүнээс дээш удаа гаргасан байхыг ойлгоно гэж ингэж тайлбарласан. Тэгэхээр энэ тайлбараа шүүх хэрэглээд явна гэж ингэж үзэж байгаа.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүмүүстэй холбоотой бол Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Зөрчил болон зөрчил шалган шийдвэрлэх хууль дээр зохицуулалтууд байгаа. Үүнтэй холбоотой практикт үүсэж байгаа асуудлын талаар бол манай цагдаагийн байгууллагын Зөрчлийн асуудал хариуцсан хүн хариулна.

Ж.Бат-Эрдэнэ: Өөрийгөө танилцуулаарай.

Б.Батзориг: Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, хурандаа Батзориг илтгэж байна. Цагдаагийн байгууллагаас хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага мэдээллийг хүлээн авах хуулийн харьяалал нь өөрөө цагдаагийн байгууллагад байгаа. Энэ хүрээнд хүүхэд, гэр бүлийн байгууллагатайгаа хамтраад тухайн гэмт хэргийн шинжтэй, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг дуудлага мэдээллийн хэмжээнд хүлээн авч шалгах, шийдвэрлэх бүхий л үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулж байгаа. Тухайлбал би зарим нэг тоо мэдээг бол товчхон дурдчихъя гэж үзэж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар 202,705 дуудлага, мэдээлэл гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл цагдаагийн байгууллагад бүртгэгдэж, хуульд заасан үндэслэл журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн байна. Цагдаагийн байгууллагаас тухайн гэр бүлийн хүчирхийллийн кэйсийг өмнө нь зөвхөн хохирогчийн овог нэрээр, хаягаар бүртгэдэг байсан бол регистрийн дугаараар болон давтамжаар нь гээд нэлээн олон төрлөөр гэр бүлийн .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ганмаа гишүүн тодруулах уу. Хариулт дуусгая.4 номерын микрофоныг цааш нь сунгая.

Б.Батзориг: Энэ чиглэлийн мэдээллийн системийг бол цагдаагийн байгууллага сүүлийн жилүүдэд бол нэлээн өргөн хүрээнд бүрдүүлж өгсөн байж байгаа. Мөн түрүүн асуултад дурдсан байнга гэдэг давтамжийн талаар Улсын Дээд Шүүхийн мэдээллийг дахиад 1 тайлбарлаад, мэдээлэл болгож хэлье. Улсын Дээд шүүхээс энэ байнга гэсэн давтамжийг бол зөрчилд хариуцлага тооцох, хөөн хэлэлцэх хугацааны энэ хооронд 3 ба түүнээс дээш удаа тухайн гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийг үйлдсэн тохиолдолд байнга үйлдэх буюу заавал тухайн гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийг 1 удаагийн үйлдлийг биш, Зөрчлийн тухай хуулийн 5.4.4-д заасан 4 хүчирхийллийн шинж байгаа. Энэ 4 хүчирхийллийн шинж

бүгдийг нь байж болно. Аль нэг хүчирхийллийн шинжийг байж болно. Нийтдээ 3 ба түүнээс дээш удаа зөрчил шалгах хугацааны хөөн хэлэлцэх хугацааны дотор үйлдсэн байвал үүнийг бол байнга гэсэн үйлдлийн шинжид хамааруулж гэмт хэргийн шинжид оруулж байгаа. 11.7 руу оруулж байгаа. Тохиолдлын шинжтэй буюу нэг удаагийн үйлдэл дээр бол Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэж .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн хугацаат цэргийн албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Тодруулах уу. Ганбаа гишүүн тодруулъя.

Д.Ганмаа: Саяын асуусан асуултаас дутуу байгаа. 1 дүгээрт тэр байнгын үйлдэх шинжийг ингээд хуульдаа тодорхойлолтыг нь шалгуур үзүүлэлттэй бараг оруулж ирэх нь зүйтэй юм шиг надад санагдаад байна. Тэгээд Улсын Дээд шүүхийн гарсан тодорхойлолтоор сая би түрүүн хэлсэн практик дээр хэрэглэхдээ янз янзаар хэрэглээд, тэгээд хохирогч улам хохирох энэ нөхцөл бүрдэж байгаа олон ч тохиолдлууд гарсан байгаа шүү дээ.

Энэ зөвхөн нөгөө хорихоосоо гадна 2 дугаарт урьдчилан сэргийлэх, хүмүүжүүлэх арга хэмжээ, сургалт нөлөөллийн ажлууд дээр ямар юмнуудыг энэ хууль дээр оруулж ирсэн бэ. Эцсийн дүндээ хүчирхийллийг давтагдахгүй байх илүү ноцтой болгохгүй байх энэ асуудлуудыг яаж урьдчилан сэргийлэх гэж байгаа гэдэг асуулт байгаа юм. Энэ уг нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүний зан үйлд нөлөөлөх сургалт гэж юм хийх нь хийдэг л юм байна лээ. Тэр нь сургалтад хамрагдсан нийт 450 .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ганмаа гишүүнд дахиад 1 минут.

Д.Ганмаа: 452 хүнээс асуухаар энэ баривчлагдах байранд зохион байгуулсан албадан сургалтын үр нөлөөг асуухаар 45 хувь нь огт хангалтгүй сургалт байсан. 28 хувь нь үр нөлөөгүй гэж хариулсан үр дүнгээс үзэхэд энэ баривчлагдсан этгээдүүдийн зан үйлд нөлөөлөх эсвэл баривчлах гэдэг чинь урьдчилан сэргийлэх, нөлөөлөх, боловсрох, эдгээр асуудлуудыг бүр цаад углуургаар нь шийдэхэд ямар ч нөлөөгүй болж харагдаад байгаа байхгүй юу. Энэ дээр энэ шинэчилсэн найруулга дээр ямар арга хэмжээ, хөтөлбөр, тусгайлсан заалтууд оруулж ирж байгаа юм гэдэг дээр.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Хариулъя. 4 номерын микрофон.

Б.Батзориг: Цагдаагийн ерөнхий газрын хурандаа Батзориг илтгэж байна. Өнөөдрийн өргөн барьж байгаа хууль тогтоомж маань бол харилцааны хувьд бол арай өөр. Гишүүний асууж байгаа түрүүн мэдээлэлд дурдагдаж байгаа асуултууд бол их чухал асуудал байгаа. Үүнийг Улсын Их Хурлаас 2016 оны 12 сарын 22-ны өдөр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль гээд бүрэн цогц хуулийг тухайн хууль дээр Их Хурлаас эхлээд төрийн бус байгууллага, төрийн байгууллагаас эхлээд гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага хэрхэн, ямар үүрэгтэйгээр хамтран ажиллаж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх юм бэ, яаж таслан зогсоох юм бэ, хэрхэн шийдвэрлэх юм бэ гэдгийг байгууллага байгууллага болгоны үүргийг, иргэний үүргийг хүртэл, хорооны Засаг даргын үүргийг хүртэл тусгайлан зааж өгсөн гол концепц бүхий хууль байгаа. Тэр хуулиар саяын яригдаж байгаа харилцаануудыг бол бүгдийг нь зохицуулж өгсөн

байгаа. Өнөөдрийн барьж байгаа энэ хууль маань эдгээр хууль тогтоомжуудыг илүү боловсронгуй болгох, мөн өмнө орхигдсон зарим .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Товчхон тодорхой хариулчихмаар байна. Яг сургалттай холбоотой асуудлуудаа бас дутуу ярьчихлаа. Дараа нь нэмж тайлбарлаарай. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Сайд нар хаачив гэдэг асуултыг л асуучихмаар байх юм. Засгийн газраас өргөн барьсан хууль шүү дээ. 1 ч сайд байхгүй. Танхимд 15 гишүүнтэй. 14 цагаас чуулган үргэлжилнэ гэж уг нь тодорхой л хэлсэн биз дээ. Тэгээд танхимдаа 15 гишүүнтэй ийм чухал асуудлыг яриад сууж байгаа нь бас л харамсалтай л байна. Тэгээд Бямбацогт сайд нөгөө өргөн барьсан сайдын оронд танилцуулгаа уншаад, уг нь бас тодорхой асуултуудад хариулаад сууж байсан бас байхгүй. Тэгээд ажлын хэсгээс л, албаныхаас л асууя даа.

Гэр бүлийн салалтын шалтгаан. 2017 онд гэр бүлээ салгаж байгаа өрхүүдийн 2 хувь нь гэр бүлээс гадуур харилцаа гэж тэмдэглэгдсэн байдаг. 2022 онд 20 хувь нь гэр бүлээс гадуур харилцаа гэж шалтгаанаа мэдүүлсэн байна. Хэдхэн жилийн дотор 10 дахин нэмэгдсэн байна. Энэ манай нийгэмд тулгамдаж байгаа маш том асуудал мөнөөс мөн. Тэгэхээр энэ гэр бүлийн гадуур харилцаа дээр ямар бодлого байх вэ гэдгийг яалт ч үгүй асуултын тэмдэг байхад үүнийг бас зүгээр торгоод өнгөрөх юм шиг, эсвэл инээдэм ханиадам болгоод л нийгэмд ийм сонин байдлыг үүсгээд л, хариултууд яваад л ердөөсөө 1 тийм чухалчилж авч үзэхгүй байгаа нь бол маш харамсалтай байна. Энэ дотроо хүүхдүүдийн асуудал маш чухлаар тавигдана. Жилд 30 мянга орчим хүүхэд бол эцэг эх нь гэрлэлтээ бүртгүүлээгүй хүүхдүүд мэндэлж байна. Энэ дотор мэдээж зүгээр иргэний харилцаа юу гэдэг юм эцэг эх хоорондоо байгаа ээж аавууд ч байна. Гэр бүлийн харилцаа, гэр бүлээс гадуур харилцаанаас үүссэн хүүхдүүд ч гэсэн байна. Тэгэхээр ер нь тухайн төрж байгаа хүүхэд бүр хөрөнгө эзэмших, өв залгамжлах, тэжээн тэтгүүлэх эрхтэй гэж зааж өгсөн нь энэ хуулийн бас маш том зүйл заалтууд юм уу гэж миний хувьд харж байгаа.

29.3 дээр гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг эхийн дундаас төрсөн хүүхэд гэрлэлтээ бүртгүүлсэн гэрлэгчдээс төрсөн хүүхдийн адил эрх эдэлнэ гэж зааж өгсөн байгаа. Тэгэхээр үүнийг тухайн эцэг нь гэр бүлийн харилцаанаас гадуур хүүхэдтэй боллоо гэж үзэхэд тухайн хүүхдийг тэжээн тэтгэх үүргийг адил хүлээх үү, үгүй юу гэдгийг тодорхой надад хариулаад өгөөч. Хаа хамаагүй, энд тэндгүй хүүхэдтэй болоод яваад байгаа энэ эрчүүдийн хувьд өв залгамжлах хүртэл энэ тухайн хүүхэд эрхтэй шүү гэдгийг чанга тодорхой хариуцлагыг нь хэлээд өгөөч. Хүүхдийн тэтгэмжийг өгөх үүргийг хүлээж байгаа юу. Тэжээн тэтгэх үүргийг хүлээж байгаа юу, үгүй юу гэдгийг нэг тодорхой хэлээд өгмөөр байна. Яагаад гэвэл хуулийнхаа танилцуулга дээр зөвхөн 5-аас доошгүй жил хамтран амьдарсан хосын хүүхдүүд гэрлэлтээ бүртгүүлсэн өрхийн хүүхдүүдтэй нэгэн адил өв залгамжлах эрхтэй юм шиг тийм салаа утгатай тайлбар бас өгөөд байна. Уг нь бол эцэг нь мөн л юм бол эхээс гарсныг нь бол угаасаа ойлгомжтой шүү дээ. Хэн ч тодорхойлоод байх шаардлага байхгүй. Тухайн эцгийн хувьд эцэг нь мөн л гэж тодорхойлсон бол тэжээн тэтгэх үүргийг хүлээж байгаа гэдгийг, ямар нэгэн цаг хугацааны хязгаар тавигдаагүй гэдгийг, өөр шалгуур байхгүй гэдгийг нэг тодорхой хэлж өгөхийг хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя.

Н.Мягмар: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар. Таны дурдаж байгаа судалгаанд гарч ирж байгаа гэр бүлээс гадуурх харилцаа бол гэр бүл салалтын томоохон шалтгаануудын нэг болж ингэж өсжээ гэдэг энэ судалгаа бол гарсан. Тэгээд үүнтэй холбоотойгоор энэ Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулгын нэг концепцын маань үндсэн юм бол хүүхдийн дээд эрх ашгийг хамгаалах гэдэг энэ агуулгаар энэ концепц маань бичигдэж орж ирсэн. Тийм ч утгаараа саяын таны асуултад дурдаж байгаа 29.3-д хүүхэд бол гэрлэлтээ бүртгүүлсэн эсэхээс үл хамааран өв залгамжлах, тэр бусад эрхтэй байхаар ингэж зохицуулсан. Ялангуяа эцэг тогтоох асуудал бол одоо байгаа Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн хуулиар бас байж байгаа. Тийм учраас гэрлэлтээ бүртгүүлэхгүйгээр хүүхэдтэй болоод ингээд гэр бүлийн гадуурх харилцаанаас явж байгаа хүмүүсийн хувьд эх нь хэрвээ хүсэлтээ гаргаад онцгой ажиллагааны журмаар шүүхэд эцэг тогтоох хүсэлтийг гаргаад, энэ хүсэлтийг хангаж шийдвэрлэхийг хүсэх тохиолдолд бол тэр хүүхдийн эцэг тогтоогдсоны дараа тэр өв залгамжлах асуудал бол Иргэний хуулийн 520.1-д зааснаар өв залгамжлуулах эрх нь үүсэх ийм бүрэн боломжтой байж байгаа. Тийм учраас хүсэхгүй байгаа тохиолдолд эх нь эцэг тогтоолгох хүсэлтийг шүүхэд онцгой ажиллагааны журмаар гаргаад ингээд шийдвэрлүүлээд ингэж явах бүрэн боломжтой байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Аюушийн Ариунзаяа гишүүн дахин тодруулъя.

А.Ариунзаяа: Хүүхдийн өмнө бол асран тэтгэх үүргийг эцэг эх хоёулаа хүлээж байгаа. Үүрэг хүлээж байгаа болохоос биш боломжийн талаар боломжтой гэдэг ийм байдлаар бас хандах ёсгүй. Үүнд эцэг нь мөн л юм бол хүүхдийг тэжээн тэтгэх, тэтгэмжээ өгөх үүргийг хүлээж байгаа. Үүнд 5-аас доошгүй жил хамтран амьдарсан байна уу, гэрлэлтээ бүртгүүлсэн байна уу, бүртгүүлээгүй байна уу, 1 удаагийн харилцаанаас үүссэн байна уу гэдэг нь үл хамаараад шүү гэдгийг бас энд тодруулж хэлмээр байна. Яагаад гэвэл хүүхдийн өмнө хүн болгон үүрэг хүлээсэн байгаа шүү. Нэн ялангуяа эцэг эх нь юм гэдгийг онцгойлж хэлмээр байна.

ДНХ шинжилгээ хэдэн төгрөгөөр, хаана хийдэг вэ. Тэгээд хосуудын хоорондын хамаарал нь хэдэн хувьтай байвал зохистой хэмжээнд тооцогддог вэ гэдгийг бас тодруулаад өгөхийг хүсэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя.

Б.Тэнүүн: Шүүх шинжилгээний ерөнхий газрын ДНХ лабораторийн эрхлэгч Тэнүүн. Тэгээд Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

Эцэг тогтоох шинжилгээг болохоор Шүүх шинжилгээний тухай хуульд зааснаар бол хувийн лаборатори болон шүүх шинжилгээний байгууллагад бол хийх бололцоотой болсон байгаа. Тэгээд эцэг тогтоох шинжилгээг болохоор Засгийн газрын төлбөрт үйлчилгээ улсын тэмдэгтийн хураамжийн дагуу болохоор 180 мянган төгрөгөөр бол авч хийгддэг. Энэ багц шинжилгээ гээд эцэг эх хүүхэд гэсэн шинжилгээ бол хийгддэг байгаа. 2025 оны байдлаар гээд энэ жил бол нийтдээ 800 орчим эцэг тогтоох шинжилгээ хийгдсэн байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ариунзаяа гишүүн дахин тодруулж асууя.

А.Ариунзаяа: Яах вэ, эцэг тогтоох шинжилгээг надад хариулаад өгсөнд баярлалаа. Гэхдээ би түүнийг асуугаагүй. Хосууд гэрлэхээсээ өмнө ДНХ шинжилгээ хийнэ гэсэн хуулийн заалт байгаад байна шүү дээ. Тэгэхээр энэ хосуудын гэрлэхээсээ өмнө хийлгэх шинжилгээг хаана хийж байгаа вэ. Хэдэн төгрөгөөр хийлгэх вэ. Тэгээд хоорондын хамаарал нь хэдэн хувьтай байх нь зөвшөөрөгдсөн гэж үзэх вэ. Одоо юу гэдэг юм 30 хувийн хамааралтай байна гээд гарчихлаар 0 биш байна. 2-уулаа салъя гэдэг юм ярих юм уу. Эсвэл 50 хувьтай байхад яах вэ, болно. Угаасаа монголчууд ийм ойрхон гэх юм уу. Ямар нэгэн ийм тавигдсан тийм шалгуур байдаг юм уу, үгүй юм уу гэдгийг л асуугаад байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Наад хуулийн заалтаас тодруулаад байна. Хариулъя 4 номерын микрофон.

Б.Тэнүүн: Дахиад хэлэхэд Монголын хүн амын 1 хувьд болохоор энэ 2028 оноос эхлэн шинжилгээ бол хийгдэж эхлэх ёстой байгаа. Тэгээд 2028 оноос өмнө энэ 2 жилийн хугацаанд бол ерөнхийдөө Монголын хүн амд бол түгээмэл давтагдаж байгаа генетикийн индексийг бол тогтоох ёстой. Ингэж тогтоож байж яг хэдэн хувиар, хэр хэмжээгээр индекс нь хэдээр тохирч байгаа тохиолдолд энийг ойртож байна, холдож байна гэдгийг тогтоох вэ гэдгээ бол тогтоогоод явна.

Тэгэхээр бол суурь судалгаа эхлээд хийгдэх ёстой. Иймэрхүү байгаа. Тэгээд 1 хүнд хийгдэх шинжилгээний дундаж өртөг бол 700-аад мянган төгрөг бол байна.

Ж.Бат-Эрдэнэ: Наадах чинь хэдэн хувьтай байвал зөвшөөрөгдөх юм. Ямар тохиолдолд зөвшөөрөгдөх юм гэдэг асуулт асуугаад байна шүү дээ.

Б.Тэнүүн: Сиплинг индексийг болохоор тогтоох ёстой байгаад байгаа. Сиплинг индекс гээд илүү ойртож байгаа хэсгийг нь тогтоогоод явах ёстой гэсэн үг. Энэ нь болохоор Сиплинг индекс 1-ээс бага байх юм бол ах дүү байх магадлал өндөр гээд, Сиплинг индекс 100-аас их байх юм бол ах дүү байх магадлалгүй байна гээд ингэж тогтоох ёстой. Индексийг нь тогтооно.

Ж.Бат-Эрдэнэ: Энийг ажлын хэсэг дээр ер нь тодруулах хэрэгтэй юм байна шүү дээ. Одсүрэнгийн Номинчимэг.

О.Номинчимэг: Өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр Гэр бүлийн тухай хууль бол манай энэ нийгмийн харилцааны бас нэг чухал суурь хууль байгаа. Бас олон ч жилд уншиж байгаа. Тэгэхээр энэ хуулийг бид хэлэлцэх эсэхийг нь шийдээд Улсын Их Хурал дээрээ хэлэлцүүлээд явах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа. Өөрөө гэр бүл гэдэг энэ нандин, эрхэм чанарын харилцаа, тэр сэтгэл зүйн байдаг юм уу, өмчийн эрхийн харилцаатай холбоотой болохоор нэлээн бас олон хүний анхаарлыг татдаг. Тэр чинээгээрээ ч гэсэн нийгэмд үзүүлэх үр нөлөө нь бас их өндөр учраас энэ хууль их чухал байгаа юм гэдгийг бас хэлмээр байна. Тэгээд яах вэ, энэ удаа илүү иргэдээс ирж байгаа өргөдөл, гомдолтой холбоотой асуудлаар энэ хуульд ер нь яаж тусгасан юм бэ гэдгийг тодруулмаар байна. 2 асуудал байна.

Эхний асуудал бол хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой асуудал байна. Тэгээд хүүхдийн тэтгэлгийн асуудал бол маш хүнд байгаа. Энэ хуулийн бас танилцуулгууд байна л даа. 2021 онд гүйцэтгэх хуудасны зөвхөн 11,3 хувь нь биелсэн. 2024 онд 9 хувь нь биелсэн гээд ер нь 91 хувь нь гүйцэтгэх хуудас маань биелдэггүй ийм асуудал байгаад байгаа юм. Гэхдээ бас үнийн дүнг нь харах юм бол 2021 онд

гүйцэтгэх хуудасны 11,3 хувь боловч мөнгөн дүнгийнхээ 51 хувь нь биелсэн гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ тооноос үзэх юм бол ер нь хөрөнгө мөнгө бололцоотой нь яах вэ, хүүхдийн тэтгэлгээ төлж байгаа юмнууд нь байх шиг байна. Цаад учир нь нөгөө бололцоогүй, одоо юу гэдэг юм гэр бүлээ салгачхаад амьдралын боломжгүй хүмүүс бас төлөхгүй байгаад байгаа асуудал байгаа юм. Нөгөө талаараа боломжтой мөртөө өөрийнхөө өмч хөрөнгийг өөр хүний нэр дээр шилжүүлээд, хүүхдийн тэтгэлгээсээ зугтаадаг асуудал ч гэсэн байна. Иргэдээс ирж байгаа өргөдөл, гомдол Өргөдлийн байнгын хороон дээр ажиллаж байгаа хүний хувьд хэлэхэд. Тэгэхээр нөгөө өөрөө их боломжтой, янзын сайхан машин унаад, байр орон сууцад байгаад байдаг. Салчихсан хүн маань. Тэгээд үзэхээр машин нь ээжийнхээ нэр дээр, байр нь хамтран амьдрагчийнх нь нэр дээр гээд эндээс нь гаргуулах боломжгүй гээд зогсчихдог юм байна. Нөгөө талаараа юу гэдэг юм эмзэг бүлгийн, давхаргын хүмүүс ч гэсэн бас төлөх боломжгүй гэдэг ийм хүмүүс байх шиг байна. Тэгэхээр энэ дээр хүүхдийн тэтгэлэг бол өөрөө энэ хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхэд өөрөө өсөн торниж, хүүхэд хөгжлийг дэмжих маш том чухал хөшүүрэг байгаа. Энэ дээр энэ хуулийн төсөл маш сайн анхаарч орж ирж байгаад бол талархаж байна.

2 юм тодруулах гэж байгаа үүнтэй холбоотой. 1 дүгээрт Дампуурлын тухай хууль дээр байдаг ийм зарчим байдаг л даа. Ер нь өөрөө нөгөө дампуурах гээд ирэхээрээ өр авлага нь ихэс гээд ирэхээрээ өөрийнхөө өмч хөрөнгийг залилангийн шинж чанартайгаар бусдад шилжүүлдэг нэг асуудал. Тэгээд энийг бусад эрх зүй, манай Дампуурлын хууль бол маш тийм болхи байгаа. Бусад эрх зүйн зохицуулалтын хүрээнд яг энэнээс өмнө үнээс нь багаар ч юм уу хэн нэгэн шилжүүлсэн, ойр тойрныхоо хүнд шилжүүлсэн байх юм бол тэр гэрээ хэлцлийг нь шууд хүчингүй болгоод, тухайн хөрөнгийг нь гаргуулж аваад, нөгөө зорилтот дампуурлын байдаг юм уу, энийг бас хүүхдийн тэтгэлэг дээр тэр гадаад улсууд хэрэглэдэг. Хүүхдийнхээ мөнгийг авах асуудалд бол шийдвэр гүйцэтгэл хийдэг асуудал байгаа. Тэгээд тэрэнтэй холбоотой ер нь зохицуулалт орж ирсэн болов уу. Санаатайгаар ингээд зугтаад, өмч хөрөнгөө ийш тийшээ шилжүүлээд байдагтай холбоотой.

2 дугаарт тэр мөнгө төгрөг үнэхээр байхгүй, эмзэг бүлгийн давхаргын хүмүүсийг яах юм бэ. Дагаж орж ирж байгаа Зөрчлийн хуулийг харах юм бол ер нь тэгээд торгоно, эсвэл баривчилна гээд. Тэгээд торгохоор дахиад л мөнгө байхгүй, нөгөө л эргэн тойрных нь хүмүүст эдийн засгийн дарамт болдог гэсэн. Тэгэхээр энэ хүмүүсийг ер нь хөдөлмөрлүүлээд, хөдөлмөрлөж олсон хөлснөөс нь энийг нь гаргадаг ч гэдэг юм уу тийм механизм байж болох уу. Мэдээж Монгол Улс нөгөө тэвчишгүй хөдөлмөрийн конвенцод орчихсон гээд байдаг боловч яг Монголынхоо нөхцөл байдлыг үзэхээр торгоно, хорино гэхээсээ илүү энэ хүмүүсээ бас хөдөлмөрлүүлж, эндээс нь үнэ цэнийг нь гаргаж авдаг ийм хөшүүрэг бас байх хэрэгтэй юм шиг байгаад байгаа. Энийг бас нэг зохицуулах боломж байгаа болов уу. Энэ 2 дээр эхлээд тодруулга авъя. Ажлын хэсгээс.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя.

Улсын Их Хурлын дарга Ням-Осорын Учрал, Улсын Их Хурлын гишүүн Алтаншагай нарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 151 дүгээр сургуулийн 10^а ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Багш, сурагчдадаа сурлага, хөдөлмөрийн их амжилт хүсье. Ажлын хэсэг хариулъя. 4 номерын микрофон.

О.Оюунзул: Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Оюунзул. Тэтгэлгээ төлөхгүй байгаа тэтгэлэг төлөгч дээр бол хөрөнгө орлогоо нуун далласан, төлбөрийн чадваргүй, эрхэлсэн тодорхой ажилгүй гээд төрөл бүрийн шалтгаанууд байдаг. Тэгээд бид бол Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж, Засгийн газраас энэ оны 5 дугаар сард өргөн барьсан Иргэний болон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөлд бол олон төрлийн хөшүүргүүдийг тусгасан. Тухайлах юм бол төрөөс тэтгэлэг төлөхгүй байгаа төлбөрийн чадваргүй тэтгэлэг төлөгчийн өмнөөс амьжиргааны доод түвшнээр урьдчилж төлөх, нөгөө хөдөлмөр эрхлэх чадвартай тэтгэлэг төлөгчийг бол ажилд зуучилж, хөдөлмөр эрхлүүлж орлогоос нь суутгах, мөн дээрээс нь энэ талаарх мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байх. Тэтгэлэг төлдөг эсэх, дээрээс нь бас олон төрлийн төрийн үйлчилгээ авах эрхэд нь бол хязгаарлалт тогтоосон байгаа. Тухайлах юм бол орон сууцын төрөөс хөнгөлөлттэй зээл авахгүй ч юм уу, нийтийн албанд орох эрх хийг нь хязгаарлах гэх зэрэг.

Тэгээд эхний асуултад энэ зохицуулалт бол одоогийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль дээр бол байдаг. Хэрэгжилтийн хувьд мэдээж хэрэг бас асуудалтай байгаа байх. Тэгээд түрүүн дурдсан Иргэний болон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль дээр бас судалгаанаас харахад гэрлэгчид нөгөө төлбөрийн үүргээсээ зугтахын тулд гэрлэлтээ дуусгавар болгочихдог. Шүүхээр ороод. Тэгээд тэр гэрлэлт цуцлалтыг хүчингүйд тооцож буцаагаад өмнөх 1-2 жилд ямар хөрөнгийг бие биедээ шилжүүлсэн байна, зах зээлийн үнээс доогуур яаж шилжүүлсэн байна хамааралтай этгээдүүдэд тэрийг шалгах, эд хөрөнгийн мэдүүлэг өгөх байдлаар энэ мэдүүлэг нь бол заавал байх, энэ мэдүүлгийн дагуу сүүлийн 2 жил хоорондоо холбоо хамааралтай этгээдүүдэд зах зээлийн ханшаас доогуур шилжүүлсэн бүх хөрөнгүүдийг шалгах, эргээд шүүхэд нэхэмжлэл гаргах энэ тогтолцоог бол Ш үүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн тэр багц хуульд бол тусгасан байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Номинчимэг гишүүн дахин тодруулъя.

О.Номинчимэг: Баярлалаа. Тэгээд яах вэ, энэ нөгөө хуулийн төсөлдөө харах юм бол хүүхдээ үл хайхарсан хүмүүсийн эцэг эх байх эрхийг нь хасна л гэчихсэн байгаа юм. Тэгээд олон ч нийслэл дээр ажиллаж байхад хүүхэд хамгааллын багтай уулзаж байсан. Үнэхээр эмзэг асуудлууд их байдаг. Тэгээд архи уугаад, нөгөө архи согтууруулах ундаанд донтчихсон хүмүүс архи уугаад алга болчихдог. Угаасаа л хүүхдээ орхичихдог. Тэгээд энэ хүмүүсийг эцэг эх байх эрхийг нь хасчихаар бүр ч баяртай. Янз бүрийн үүрэг хүлээхгүй гээд тэгээд өөр газар очоод дахиад л хүүхэд гаргаад, энэ асуудал их хүнд байна гэдэг юм ярьдаг. Тэгэхээр ийм зүйлийг зөвхөн хуулиар гэхээсээ илүү эдийн засгийн арга хөшүүргийг бий болгож, энэ хүмүүс өөрөө хөдөлмөрлөдөг энэ чинь эцэг эх болж байгаа чинь өөрөө үүрэг, хариуцлага дагуулдаг юм шүү гэдэг юмыг эдийн засгийн хөшүүрэгтэй л болгомоор санагдаад байгаа юм. Тэгээд л би тэр нэг хөдөлмөр эрхлүүлж энэ хүмүүсээс энэ үр хүүхдэд нь хэрэгтэй мөнгийг нь гаргуулж авах талаарх хөшүүргийг бид нар бас энэ конвенцынхоо юуг зөрчихгүйгээр арга замыг нь олоод авчих ёстой гэсэн зүйл..../минут дуусав/

Ж.Бат-эрдэнэ: Номинчимэг гишүүнд дахиад 1 минут.

О.Номинчимэг: Бас нэг зүйлс энэ өргөдөл дээр ирж байгаа 1 юм байна. Одоо бүр сүүлдээ хүүхдийн тэтгэлэг тогтоолгохоос зайлсхийгээд гэрлэлтээ цуцлуулахаас

зайлсхийдэг кэйсүүд болчхож. Гэрлэлтээ цуцлуулчих юм бол өмч хөрөнгөө хуваах болчихно. Хүүхдийн тэтгэлэг тогтоох болгочихно гээд нөгөө гэрлэлт цуцлуулахаар шүүхэд очихоор хаяг нь байхгүй, алга болчихдог ч юм уу. Эсвэл нөгөө шүүх нь эвлэрчхээд ир гээд хугацаа өгөөд, хугацаа өгсний дараа нөгөө хүн нь дахиад хаягаа өөрчлөөд алга болчихдог ийм жоохон асуудлууд байна. Энийг хууль, эрх зүйн хувьд шийдэх. Тэгээд дараагийн хуультай ч гэсэн холбоотой байх. Энэ процесс юу гэдэг юм салахтай холбоотой өмч хөрөнгийнх нь эрхийг нь яахтай холбоотой одоо гарч байгаа энэ гажуудлуудыг засах процессын юмнууд орж ирсэн байгаа юу гэдэг дээр бас тайлбар өгчихвөл сайн байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя. Өөрийгөө танилцуулаарай.

О.Оюунзул: Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Оюунзул. Хүүхэд бол төрснөөр, үрчлэн авснаар хүүхэд, эцэг эх хооронд бол хүүхэд эцэг эхийн харилцаа үүсэж байгаа. Тэгээд энэ утгаараа хүүхэд гэрлэлт дуусгавар болсон эсэхээс үл хамааран хүүхдийн өмнө хүлээх үүрэг ямар ч тохиолдолд байгаад явж байгаа. Тэгээд гэрлэлт цуцлахаас наана ч гэсэн бас энэ тэжээн тэтгэх үүрэг бол үргэлжлэхээр хуулийн төсөлд бол тусгаж өгсөн байгаа. Тэгээд хэлэлцүүлгийн үе шатад нарийвчлаад илүү сайжруулах боломжтой. Өөрөөр хэлэх юм бол нарийвчлан зарим нэг зохицуулалтаас дурдах юм бол жишээлбэл эцэг эх байх эрхийг хасах, хязгаарлахад 6 сар хүртэл ингэж хугацаа тавьж хязгаарлаж байгаа. Энэ хугацаанд ч гэсэн тэтгэлэг бол тогтоогоод явдаг байгаа. Тэгээд хуулийн төсөлд бас тусгасан байгаа. Тэгэхээр илүү бүр тусдаа амьдрах болж байгаа тэр амьдралын шаардлагууд дээр бас ингээд тэтгэлгийг .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Та хэд наадах асуудлаа тэгээд тусгаад орж ирж болоогүй юм уу. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын гол үзэл баримтлал нь бол гэр бүл болж байгаа гэрлэгсэд болоод гэр бүл салалтаас үүдэлтэйгээр энэ хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг л орхигдуулаад байгаа зүйл заалтын асуудлыг л нэн тэргүүнд хүүхдийн эрхийг зөрчихгүй байх асуудал дээр л гол анхаарлаа хандуулж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Тэгээд ингээд гэр бүл хүүхдийн эрх юунаас үүдээд байна, хохироод байна гээд хараад үзэхээр та бүхний энэ танилцуулгууд дээр хэд хэдэн зүйлүүд байна. Сая Номинчимэг гишүүний асуугаад байгаа энэ гэр бүл цуцлалтаас үүдэлтэй хүүхдийн тэтгэлгийн нөхөн олговрын асуудал шүүхийн шийдвэр гүйцэтгэл хангалтгүй байна гэж байна. Нөгөө талаар шүүгч нарын шийдвэрийн биелэлт шүүгч нарын шийдвэр дээр бас асуудал байна. Тухайлбал 2022 оны түүвэр судалгаагаар 50 шүүхийн шийдвэр дээр түүвэр судалгаанаас авч үзэхэд 5 нь буюу 10 хувь нь л тухайн шүүгч хүүхдийн тэтгэлгийг олгох асуудлаар шийдвэр гаргасан. 90 хувьд нь буюу 45 шүүхийн шийдвэр нь хүүхдийн тэтгэлгийг олгохгүй, орхигдуулсан байх ийм шийдвэр гарсан байх жишээтэй. Тэгээд энэ шүүгч нарын шийдвэрийг бас судлаад үзэхээр бас шалтгаан байдаг л юм байна л даа. Нэхэмжлэгч нар нь нэхэмжлэлдээ хүүхдийн тэтгэлгийг гаргуулах асуудлаар тусгаагүй, үндэслэлтэй нэхэмжлэлтэй ингэсэн байна. Тэгээд өнөөдөр амьдрал дээр ер нь энэ 90 хувь нь төлөгдөхгүй байгаа хүүхдийн тэтгэлгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийнхэн ер нь хэрхэн яаж хөөцөлдөж, ер нь иргэний хэргийн шүүхийн шийдвэр маргааны биелэлт дутуу байгаа асуудал бол ерөөсөө энэ гэр бүл цуцлалт, хүүхдийн тэтгэлгээс л үүдэлтэй юм байна лээ шүү дээ. Энэ дээр яг өнөөдөр яг амьдрал байдал дээр ямар хүндрэлтэй байна вэ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийнхэн энэ дээр нэг хариулж

өгөөч. Зарим эцэг эхчүүд бол үнэхээр 2 чихийг маань авахаас өөр юм байхгүй хүнээс юуг нь авдаг юм гээд л сууж байгаа шүү дээ. Ийм хүмүүстэй л холбогдож ажиллаж байгаа, харьцаж байгаа. Тэгээд энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг биелүүлэхийн тулд, хүүхдийн тэтгэлгийг гаргуулахын тулд тухайн хүүхдийн эрүүл аюулгүй орчинд өсөж торних, сурч хүмүүжих бололцоо боломжийг хангахын тулд тэр тэтгэлгийг гаргуулах талаар яаж амьдрал дээр ер нь хатуу ширүүн гэдэг юм уу нөхцөл байдлууд үүсдэг юм. Та бүхний үйл ажиллагаанд. Энэ талаар ямар арга хэмжээ авмаар байгаа юм. Энэ хууль батлагдсанаар тэгвэл энэ хэрэгжилт яаж сайжрах юм. Ямар арга хэмжээ авах юм. Энэ хүүхдийн тэтгэлгээ төлөхгүй байгаа энэ эцэг эхчүүдэд ямар хариуцлагын арга хэмжээ авах юм бэ. Энэ хууль батлагдсанаар яаж сайжрах юм бэ. Хэдэн хувьд хүрнэ гэж бодож байгаа юм бэ гэдгийг нэг хариулж өгөөч.

Нөгөө талаар энэ хууль зүйн хэллэг чинь хүүхдийн тэтгэлэг гээд ингээд бүгд хаа хаанаа хэлээд яриад сурчихсан юм шиг байна. Хүүхдийн тэтгэлэг гэж ярих чинь ер нь зөв үү, үгүй юу. Тэтгэлэг гэхээр энэ чинь уг нь боловсролын зээлийн тэтгэлэг гээд тухайн хүүхдийг маш сайн дэмждэг биз дээ. Сурах, гадаад дотоодод сурах тэтгэлгүүдийг төрөөс бодлогоор дэмжиж байгаа юм. Гэтэл хүүхдийн тэтгэлэг гээд ярихаар энэ чинь эцэг эхийнхээ үүрэг хариуцлагыг л дутуу биелүүлсэн, түүнээс болж хүүхэд хохирсон, гэр бүл цуцлагдсан асуудлаас болж л хүүхдийн тэтгэлгийн асуудал гэж яригдаад байна. Тэгээд энэ яг тэтгэлэг мөн үү. Үүрэг хариуцлагын бас энэ чиглэлийн юм байх уу. Энэ тал дээр та бүхэн энэ нэр томьёоны тал дээр хүртэл анхаарсан уу, үгүй юу. Энэ дээр бас Мягмар дарга хариулт өгөөч. Энэ яг хүүхдийн тэтгэлэг гэж ярьж явах нь хууль зүйн ухаанд зөв үү, үгүй юу.

Нөгөө талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэлийнхэн амьдрал дээр ямар бодит байдал дээр нөхцөл байдал хүнд байна вэ. Та бүхэн яаж хэрэгжүүлэхийн тулд ямар арга хэмжээ авч байна вэ. Хууль батлагдсанаар ямар үр дүнд гарах вэ гэдэг .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Хариулт өгье. Ажлын хэсэг хариулъя.

Н.Мягмар: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулгын маань 1 зүйл бол яах арга байхгүй хүүхдийн дээд эрх ашгийг хамгаалахтай холбоотой. Тийм учраас гэр бүл цуцлуулсан тохиолдолд бол хүүхэд тэжээн тэтгүүлэх энэ эрхийг нь бол хангах ийм зарчмаар бол энэ хуулийн төсөл боловсруулагдсан. Таны хэлж байгаа тэр судалгаануудад байгаа одоогийн шүүхийн практикт нэхэмжлэлийн шаардлагад тэтгэлэг тогтоолгох асуудлаар хандаагүй тохиолдолд шүүгч бас энийг нь шийдэхгүй байх ийм практик гарсан учраас энэ шинэчилсэн найруулгын төслийн 48.3 дээр хүүхдийн тэтгэлэг тогтоолгох хүсэлтийг гаргасан эсэхээс үл хамаараад шүүх гэр бүлийг цуцлах тохиолдолд энэ тэтгэлгийн асуудлыг заавал тусгаж, шийдвэртээ тусгахаар зааж өгсөн байж байгаа юм. Тэгэхээр энийг тэтгэлгийн хэмжээг амьжиргааны доод түвшинтэй уялдуулж тогтоож байгаа. Хүүхдийн насных нь онцлогоос хамаарч. Энийг нь хүүхдийн хэрэгцээ шаардлага, тэтгэлэг төлөгчийн бас олж байгаа орлоготой уялдуулаад, шүүх өөрөө тогтоох ийм бололцоог энэ хуульд бол оруулж өгч байгаа.

Түрүүн бас дурдагдсан, Номинчимэг гишүүний асуултад хариулагдсан. Одоо Улсын Их Хуралд өргөн мэдүүлчхээд байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой 3 багц хуулийн төслийн 1 болох Иргэний болон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хуулийн төсөл дээр энэ тэтгэлгийг төлөөгүй байгаа

хүмүүсийн төлүүлэх талаар хөшүүргүүдийг нь бол оруулж өгсөн. Үүнд тухайлбал, тэтгэлэг төлөгчийн төлбөрийн чадваргүй байх юм бол Хүүхдийн төлөө сангаас тодорхой амьжиргааны түвшнээр нь төлчхөөд, хөдөлмөрийн чадвартай, төлбөрийн чадваргүй этгээдийг ажил зуучлаад, ажил зуучилсан хөдөлмөрийн хөлсөөр нь буцааж нөхөн төлүүлэх, мөн тэр тэтгэлэг төлөхгүй байгаа этгээдийн гадаадад зорчих эрхийг хязгаарлаж байгаа энэ зохицуулалтыг хэвээр явуулж байгаа. Мөн бусад төрөөс олгож байгаа тэтгэмж авах эрхийг нь хязгаарлах, жолооны эрх авах асуудал дээр хязгаарлалт тогтоох ч гэдэг юм уу энэ хөшүүргүүдийг өргөн мэдүүлчихсэн байгаа. Тэр хуулийн төсөл дээр явж байгаа. Тэгэхээр эдгээр хуулиуд маань хэрвээ батлагдвал энэ чинь уялдаатай болж энэ шүүхээр тогтоосон хүүхдийн тэтгэлэг төлөх асуудал үр дүнгээ үзүүлнэ гэж үзэж байгаа.

Нэр томьёоны хувьд хүүхдийн тэтгэлэг, тэтгэмж гэдэг энэ асуудал дээр бол одоо байгаа хүчин төгөлдөр хуулиараа бид бүхэн бас хүүхдийн тэтгэлэг тэгээд ингээд нэр томьёо үйлчилж байгаа. Энийгээ бас хэвээр нь ингээд үргэлжлүүлээд аваад явж байгаа. Тэгэхдээ яг нэр томьёоны хувьд бол ажлын хэсэг судалгааны хүрээнд хөндөөгүй. Гол нь энийг .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Сандаг-Очир гишүүн тодруулах уу. Тодруулъя.

Ц.Сандаг-Очир: Хуулийн 5.2 эрэгтэй хүн 1 эхнэртэй, эмэгтэй хүн 1 нөхөртэй байна гэж байгаа юм. Энэ бол хууль зүйн асуудал. Яг хөдөө орон нутагт, алслагдсан бүс нутгуудад энэ хуулийн энэ заалт бол бас зөрчигдөж байгаа тохиолдол нийгмийн амьдрал, харилцаа дээр бол байгаа шүү. Гэр бүлийн эгч дүү 2-той суучихсан асуудал ч байж л байдаг. 2 эхнэртэй 1 нь хууль ёсны, 1 нь хууль бусаар ингээд аль аль нь хүлээн зөвшөөрдөг, ингээд явдаг асуудлууд ч байж л байдаг. Ийм тохиолдлууд дээр цаашдаа бас яах ёстой юм. Хуульдаа бол хуульчлаад ингээд заагаад өгчихсөн. Гэхдээ хууль бусаар, албан бусаар гэдэг юм уу яг үнэнийг хэлэхэд амьдрал дээр 2 эхнэртэй байгаа албан ёсны эхнэрээсээ гадна гэр бүл тэжээгээд яваад байгаа ийм хүмүүс байгаа шүү дээ. Бид нар бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ/минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя.

Н.Мягмар: Хуулиар бол Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалаар ч гэсэн, Үндсэн хуульд заасан зохицуулалтаараа ч гэсэн 1 эхнэр, 1 нөхөртэй байна гэдэг энэ агуулга бол энэ хуулиараа зөвшөөрөөд явж байгаа. Тэгээд төрөөс албан ёсоор гэрлэлтийг бүртгэх, цуцлах, асран хамгаалах, харгалзан дэмжих үүрэг зэрэг энэ зүйлүүд дээр бол хүчинтэй гэр бүл дээр л энэ асуудлыг ярьж явж байгаа. Тэгэхээр энэ асуудлаа л цаашид баталгаажуулж ингэж явна. Гэр бүлээс гадуурх харилцаа буюу гэр бүлээ бүртгүүлээгүй, гэрлэлттэй адилтгах харилцааны асуудлыг бас энэ шинэчилсэн найруулгын төсөл дээр бол оруулж ирсэн явж байгаа. Тийм учраас цаашид бас олон улсын гэдэг юм уу, дэлхий нийтэд бас түгээмэл бас болох гээд байгаа нэг асуудал бол гэр бүлээ бүртгүүлэхгүй бас хамтран амьдрах хэлбэр, хандлага байгаад байгаа учраас бас энийг гэрлэлттэй адилтгах зохицуулалтын асуудлыг бол энэ шинэчилсэн/минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Түрүүн тэр хөшүүргүүд гээд их олон төрлийн хөшүүргүүд ярилаа. Ийм хөшүүргүүдээ бид нар журамд юм уу эсвэл хуульдаа яг зааж өгөхгүй бол наадах чинь хүний хүчин зүйлээс хамаараад байгаа шүү дээ. Тийм болохоор тодорхой яг гарах гарцгүйгээр энэ хөшүүргүүд нь үйлчилж байдаг байдлаар энэ

хуульдаа, ер нь бол бид нар журамд заахгүйгээр журмуудыг хуульдаа оруулъя гээд байгаа шүү дээ. Тэгж байж бид нарын энэ зүйл хүний хүчин зүйлээс үл хамаарсан яг бүр тодорхой заалтаар хэрэгжих ийм л нөхцөл бололцоогоор хангагдах гээд байгаа шүү дээ. Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууна.

О.Саранчулуун: Хосууд хамтран амьдраад 3 жил хамтран амьдраад дундаасаа хүүхэдтэй болсон эсвэл үрчилж авсан бол энэ гэрлэлттэй адилтгах харилцаа болох уу. Гэрлэлттэй адилтгах харилцааны жагсаалтад яг энэ байхгүй байгаа болохоор асууж байгаа юм.

2 дугаарт нь гэрлэлт цуцалсны дараах үүсэх тэтгэлэг, санхүүгийн харилцаан дээр асрахуйн асуудлыг яаж оруулж байгаа вэ. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ ээжүүд голдуу асраад явж байгаа. Тэр аав нь бол хүүхдийн тэтгэмж гэдэг дүнгээр мөнгө өгч байна шүү дээ. Гэтэл тэр нь тэр хүүхдийн эм эмчилгээ, сургуульд сурахтай холбоотой, хөгжихтэй холбоотой зардал дээр ерөөсөө төлж дийлдэггүй ийм амьдрал бол хэдэн мянгаараа л байгаа даа. Тэгэхээр энэ асуудал дээр ямар ахиц гарах вэ.

3 дугаар асуудал нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Үндсэн хууль болон Гэр бүлийн тухай хуульд ижил хүйсийн хосуудыг угаасаа гэрлэх боломж, үндэслэл ер нь байхгүй л байгаа шүү дээ том зургаар бол. Гэтэл манай энэ хуулийн шинэчлэл дээр бол оруулж ирсэн байна л даа. Тэгэхээр үүний цаад учир нь яаж тэр Үндсэн хуулиа юм уу эсвэл өөр гэрээ конвенцод байгаа зүйлээ дагаад ингээд өөрчлөх юм уу. Ер нь манайд ЛГБТ хүмүүс ижил хүйсийн гэрлэгчид энэ хуулийг баталсны дараа нэмэгдэх юм уу гэдэг ийм 3 асуулт байгаад байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя.

О.Оюунзул: Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Оюунзул. Таны асуултад хариулъя. 2 дугаар асуулт дээр бол асрахуйн асуудал. Тэгэхээр манай энэ Гэр бүлийн тухай хууль 1999 онд батлагдсан энэ хууль маань өөрөө олон улсдаа ч гэсэн яг гэрлэлт бүртгэх, гэрлэлт цуцлах, тэгээд тодорхой бүтэн өнчин ч юм уу тохиолдлуудад асран хамгаалалт харгалзан дэмжлэг тогтоох, үрчлэх, эцэг эх байх эрхийг хязгаарлах, хасах энэ гол цөм харилцааг зохицуулдаг ийм хувийн эрх зүйн шинжтэй хууль байгаад байгаа. Тэгээд ер нь бол хуулийн төсөлд болон одоо байгаа хууль дээр ч гэсэн гэрлэгчдийн эрх үүрэг дээр ямар ч тохиолдолд хүүхдийг ямар ч хүүхэд байсан гэсэн хүүхэд төрснөөр эцэг эхийн энэ харилцаа үүсэх хүүхдийн өмнө тэжээн тэтгэх, хүүхдээ тэжээн тэтгэх энэ малгай үүрэг нь бол хэвээрээ хадгалагдан явж байгаа. Тэгээд холбогдох бусад салбарын хуулиар энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг дэмжих асуудлуудыг бол зохицуулж өгсөн байгаа. Тэгээд мөн дээрээс нь бас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Гэр бүлийн хөгжлийг дэмжих хуулийн төсөл бас ингээд хамт боловсруулагдаад явж байсан. Араас өргөн мэдүүлэгдэх байх. Энэ хуулийн төсөлд бол яг энэ гэр бүлүүд ийм хүүхдүүдтэй гэр бүл, ганц бие эцэгтэй гэр бүл зэрэг асуудлуудад бол яаж төрөөс дэмжлэг үзүүлэх юм. Энэ харилцааг бол төрийн нийтийн эрх зүйн хүрээнд бол зохицуулж оруулж ирэх юм.

Ж.Бат-Эрдэнэ: Саранчулуун гишүүн тодруулж асууя. Байж байгаарай.

Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийн урилгаар Олон улсын стандартчиллын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Сержио Мужико тэргүүтэй төлөөлөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Би 3 асуулт асуусан. 1 дээр нь л хариулт авлаа. Миний асуугаад байгаа зүйл болохоор шинэ хуулиар бол гэрээгээр зохицуулж болох харилцаа гэж үүсэх юм байна. Тэгэхээр тэр дотор асрахуйн асуудлыг дурдаж өгөхгүй бол яг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ээжийн жишээг зүгээр бодоод үзэхээр гэрээгээр зохицуулж байгаа харилцаан дээр энэ бол огт дурдагдаагүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг би тодруулаад байгаа юм.

Дахиад нэг юм тодруулчихъя. Гадаадад байгаа эсвэл хорих ял эдэлж байгаа биечлэн уулзах боломжгүй, зан үйлийн хувьд асуудалтай ийм тохиолдолд хүүхэдтэйгээ уулзах цаг энэ тэрийг онлайнаар зохицуулж уулзах ийм зохицуулалт ер нь байж болох уу. Уулзахгүй байгаа хүмүүс бол зөндөө л байгаа л даа хүүхдүүдтэйгээ. Тэгэхээр гадаадад байгаа ээж аавуудын хувьд яах юм бэ. Салчихсан, салаагүй нь мэдэхгүй яваад алга болчихсон гэж байна лээ шүү дээ. Тийм ээ. Тэд нарын хувьд ямар зохицуулалт байх вэ. Хүүхэдтэйгээ харилцах харилцаа дээр.

Ж.Бат-Эрдэнэ: Отгоны Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг.

Н.Мягмар: Саранчулуун гишүүний асуултад тодруулъя. Гэрээгээр зохицуулах харилцаа гээд энд бол гэрлэлтийн гэрээний асуудлыг та ярьж байх шиг байна. Тэгээд гэрлэлтийн гэрээний асуудал тусгаж болох зохицуулалтууд болон тусгахыг хориглосон, өөрөөр хэлэх юм хориглосон зүйл дээр бол тэжээн тэтгэх буюу гэрлэгчдийн тэжээн тэтгэхтэй холбоотой үүргээ хязгаарласан ч гэдэг юм уу ийм зүйлийг хориглоно гээд ингээд тодорхой заагаад өгчихсөн байж байгаа. Тэгэхээр гэр бүл цуцалсан тохиолдолд хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг бол ямар ч тохиолдолд тэр үүргээс бол чөлөөлөгдөхгүй. Энэ хуулийн зарчим. Тийм учраас хүүхдийг асрамждаа авч үлдсэн хүн маань гэр бүл цуцлуулсан нөгөө хүнээсээ хүүхдийн тэтгэлэг гаргуулах энэ бололцоог шүүх бол шийдвэрлээд явчихна. Хүүхэдтэй уулзах асуудал бол шүүхийн шийдвэр дээрээ бас энэ хүүхэдтэй уулзах .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя. Шүүхийн шийдвэр дээр энэ хүүхэдтэй уулзах цаг, хуваарь энэ тэрийг бол шүүхийн шийдвэрээрээ заагаад өгчих юм. Энэ хуулиараа. Дараагийн Гэр бүлийн процессын хууль дээр бол энэ түлхүү нарийвчлагдаад зохицуулагдсан байж байгаа. Тэгэхээр гадаадад байгаа гэрлэгчид гэр бүлээ цуцлуулах гэдэг юм уу энэ тохиолдолд цахимаар дипломат төлөөлөгчийн газар байгаа газраас оролцох энэ хэлбэрээр жишээ нь гэрлэлт цуцлуулсан тохиолдолд хүүхэдтэйгээ уулзах хэлбэр энэ тэрийг шүүхийн шийдвэртээ хугацаа, давтамж, ямар байдлаар уулзах юм гэдгийг нь тодорхой зааж өгөх юм байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Баярлалаа. Яах вэ, гэрээгээр шийдэж болно гэдэг нөхцөл дээр болно гэхихсэн байгаа байхгүй юу. Тэгэхээр гэрээгээр шийдэж болохгүй байгаа асуудал дээр яах юм бэ л гээд байгаа байхгүй юу. Гэрээгээ шийдэх боломжгүй.

Асрахуйн хөдөлмөр гэдэг чинь нөгөө хүүхдийн тэтгэмж. Хүүхдийн тэтгэмж чинь сургуулийнх нь зардалд нь л арай чүү гэж хүрч байгаа. Бараг сарын хоолны мөнгөнд нь л арай чүү хүрч байгаа дүн байгаад байгаа шүү дээ. Одоо байгаа дүнгээр харахаар. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд онцгой их асуудлууд байдаг. Тэгээд энэ дээр чинь хүүхэд асарч байгаа байхгүй юу. Асрахуй чинь өөрөө бүр ажил байхгүй юу. Тэгэхээр энэ ажлын харилцаан дээр яах юм бэ. Энийг яаж тусгах вэ гэдэг л юмыг би асуугаад байгаа юм. Тэгэхээр одоо байгаа хүүхдүүдээ хайхрахгүй байгаа, орхиод явчихсан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ээжүүд, өрх толгойлсон аавуудад энд ямар ахиц гарах юм бэ. Ямар өөрчлөлт байх бол. Энэ дээр мэдээлэл өгөөч ээ.

Тэгээд 3 жил хамт амьдраад дундаасаа хүүхэдтэй болчихсон хүмүүс гэрлэлттэй адилтгах харилцаатай болох уу, үгүй юу.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя.

О.Оюунзул: Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Оюунзул. Таны асуултад хариулъя. Хөгжлийн бэрхшээлтэй, хүндээр өвчилсөн, байнгын асаргаа шаардлагатай, сургуульд орсон зэрэг онцгой тохиолдолд тэтгэлэг төлөгчөөс бол нэмэлт тэтгэлэг зардлыг гаргуулж болохоор бол хуулийн төсөлд тусгаж өгсөн. Тэгээд дээрээс нь таны өмнөх асуулт дээр 3 жил хамтран амьдарсан тохиолдолд гэрлэлттэй адилтгаж үзэх үү гээд асуусан. Энэ асуултад хариулахад хуулийн төслөөр бол 5-аас дээш жил 1 хаягт хамтран амьдраад, дундын хөрөнгөтэй болсон. Гэхдээ аль ч хамтран амьдрагч маань өөр өөр хүнтэй гэрлэлтээ бүртгүүлээгүй байгаа тохиолдолд тэр хамтын амьдрал нь дуусгавар болоход зөвхөн дундын хөрөнгөө хуваахад л энэ хуулийн төслөөр гэрлэлттэй адилтгаж үзэж байгаа. Тэрнээс бусад асуудлаар бол гэрлэлттэй адилтгаж үзэж байгаа зүйл байхгүй. Гэхдээ мэдээж хэрэг хамт амьдарч байгаа гэрлэлтээ бүртгүүлээгүй ч бай гэрлэлтээ .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Хариултууд чинь ер нь бол хуулиасаа гадуур тийм ярилцлага маягтай л яваад байх юм. Яг яаж хэрэгжих гэдэг юм чинь хуульдаа, журамдаа заасан байж байж наадах чинь хэрэгжинэ шүү дээ. Түүнээс биш та хэдийн санал дүгнэлтээр явахгүй. Цаана чинь хэрэгжүүлж байгаа хүмүүс нь шал ондоо. Хэрэгжүүлж байгаа нөхцөл нь ондоо. Тэгээд хүний хамааралгүй ийм нөхцөл байдлыг бид нар бий болгох гэж л энэ журам, хууль 2-ыг чинь хийгээд байгаа шүү дээ. Хүрэлбаатарын Баасанжаргал.

Х.Баасанжаргал: Би дахиад Саранчулууны асуултыг давъя. Тэгээд манай ажлын хэсгийнхэн хариулах байх. Тэгээд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бас хариулах байх. Тэгээд бас л ялгаа байхгүй нөгөө ажил хэргийн харилцаан дээр ч гэсэн жендерийн эрх тэгш байдлыг хангана гэсэн ганц байгаа эмэгтэйдээ л та хэд маань урагш нь түлхээд байх юм. Бусад ажлын хэсгийнхэн бас нэмээд хариулаад өгөөсэй гэж хүсэж байна. Асуултдаа орёе.

Хүүхдийн эрхийн асуудал дээр би нэлээн түлхүү асуултаа асууя. Хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд байх талаар заалт энэ удаагийн хуульд яагаад

орсонгүй вэ. Яах вэ, хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол, хүүхдийн дээд ашиг сонирхол 2 ялгаатай ойлголт. Энийг л хэлэх гээд байгаа юм гэсэн үг. Тэгэхээр энэ 2-ын ялгааг бид нар энэ Гэр бүлийн хууль дээр гаргаж ирэхгүй бол бусад хууль тогтоомж дээр ер нь гарахад аягүй хэцүү. Өөрөөр хэлбэл түрүүн Саранчулуун гишүүн асуугаад байна л даа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ээж хүүхдээ асраад үлдчих юм бол тэтгэлгийн асуудлыг жишээ нь 2 дахин илүү байхаар шууд хууль дээр тэгж тогтоогоод бичиж болох уу л гэж асуугаад байгаа гэсэн үг. Энэ тохиолдолд хүүхдийн дээд ашиг сонирхлоо эрхэмлээд ийм шийдвэр гаргах бололцоо шүүхэд байгаа юу. Энэ хуулийг хэрэглээд одоогийн байгаа хуулийн төслийн хүрээнд боломжтой юу. Эсвэл шууд хууль дээрээ маш тодорхой энийг заах уу. 1 дэх асуулт.

2 дугаар асуудал. Хүүхэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхээс гадна хүүхэд сонсогдох эрхтэй байх гэдэг ийм эрхийн асуудал байдаг. Тэгээд хүүхэд өөрөө гэр бүлийн харилцаанд тухайн асуудалд өөрөө байр сууриа илэрхийлэх хамгийн гол нь байр сууриа илэрхийлэхээс гадна тэр нь өөрөө шийдвэр гаргалтад нөлөөлдөг байхыг л хэлээд байгаа юм. Нөгөө сонсогдох гээд байгаа асуудал нь. Тэгэхээр хүүхдийг яг бодитойгоор жинхэнээсээ сонсдог байх механизм яг энэ Гэр бүлийн хууль дотор орж байгаа юу гэдэг ийм 2 дахь асуулт.

3 дугаарт хүүхдийн асран хамгаалалттай холбоотой ийм 2 асуулт байгаа. Ер нь шүүхээс гэр бүл цуцлаад, хүүхдийн асран хамгааллыг тогтоохдоо хүүхдийн байнга оршин суух хаягийг тогтоох гол зорилготой л ер нь бол манай шүүхийн шийдвэрүүд гарч байгаа. Бид нар бүгдээрээ сайн мэдэж байгаа. Яг нөгөө хүүхэдтэй уулзах уулзалтын талаар нарийн ширийн зохицуулалтууд шүүхийн шийдвэр дээр төдийлөн дурддаггүй. Мэдээж нэхэмжлэгч шүүхэд нэхэмжлэл гаргаагүй бол дурдахгүй байгаа гэдгээр бол бас өнөөдрийг хүртэл хаацайлж ирсэн. Энэ цаашаа засагдах уу.

Дээрээс нь энэ гэр бүлээс гадна эцэг эхээс гадна бусад эмээ өвөө нь хүүхэдтэй уулзах тэр боломжийг шүүх энэ удаагийн хуулиар нээж өгөх үү. Саяхан цахимаар яваад байсан. Эмээ өвөө нь хүүхэдтэйгээ уулзаж чадахгүй, харамсалтай нь охин нь нөхрийнхөө гарт амь үрэгдчихсэн ийм асуудал яваад байгаа. Тэгвэл үүнтэй адилхан энэ асуудал жишээ нь шийдэгдэх үү. Энэ удаагийн хуулиар.

3 дугаарт би дахиад асууя. Энэ нөгөө дотуур байрны асуудал. Та хэд маань Байнгын хорооны хурлаас хойш бас судлаад ч юм уу, дотроо ярилцаж үзсэн болов уу гэдэг асуулт. Дотуур байранд байгаа хүүхдийн асран хамгааллын асуудлыг хувилбарт асран хамгааллын үйлчилгээ гэдэг ангилал руу оруулах боломжтой юу. Одоо бид нар өөрсдийнхөө хүүхдээр төсөөлөөд үзье л дээ. 6, 7 настай хүүхдээ бид нар дотуур байранд амьдруулж байгаа. Багш нь дотуур байрны багш би асран хамгаалагч нь биш гээд зогсож байдаг. Энэ ер нь байж болох уу. Яг нөгөө хүүхдийнхээ нүдээр хэдүүлээ харъя л даа. Энэ өөрөө байж болох уу, хэвийн үү. Тэгэхээр бид нар энэ дээр өөрсдийн гэсэн онцлогтоо тохирсон шийдэл байж болох уу гэдэг дээр ажлын хэсэг дотроо ярилцсан болов уу. Байнгын хорооны хурлаас хойш.

Тэгээд хамгийн сүүлд хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүл болох, хүүхэдтэй болох, хүүхэд үрчилж авах харилцаанд үүссэн ялгаварлан гадуурхалтыг энэ удаагийн хуулиар засаж байгаа юу. Өмнөх хуулиасаа одоогийн байгаа хуулиасаа гарч байгаа ахиц дэвшлийн л тухай яриарай. Тэрнээс биш одоогийн байгаа заалтыг бол бид нар бүгдээрээ сайн мэдэж байгаа.

Тэгээд хамгийн сүүлд гэр бүлийн хөрөнгийн зохицуулалт дээр гарч байгаа өөрчлөлт ахиц дэвшил юу байгаа вэ. Дундын хөрөнгийн асуудал, хуваарьт хөрөнгийн асуудал. Одоогийн байгаа хуулиас ялгаатай байгаа, өөрөөр зохицуулагдаж байгаа ямар /минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя. Өөрийгөө танилцуулаарай.

М.Цогтбаатар: Цогтбаатар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ахлах шинжээч. Гишүүний асуултад хариулъя. Энэ хууль дээр хүүхдийн дээд эрх ашгийг хамгаалах талаар манай 2024 онд хэрэгжиж эхэлсэн Хүүхдийн эрхийн тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хуулиар энийг нарийвчилж зааж өгсөн. Дээр нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал дээр асрахуйн эдийн засгийг ярьж байна. Асрахуйн эдийн засгийн асуудал Баясгалан гишүүн бас санаачилсан Асрахуйн тухай хууль төслийн хэмжээнд явж байгаа. Дээр нь энийг Нийгмийн халамжийн хуулиар зохицуулахаар бид бүхэн өргөн барихаар энэ хуулийн төслөөр зохицуулахаар ажиллаж байгаа. Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зүгээс Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийг өргөн барихаар үзэл баримтлалыг батлуулахаар явж байна. Тэгэхээр энэ хуульд ч гэсэн мөн адил энэ хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүл болон ахмад настан, тэдгээрийг асрах үйлчилгээнд зарцуулж байгаа хөлс хүчийг тэтгэвэр тооцдог болох, энэ дээр бас нэмэлт төрийн дэмжлэг үйлчилгээг үзүүлдэг байх энэ зохицуулалтуудыг бас шинэ хуульд оруулж ирсэн. Одоо өргөн барьсан хуулийн 51 дүгээр зүйлд бас мөн нэмэлт тэтгэлэг хэмжээг гаргаж өгөх талаар нарийвчлан заасан байгаа. Хуулийн төсөлд байгаа гэдгийг бас нэмж хэлмээр байна.

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулах уу. Асуулт дутуу байна уу.

Н.Мягмар: Баасанжаргал гишүүний дутуу зарим асуултуудад нь хариулъя. Хүүхдийн дуу хоолой сонсогдох эрхийн асуудал гээд асууж байна. Энэ шинэчилсэн найруулгаар болон одоо байгаа хүчин төгөлдөр хуулиудаар ч гэсэн гэр бүлийн орчинд байгаа нөхцөл байдлыг нь шинжилж, гэр бүл цуцлах үед болон хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэх, мөн хүүхэдтэй холбоотой асуудлаар шүүхээс шийдвэр гаргахын өмнө 7-оос дээш насны хүүхдийг саналыг нь нөхцөл байдлын шинжээчийн хүрээндээ тайлан юмандаа тусгаж энэ шүүх шийдвэртэй хүүхдийн дуу хоолойг сонсох нөхцөл зохицуулалтууд хуульд бол орж ирсэн байгаа.

Дотуур байртай холбоотой Байнгын хороон дээр асуугдсан асуулт Гэр бүлийн хуулийн энэ зорилго, зохицуулах харилцаанд яг энэ дотуур байрны асуудал бол хамаарахгүй байгаад байгаа .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Нэмж, гүйцээж хариулъя.

Н.Мягмар: Энэ хуулиар зохицуулах харилцааны хүрээнд бол хамаарахгүй байгаад байгаа учраас энд тусгаагүй байж байгаа. Энэ маань бол Хүүхэд хамгааллын хууль, Боловсролын хууль, бусад хуулиудаараа энэ дотуур байртай холбоотой тэр стандарт, мөн хараа хяналт тавих, багш, сурган хүмүүжүүлэгчдийн хүлээх хариуцлага гээд энэ зүйлүүд нь өөр хуулиар зохицуулагдаж байгаа учраас Гэр бүлийн хуулийн зохицуулах харилцаанд бол энэ орж ирэхгүй байгаа. Энэ маань бол илүү гэр бүлийн гэрлэлт бүртгэх, тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой гэдэг юм уу, гэр бүл цуцлах, мөн цуцалсан тохиолдолд хүүхдийн тэтгэмж, эцэг тогтоох ч гэдэг

юм уу энэ яг хувийн эрх зүйн харилцааны асуудлыг зохицуулсан хуулийн төсөл байж байгаа.

Эд хөрөнгийг хуваахтай холбоотой асуудал дээр бол дундаа хамтаар өмчлөх, хөрөнгийг хуваах асуудал дээр бол ялангуяа гэрлэгчдийн хэн буруутай этгээд .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя.

Н.Мягмар: Хөрөнгийг хуваарилах, дундаа хамтран өмчлөх, хөрөнгийг хуваах асуудал дээр бол буруутай этгээдэд бас хариуцлага ноогдуулах гэдэг юм уу энэ хүрээндээ шүүх бол өөрөөр тогтоох бололцоог энэ Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дээр бол шүүхэд бол энэ эрхийг нь олгосон зохицуулалт орж ирж байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Баасанжаргал гишүүн тодруулж асууя.

Х.Баасанжаргал: Саранчулуун гишүүн бид 2-ын асуугаад байгаа тэр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй тохиолдолд гээд энэ нийгмийн халамжаас тусдаа байхгүй юу. Тусад нь асуугаад байна. Нийгмийн халамжийн асуудал чинь бүр тусдаа харилцаа. Яг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүд салах тохиолдолд тэр тэтгэлгийн асуудал дээр ялгамжтай байдлаар зохицуулах боломжтой юу. Эсвэл хууль дээр шууд тодорхой заах нь илүү оновчтой юу. Үүнийг та хэд ер нь яг судалж үзсэн үү гэж л асуугаад байгаа юм гэсэн үг. Нийгмийн халамжаас чинь тусдаа. Баясгалан гишүүний асрахуйтай холбоотойгоос бас тусдаа асуудал. Яг гэр бүлийн харилцаанд яг энэ асуудлыг үүрэг хариуцлага нь өөрөө яаж хуваагдаж, яаж оногдох юм бэ л гэж асуугаад байна гэсэн үг.

2 дугаарт тэр юуны асуудал байна. Дотуур байрны асуудлыг яг манайхан ингэж маш олон жил энэ гэр бүлийн харилцаанд хамаарахгүй гэж ирсэн. Би өмнө нь хэлж байсан НҮБ-аас хүүхэд 24 цагаас дээш хугацаагаар өөрийнхөө гэр бүлээс гадуур, хол эцэг эхийн асран/минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Нэмэлт 1 минут өгье. Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Өөрийнхөө эцэг эхийн асран хамгааллаас хол, 24 цагаас дээш хугацаа өнгөрсөн тохиолдолд хүүхдийн асран хамгаалал өөрчлөгдсөн гэж үзэж тухайн улс орон бодлого шийдвэр, хууль, дүрэм журамдаа хүүхдийн асран хамгааллын эрхийн асуудлыг анхаараач ээ л гэдэг ийм зөвлөмж өгөөд байгаа юм НҮБ-аас. Тайлбар нь бас ингэж гараад байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө бид нар нөгөө уламжлалт яг л нөгөө гэр бүл гэдэг ойлголтоороо бид нар хармааргүй л байна гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр хэдүүлээ дахиж л нэлээн нарийн ярих хэрэгтэй байх. Одоо хариулахгүй байх. Хариулахгүй байж болно гэж бодож байна. Хариултыг бол ойлгомжтой авчихлаа.

Тэр гэр бүлийн тухай хуулийг тэгэхдээ бид нар зөвхөн гэрлэлт цуцлах үед хэрэглэдэг хууль гэж ойлгож болмооргүй байгаа юм. Миний асуугаад байгаа бас олон асуултууд гэр бүл бүртгүүлэх үеийнх, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, хамгийн сүүлд гэр бүл цуцлах тохиолдолд гээд энэ ялгаа заагуудыг бид нар бас аягүй сайн ялгаж зааглаж, тэгээд энэ хууль.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Хариулт авах уу. Болчихсон юм уу. Мягмар дарга аа, хажууд чинь газрын дарга чинь байж байна. Уг нь та хэд энэ хуулийг чинь бараг л нэг нэггүй үзчихсэн өөрсдөө бараг л биччихсэн юм байгаа биз дээ. Бичсэн хүмүүс шүү дээ газрын дарга гэдэг чинь. Тэгээд хэрвээ заалтад байхгүй, журам чинь байхгүй байгаа бол өөр бусад хуульд яаж яаж зохицуулах юм гэдгийг өнөөдөр магадгүй тэмдэглэж аваад, дараа нь ажлын хэсэг дээр наадуулаа илүү суулгах ийм л ач холбогдолтой юм байгаа шүү дээ. Та хэдийг заавал мэдэхгүй юмыг чинь, бусад хуульд байхгүй заалтыг чинь хэлүүлэх гээд байгаа юм биш шүү дээ. Гарах гаргалгаа заалт хэрвээ шаардлагатай бол энэ гишүүдийн амьдрал дээр байгаа зүйлүүдийг хаана нь ямар хуульд яаж заах юм гэдгийг чинь л яамны газрын дарга нар та нар чинь шийддэг шүү дээ, мэддэг шүү дээ уг нь бол. Тэр өнцгөөсөө арай л дутуу хариулаад байх шиг санагдах юм. 4 номер.

Н.Мягмар: Тэр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой тэтгэлгийн асуудал дээр гээд энэ 51 дүгээр зүйл дээр байгаа юм. Энийг шүүхэд эрхийг нь олгочихсон юм. Заавал юу гэдэг юм, амьжиргааны түвшнийг нь 2 дахин нэмэгдүүл гээд хатуу заах гэхээсээ илүү тэр хүүхдийн хэрэгцээ шаардлага, тэрэнд хүрэлцэхүйц байх энэ агуулгаараа бол нэмэгдэл тэтгэмж тогтоож болно гээд ингээд 51.1 дээр заагаад өгчихсөн зохицуулалт байгаа байхгүй юу. Шүүх энийг шийдэх бололцоотой юм. Тэгэхээр тэр 3 дахин нэмэгдүүлнэ үү, яана уу энэ бол хүүхдийн эрх ашгийг хангасан дагнасан шүүхтэй болсны ач холбогдол энэ юм. Тэгэхээр энэ Гэр бүлийн хууль дээр бусад хуулиар гэр бүлийн хөгжлийг дэмжих гэдэг юм уу тэтгэмж урамшуулалтай холбоотой бусад хуулиар зохицуулах харилцааг энэ гэр бүлийн хууль дээр бүгдийг нь оруулж ирж базаж зохицуулна гэх юм бол боломжгүй гэж ингэж харж байгаа юм. Тэгэхээр өөр бусад хуулиуд байгаа учраас энэ хуулиудаараа энэ нарийвчилсан зохицуулалтаа хийх ёстой..../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Үнэхээр шаардлагатай гэж үзвэл дагалдах хуульд оруулж болно шүү дээ. Энэ асуудлыг зохицуулахын тулд. Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна.

С.Одонтуяа: Энэ 1999 оны хууль гэхээр үнэхээр шинэчилсэн найруулгыг бол бид нар заавал батлах ёстой гэж бодож байна. Өмнөх 4 парламентад энэ хууль яригдсан. Тэгээд ерөөсөө батлагддаггүй. Тэгээд л хараад ажлын хэсэг юм уу хараад байх нь эрэгтэй гишүүд их гацаадаг юм. Яагаад байдаг юм. Тэтгэмж төлөхөөс зайлсхийдэг юм уу, аминдаа эмэгтэйчүүдийг хохироогоод байна гэж боддог л байх. Гэхдээ энэ чинь хүүхдүүдээ л хохироож байгаа шүү дээ. Аль 10 жилийн өмнө баталчихсан байсан бол өнөөдөр маш олон хүн хохирохгүй л байх ийм боломж байсан юм. Тэгэхээр энэ Улсын Их Хурал өөрөө хариуцлагатай байх шаардлагатай л гэж хэлмээр байна.

Энэ статистикаас 1 зүйл асууя. Сая энэ статистикийн дүн дээр өрх толгойлсон аав ээжүүдийн тоо эрс буурчихсан ийм тоо байна л даа. Тэгэхээр энэ уг нь их сайхан мэдээ байна. Гэхдээ гэр бүл салалт жилд өсөн нэмэгдээд байгаа үед яаж өрх толгойлсон аав, ээжүүдийн тоо ингэж их хүчтэй буураад байгаа юм бол. Энэ ямар бодлого явуулсан юм. Яаж энэ тоо гарсан юм бол гэдгийг асууя. Жишээлэхэд 2019 онд 86,822 өрх толгойлсон гэр бүл байхад одоо 66 мянга болчихсон байж байгаа юм. Тэгэхээр яах вэ тоог нь харахад сайхан байна. Энэ алдаа юу эсвэл энэ ямар бодлогын үр дүн бэ гэдгийг асууя.

3 дахь асуулт бол энэ албан ёсны гэрлэлтийн баталгаагүй хэр нь энэ залуучууд бас хүүхэдтэй болдог. Тэгэхээр энэ үед ямар харилцаа зохицуулахаар орсон байгаа вэ. Баталгаагүй болохоор тэтгэмж энэ тэр төлөхгүй юу, төлөх ёстой юу. Энийг асууя.

Би 2016-2020 онд манай Ардчилсан эмэгтэйчүүдийн холбоо улс орон даяар бид нар хэлэлцүүлэг хийсэн байгаа юм. Ер нь энэ Гэр бүлийн хууль дээр ямар санаа оноо байна гээд. Манай эмэгтэйчүүд энэ дээр мэдээж олон санал хэлсэн. Ганц санал бол бараг бүх газар давтагдаж байсан. Энэ ямар санал вэ гэхээр гэр бүл салсны дараа ялангуяа ээжүүд энэ шүүхийн шийдвэр гартал маш олон жил явдаг. Шүүхийн шийдвэр гарчихсаны дараа тэтгэмжээ авах гэж бас шүүхийн шийдвэртэй их олон жил болдог. Ингэсээр байтал хүүхэд нь том болчихдог. Тэгэхээр яг гэр бүл салсны маргаашаас л энэ хүүхэд д чинь хоол иднэ, хувцас өмсөнө, зардал гарна. Тэгэхээр энэ ингээд шууд эрсдэл үүсэж байгаа учраас энэ эрсдэлийг бид нар яаж зохицуулахаар байна вэ. Би ойлгочихлоо. Аль болохоор шүүхийн шийдвэр дээр тэр аав хурдан гаргуулах барих, түргэвчлэх гээд заалтууд орсон байна л даа. Гэхдээ энэ үүсчихсэн байгаа бодит эрсдэлийг яаж бууруулах юм бэ. Тэгэхээр ээжүүдээс гаргаж байсан санал юу байсан бэ гэхээр эрсдэлийн сан гээд улс байгуулчхаж болдоггүй юм уу. Тэгээд ямар ч дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу ийм ээжүүдэд бас энэ эрсдэлийн сангаасаа эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр энэ санг байгуулаач ээ гэдэг ийм санал бол ерөөсөө бүх газруудаас бол гарч байсан юм байгаа юм. Тэгээд энэ дээр яг ямар хууль, эрх зүйн зохицуулалт орсон бэ гэдгийг асуумаар байна. Ер нь яах вэ бусад оронд бол ийм эрсдэлийн сан байдаг юм байна лээ. Тэгээд эндээс нь яах аргагүй шаардлагатай хүмүүст бол эргэн төлөгдөх нөхцөлөөр олгодог. Тэгэхээр Үндсэн хуулийн 16.11-д бол хүүхэд төрийн хамгаалалтад байна гээд заачихсан байгаа. Тэгэхээр энэ эрсдэлийг бид нар бас хариуцаж анхаарахгүй бол энэ хүүхдүүд чинь гараад л хулгай хийж байна, зарим нь гэмт хэргийн золиос болж байна. Тэгэхээр энэ эрсдэлийг ер нь яаж харж байгаа вэ гэдгийг асуумаар байна.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя.

Н.Мягмар: Одонтуяа гишүүний асуултад холбогдох хэсэгт нь хариулъя. Гэр бүл, хөдөлмөрийн яамны төлөөлөл маань тэр өрх толгойлсон аав ээжүүдийн тоо буурч байгаатай холбоотой хариултыг өгөх байх.

Албан ёсны бүртгэлгүй хүүхэд тэтгэлэг авахтай холбоотой асуудал байна. Хүүхэд бол төрсөн цагаасаа эхлээд тэжээн тэтгүүлэх ёстой гэдэг хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах хүрээнд энэ Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулга маань боловсруулагдаж орж ирж байгаа учраас тэтгэлэг авах энэ эрхийг баталгаажуулж өгч байгаа юм. Тэгэхдээ юу гэдэг юм албан ёсны бүртгэлгүй боловч хүүхэд төрсөн тохиолдолд тэр хүүхэд маань хэнээр овоглох вэ, хэний нэрийг авах вэ гэдгээсээ хамаараад энэ асуудал бол шийдэгдэж байгаа юм. Тэгэхдээ юу гэдэг юм, хэрвээ эцэг нь хүүхдээ өөрөөрөө овоглохыг хүсэхгүй тохиолдолд эх бол эцэг тогтоолгох хүсэлтийг шүүхэд гаргаад, энэ тусгай журмыг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлүүлчихсэн тохиолдолд эцгээр нь тогтоолгосон тохиолдолд тэр эцгээс бол тэжээн тэтгүүлэх хүсэлтийг гаргаж энэ тэтгэлэг тогтоолгох энэ боломж нь бүрдэж байгаа. Таны дурдсан тэр эрсдэлийн сантай холбоотой асуудал дээр ялангуяа өрх толгойлсон ийм эмэгтэйчүүд маань гэр бүлд шаардлагатай зардал гэдэг юм уу энэ зүйлүүд дээр төрөөс ямар дэмжлэг урамшуулал олгох вэ гэдэг энэ асуудал дээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулж байгаа Гэр бүлийг дэмжих хуулийн төсөл дээр тодорхой зохицуулалтууд орж ирэх

болов уу гэж ингэж тооцож байна. Үзэл баримтлалыг нь бол Хууль зүй, дотоод хэргийн яамнаас дэмжээд баталчихсан. Ингээд боловсруулагдаад явж байгаа. Энэ Гэр бүлийн хууль дээр яах вэ, гэр бүл цуцлаад, тэтгэлэг тогтоогоод, тэтгэлэг төлөх ёстой тэр үүрэг байж байгаа аав гэдэг юм уу, ээж нь ч гэдэг юм уу энэ хүмүүс маань бол хэрвээ төлбөрийн чадваргүй байх юм бол Засгийн газрын тусгай сангийн одоо байгаа хуулийн зохицуулалтад байгаа Хүүхдийн төлөө сан гэж байдаг. Засгийн газрын тусгай сан. Тэгээд энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэх багц хуулийн хүрээнд бол хүүхдийн төлөө сангаас амьжиргааны доод түвшнээр нь төлбөрийн чадваргүй хүүхдийн тэтгэлэг төлөх үүрэг хүлээсэн хүмүүсийн тэтгэлгийг түрүүлээд олгож байя. Эргээд нөгөө хүнээс нь нөхөн төлүүлье гэдэг зарчмаар Иргэний болон захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэлийн хуулийн төсөлд энэ зохицуулалт орж ирчихсэн явж байгаа. Тэгэхээр энэ маань Их Хурал дээр хэлэлцэх эсэх нь дэмжигдээд, цаашаа хэлэлцүүлгийн шатандаа батлагдчихвал энэ Хүүхдийн төлөө сангийн зориулалтыг нь бас энэ чиглэл рүү оруулахаар өөрчлөлт хуулийн төсөлд тусгагдаад орж ирчихсэн байгаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийнхэн маань зөвхөн гишүүддээ хариулж байгаа биш, олон нийт бас их мэдээлэл авч байгаа шүү дээ. Энэ өнцгөөс нь бас хариулаарай. Түүнээс биш гишүүд маань юмаа уншаагүй, амьдрал мэдэхгүйдээ биш шүү дээ. Ямар вариантууд ямар кэйсүүд байна гэдгийг л асуугаад байгаа шүү дээ.Тодруулах уу. Болсон уу. Нэмэлт хариулт 4 номер.

М.Цогтбаатар: Гишүүний асуултад хариулъя. Цогтбаатар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. Өрх толгойлсон эцэг эхтэй өрхийн тоо 2020 онд 86 мянга, 2021 онд 84 мянга, 2022 онд 81 мянга, 2023 онд 66813 болсон. Энийг бид бүхэн бас тухайн үед Үндэсний статистикийн хорооноос бас тодруулсан. Энд өмнө нь бол асуулгынхаа аргачлалыг тухайн үедээ өөрчлөөд, 2023 оноос эхлээд яг регистрийн дугаараар нь нэг бүрчлэн тулгаж, мэдээллүүдээ цуглуулсан. Аргачлал өөрчлөгдсөнтэй холбоотой 2023 оноос хойших мэдээлэл яг энэ бодит мэдээллүүдээрээ ингэж гарч явна гэсэн мэдээллийг өгсөн байгаа.

Аргачлалыг бол Үндэсний статистикийн хороо өөрсдөө баталдаг ийм байгаа юм. Дээр нь би бас зарим тайлбарыг хэлье. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийг ингээд өргөн барьж байгаа. Тэгээд Орон сууцын дэмжлэг үзүүлэх, татвар .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Одонтуяа гишүүн нэмж тодруулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ хариултуудаас харахаараа яг нэг ийм хариултууд их яваад байна л даа. Одоо тэр Гэр бүлийн хөгжлийн тухай хууль орж ирэх гэж байгаа. Тэрүүгээр ихэнх нь зохицуулагдана ч гэдэг юм уу. Эсвэл Хүүхдийн төлөө сангаас ч олгох ч юм шиг. Ингээд бусад хуулиуд руу энэ чихэгдээд байна л даа. Тэгэхээр ер нь энэ хууль чинь өөрөө гол малгай хууль учраас энэ хуулийг хэлэлцэх эсэх нь дэмжигдсэний дараа энэ бусад хуультай бүгдтэй уялдуулж бас энийг ажиллах ёстой гэж үзэж байна. Жишээлэхэд Алтангэрэл сайдын өргөн барьж байсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль байгаа. Энэ хуулийг бид нар бас оролцуулж энд хийж байж энэ хуулийн чинь гол амин сүнс болно. Яг тэр шүүхийн шийдвэрийг хэрхэн хурдан биелүүлэх яах юм. Энэ бүх зүйл тэгэхээр энийг ерөөсөө их олон хуультай уялдуулж л баталмаар санагдаж байгаа. Хүүхдийн эрхийн тухай хууль байна. Хүүхэд .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу. Яг сая Одонтуяа гишүүний хэлсэнчлэн бусад хуулиуд руу оруулах ёстой шүү дээ. Татаж авчирч энэ рүүгээ зохицуулалт хийхгүй бол зөвхөн нэг хуульдаа барьчихаар наадах чинь болохоо байчихаад байна шүү дээ. Зохицуулалт дутаад байна. Гомбын Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. Энэ эрх баригч намын зодоон одоо болтол дуусаагүй юм уу. Хаашаа юм бэ. Энэ чуулганыхаа ирцийг хар л даа. 126 хүнээс энд чинь 20 гаруйхан хүн сууж байна шүү дээ. Тэгээд дээрээс нь олон хүмүүс энд тэндээс гишүүдийн урилгаар гээд л тэнд хүмүүс гарах юм. Сая баахан хүүхдүүд орж ирлээ. Үдээс өмнө 3 хүн урилгаар ирлээ, үдээс хойш бас 3 анги ч юм уу. Энийг ингээд харах юм бол ичмээр байна шүү дээ. Одоо яг энэ дотор 15 хүн л байна шүү дээ. Тэгээд нөгөө хууль хэлэлцэх, хиам хийх 2-ыг битгий хар гэдэг шиг л юм болж байна шүү дээ.

Асуулт, санал 2-оо хамт явчихъя гэж бодож байна. Миний асуултууд яг ингээд ийм хууль хэлэлцэх гэж байгаа гээд би өөрийнхөө пэйж, фэйсбүүк дээр тавиад яг энэ бүсгүйчүүдээс голдуу ирсэн асуултууд байгаа. Тодорхой хариулаарай. Та нарын асууж байгаа, хариулж байгаа 2 чинь, дээрээс нь ялангуяа хариулж байгаа чинь бол арай дэндүү байна шүү. Тэгээд энийгээ бас тэмдэглэж аваад, энэ хуулийнхаа хэлэлцүүлэгт анхаараарай гэж хүсэх байна.

1 дүгээрт амьдрал дээр их гардаг жишээ гэнэ. Эхнэр нь эсвэл нөхөр нь гадагшаа яваад, тэгээд тэндээ очоод 1 хүнтэй суучихдаг. Эсвэл салчихсан мөртөө, тусдаа байгаа мөртөө Монголдоо байгаа эсэх нь мэдэгдэхгүй. Тэгээд аль аль нь тусдаа гэр бүлтэй болчихсон мөртөө гэр бүлээ цуцалъя гэхээр нь шүүх хариуцагч нь байхгүй гээд нэхэмжлэхийг нь хүлээж авдаггүй. Яг ингээд миний чатад хэд хэдэн бүсгүйчүүдийн ийм юу байж л байна л даа. Тэгээд эсвэл Монголдоо хаа байгаа нь мэдэгддэггүй. Тэгээд нөгөө нэхэмжлэлийг нь хүлээж авдаггүй учраас дараагийнхаа гэр бүлтэй болчихсон байдаг. Тэгээд гэрлэлтээ батлуулах гэхээр өмнөх гэрлэлтээ салга, цуцал гээд байдаг. Хүүхэд өргөж авмаар байдаг. Хүүхэд өргөж авъя гэхээр заавал нөгөөдөх нь гэрлэлт нь баталсан байдаг. Энэ асуудлыг яаж шийдэх юм бэ. Энэ дээр чинь тодорхой бас D-Parliament дээр тавьсан юмнуудыг хараад л байгаа юм шиг байна. Яг энэ дээр тодорхой зохицуулалтууд харагдахгүй байна шүү дээ. Тэр хуулийн чинь заалтад бол тэр хуулийн төслийн 14.1.2-т нь гэрлэгчид сүүлийн 5 жилээс доошгүй хугацаанд хамт амьдраагүй, бага насны хүүхэдгүй бол гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн бол гэсэн заалт байна. Энийг чинь юу гэж ойлгох юм бэ гэсэн 1 дүгээр асуулт.

Хоёрдугаарх нь төлбөрийн чадвартай, өндөр цалин, хангамжтай мөртөө шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй, хүүхдийнхээ тэтгэмжийг өгөхгүй ингээд зугтаагаад байдаг энэ хөхөө шувуу шиг хүмүүсийг яах юм бэ гэсэн асуулт байна. Яг иймэрхүү асуултууд. Энэ 2 асуулт бол гишүүний хувьд орон нутгаас ирсэн асуулт.

Түрүүн тэр ДНХ шинжилгээний үнэ дунджаар 700 мянга байх юм гэж хариултад би өглөөнөөс хойш яг ингээд бүгдийг нь сонсоод суугаад л байна л даа. Энэ чинь уг нь бол яг өндөр хөгжилтэй Америк бол 100 орчим доллар л байдаг юм даа. Тэгээд энэ ДНХ шинжилгээ хувийн хэвшил хийх юм уу, төр хийх юм уу. Явж явж Гэр бүлийн хууль баталсан чинь ДНХ шинжилгээний бизнес хийдэг баахан газрууд гараад ирэх юм биш биз дээ. Нөгөө талаасаа манайд ДНХ-ийн нарийвчилсан шинжилгээ хийх боломж бүрдсэн үү. Энэ 120-ийн хажууд Хурдын байран доор ДНХ шинжилгээ хийдэг газар байсан. Би нэг очиж байсан юм. Дээжийг нь аваад гадагшаа явуулдаг

байсан шүү дээ. Тодорхой хугацааны дараа ирдэг гээд иймэрхүү нарийн ширийн заалтууд дээр тодорхой хариултууд өгчихвөл зүгээр байна.

Дээрээс нь ер нь яах вэ саналаа давхар хэлчихье. Энэ хүүхдийн эрхийг хамгаалах, тэр тэтгэмжийн асуудлыг нь шуурхай олгох, дээрээс нь энэ удмын сангийн аюулгүй байдал энэ ургийн овгоо зөв хэрэглэх, дээрээс нь 1990-ээд ургийн овог хэрэглэхээр бүгд Боржигон болчихсон. Зарим нь Боржигон гэж бичээд зарим нь Боржигин гэж бичээд. Тэгээд энэ ургийн овгоо жоохон ухаарсан үед нь зөв солих боломжийг нь нээж өгвөл энэ хуульд бас зүгээр байх шиг байгаа юм.

3-д нь энэ өмчийн маргааныг шийдвэрлэх асуудал байгаа. Үндсэндээ энэ хуулийн гол агуулга бол энэ хүүхдийн эрхийг хамгаалах, тэгээд удмын сангийн аюулгүй байдал өмчийн маргааныг шийдвэрлэх дээр л гол цаашаа анхаарах нь зөв болов уу л гэсэн 3 саналаа бас давхар хэлчихье. Ингээд 3 асуултдаа хариулт аваад тодруулах эсэхээ шийдье.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя. Тодорхой асуултууд асуулаа. Ажлын хэсэг.

Н.Мягмар: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар. Гэр бүл цуцлуулахтай холбоотой асуудал таны хэлж байгаагаар шүүх хуралдаанд биечлэн оролцох гэдэг юм уу, үүнээсээ болоод эсвэл гадаадад байгаагаас болоод гэр бүлээ цуцлуулж чаддаггүй, мөн үүнээсээ болоод дараагийн гэрлэлтээ бүртгүүлэх гэдэг юм уу ийм асуудал, хүндрэл учирч байна гээд асуудлыг та хөндөж байна. Энэ маань бол Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх процессын хууль дээр буюу дараагийн хэлэлцэх эсэхийг нь шийдэх гэж байгаа хуулийн төсөл дээр уг нь байгаа юм. Тухайлбал энэ хуулийн 14.1 дээр зохиогч хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд шүүх хуралдаанд өөрөө оролцох үүргээ цахим хэлбэрээр хэрэгжүүлж болно. Цахим хэлбэрээр хэрэгжүүлж байгаа тохиолдолд зохигч байгаа нутаг дэвсгэрийн харьяаллын шүүхийн байр эсвэл Дипломат төлөөлөгчийн газрын байрнаас гэр бүл цуцлах шүүх хуралдаанд оролцох ийм боломж нь бүрдээд явчих юм. Тэгэхээр саяын хүндрэлтэй ийм асуудлууд шийдэгдэнэ гэж бид бүхэн харж байгаа юм.

ДНХ-ийн тэр шинжилгээтэй холбоотой асуудал дээр бол энэ сайн дураараа хийгдэх юм. Өөрөөр хэлэх юм бол цус ойртолт болон удам зүйн шинжилгээний асуудлыг гэрлэгчдийн хэн нэг нь өөрсдөө хүсэх гэдэг юм уу, эсвэл сонирхогч талын шаардлагаар энийгээ хийгээд төрөл садан юм уу, цус ойртолтоос сэргийлэх үүднээс энийгээ бол хийлгэх боломж бүрдэх юм. Тэгэхээр энэ зохицуулалт маань бол 2028 оны 1 сарын 1-ээс үйлчлэхээр зохицуулж орж ирж байгаа учраас энэ хооронд бэлтгэл ажлаа хангана гэж ингэж тооцож байгаа. Тэр хүрээндээ саяын таны хэлж байгаа 700 хэдэн мянган төгрөгийн өртөг гарах юм байна гэдэг энэ асуудал бол энэ бэлтгэл ажлын хүрээнд тодорхой болно. Яг одоо бас олон улсын энэ чиглэлийн шинжилгээ хийлгэхэд 100 орчим доллар байдаг асуудлууд байгаа юм. Тодорхой хэмжээний кит гээд гараад явуулах шиг юмыг эмийн сангаасаа аваад ч юм уу ингэнгүүтээ шуудангаар хүргүүлээд, лабораторийн шинжилгээний хариу нь гарчихдаг ийм бас олон улсын хямд төсөр аргууд бол байгаа. Тэгэхээр энэ бэлтгэл ажлыг хангах хүрээнд бол энийг бас судалж хангах бололцоо бүрдэнэ гэж. Яг цэвэр лабораторийн тоног төхөөрөмжтэй холбоотой энэ асуудал дээр манай Шүүх шинжилгээний ерөнхий газар бас генетикийн ийм лабораторитой. Энэ лабораториор бол тодорхой төрлийн ДНХ-ийн буюу генетикийн шинжилгээнүүд бол

хийж байгаа. Тэгэхээр бэлтгэл ажлыг хангах хүрээндээ энийг бол хийх бүрэн бололцоотой байж байгаа. Эрүүл мэндийн яамнаас өгч байгаа мэдээллээр бол бас хувийн эмнэлгүүд энэ генетикийн буюу ДНХ-ийн шинжилгээ хийдэг ийм лабораториудтай болсон мэдээллийг өгч байгаа. Тэгэхээр дахин хэлэхэд энэ бол бизнес болох гэхээсээ илүү сайн дураараа хийгдэх ийм шинжилгээ байгаа гэдгийг тодотгож хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Тодруулах уу. Гомбын Ганбаатар гишүүн тодруулна.

Г.Ганбаатар: Мягмар дарга 1 асуултад хариулсангүй. Тэр нөгөө хүүхдийнхээ тэтгэмжийг төлөхгүй, өөрсдөө бас цалин хангамж нь боломжийн байгаа мөртөө шүүхийн шийдвэр биелүүлэхгүй яваад байгаа хүмүүс. Энэ бол ингээд бүсгүйчүүдээс, тойргоос ирж байгаа асуулт байхгүй юу. Тийм юм амьдрал дээр их байна л даа. Тэгээд энийг нь санкцыг нь хэрхэн чангаруулсан юм бэ гэсэн. Яах вэ хуулийн төслийг нь би уншсан л даа. Тэр алданги 0,5-аар тооцно гээд. Тэрнээс өөр ямарваа нэгэн тийм сайжруулсан юм байгаа юу л гэж асуугаад байгаа юм.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг Мягмар дарга.

Н.Мягмар: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ тэтгэлэг төлөхтэй холбоотой энэ асуудал маань шүүхийн шийдвэр гарсны дараа шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн процессын асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр яг Гэр бүлийн энэ хууль дээр энэ маань орж ирээгүй. Түрүүн бас хэлсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн багц хуулийг Засгийн газраас боловсруулаад, Алтангэрэл сайдыг байх үед бол Улсын Их Хуралд өргөн мэдүүлчихсэн байж байгаа. Энэ 3 багц хуулийн төслийн 1 нь болох Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хууль гээд энэ төсөл байж байгаа юм. Тэгээд шүүхийн ялангуяа энэ тэтгэлэг төлөөгүй хүмүүстэй холбоотой, энэ үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд энэ хөшүүргүүдийг нь 34 дүгээр зүйлд нь тусгаад өгчихсөн байгаа юм. Тухайлбал, гадаадад зорчих эрхийг хязгаарлах, нийтийн албанд ажиллах эрхийг хязгаарлах, төрөөс олгох орон сууцын зээл авах эрхийг нь хязгаарлах, гадаад паспорт захиалах эрхийг хязгаарлах, жолооны үнэмлэх захиалах эрхийг хязгаарлах гэх мэт .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Хариулт болчихлоо. Ерөнхийдөө 3 асуулт. Түрүүн өглөөний хурал дээр Сайнзориг гишүүн нэг санал тавиад байх шиг байсан. Тэр удмын сантай холбоотой Чулуун докторын бичсэн 9 боть ном байгаа гээд. Тэр жоохон ташаа мэдээлэл шүү. Бас жоохон юм хум уншиж байгаад, ялангуяа энэ түүх удам зүйн талаар юу яахгүй бол тэрний чинь түүх ийм юм.

1916 онд Олноо өргөгдсөний 6 дугаар онд Оросын тухайн үеийн Орос улсаас өөрсдөө хөрөнгөө гаргаад, Козин гэдэг хүн ахлаад, тэгээд тэр чинь хүн амын тооллого ч биш. Ер нь манай улсын Мал аж ахуйн татвартай холбоотой нэг тийм судалгаа хийгдэж байсан юм билээ. Би энэ талаар их сайн мэдэж, уншсан хүн байхгүй юу. Тэгээд явсан газрууд нь бол зүгээр тухайн таарсан газруудаа ингээд бүртгээд, тэр мал ахуйг нь ингээд юу яагаад явсан болохоос биш энэ манай тооллогын холбоо.../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: 2019 оны асуудал байх наадах чинь. Үг хэллээ. Уучлаарай. 1919 оны Оросоос ирсэн юу байдаг. 1 экипаж ирсэн байдаг. Сайнбуянгийн Амарсайхан гишүүн.

С.Амарсайхан: Хуулийг дэмжиж байгаа. Ер нь бол гэр бүлээ дэмжсэн, үр хүүхэд, хойч үеэ хамгаалсан, үүх түүх, өвөг дээдсээ дээдэлсэн улс үндэстэн уруудаж байсан түүх байдаггүй. Харамсалтай нь манайд энэ бүхэн өнөөдөр сорилт болж байгаа. Энэ Гэр бүлийн хуулийг бид 20 жилийн өмнө баталж байсан бол түүнээс хойш энэ нийгмийн өөрчлөлт, энэ улс оронд гэр бүлийн бүтэц, өрхийн эдийн засаг, хөдөлмөрийн нөхцөл байдал, хүүхдийн эрхийг хамгаалах тогтолцоо, хүчирхийллийн нөхцөл байдал гээд бүх зүйлүүд эрс өөрчлөгдөж байгаа. Тийм учраас энэ хуулийг дэмжиж байгаа.

Гэхдээ бид асуудалд жоохон сууриар нь хандах цаг болчихсон байна. Мэдээж энэ хууль өөрөө гэр бүл, хүүхэд төвтэй эрх зүйн орчныг бүрдүүлэх ёстой. Аливаа халдлага, эрсдэл, хүчирхийллээс шуурхай хамгаалах тогтолцоог бүрдүүлэх ёстой. Цаашлах юм бол тэтгэлэг, тэгээд тэр нийгмийн хамгааллын асуудлуудыг нь цогцоор нь шийдвэрлэсэн хариуцлагын шинэ стандартыг бий болгох ёстой. Энийг нь татвар хураамж, нийгмийн тогтолцоотой нь бүгдийг нь уяж өгч, цахимжуулах ёстой. Энэ гэр бүлийн асуудал гэдэг бол зөвхөн 2 хүний хоорондын асуудал биш. Түүнээс үүдсэн хөрөнгө мөнгө, өмчийн маргааны асуудал ч биш. Энэ бол улс орон, үндэстэн оршин тогтнох, бат бэх байх, цаашлах юм бол өв уламжлал, үнэт зүйл, тэгээд тэр бүхнийг агуулсан улс орны тусгаар тогтнолын үнэт зүйлтэй холбоотой. Тэгэхээр хувь хүний төлөвшил ямар байх юм, тэр нь сургууль цэцэрлэгээсээ яаж эхлэх юм, хөдөлмөр эрхлэх шатдаа яаж явах юм, насанд хүрсэн үедээ залуучууд нь гэр бүлээ яаж төлөвлөх юм. Тэр дээр нь төрөөс, нийгмээс ямар дэмжлэг туслалцааг бага ангиас нь эхэлж сургах ёстой юм. Цогцоор нь мэдлэгийг нь олох ёстой юм. Яаж эцэг эхийн чадавхыг нэмэгдүүлэх ёстой юм. Яаж өрхийн соёлыг нийгмийн соёл болгож давллагаалуулах ёстой юм. Энэ бүхнийг уялдуулсан цогц шийдвэр нь байж байж бид үр дүн гарна гэдгээ олж харахгүйгээр мэдээж энэ зохицуулалтыг бол хийх ёстой. Эрх зүйн зохицуулалтыг нь. Гэхдээ үүнийг дагасан үндэсний ямар хөтөлбөрүүдийг төлөвлөж байгаа юм бэ. Ямар шинэчлэлүүдийг хийх гэж байгаа юм бэ. Тэр нь өнөөдөр төрж байгаа, маргааш 18 насанд хүрч нөгөөдөр гэрлэх гэж байгаа, гэр бүл зохиож эцэг эх болох гэж байгаа хүмүүсийг яаж төлөвшүүлэх гэж байгаа юм бэ гэдэг энэ нийгмийн хөтөлбөрүүд яагаад байхгүй болчхов.

Хүүхэд хамгааллын төв гээд байна. Боломжоороо, чадлаараа ажиллаж байх шиг байна. Гэхдээ энэ дээр нэгдсэн бөгөөд төрийн цогц бодлого байхгүй байна. Нэгдсэн хуралдаанд .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Нэгдсэн хуралдаанд асуулт асууж, хариулт авах хугацааг зөвлөлөөс тогтоосон байдаг. Энэ хугацаа дууссан тул асуулт асууж, хариулт авах хугацааг 1 цагаар сунгалаа. Амарсайхан гишүүн тодруулъя.

С.Амарсайхан: Тэгэхээр ийм ямар бодлогууд явж байна вэ. Одоо бол зүгээр Хүүхэд хөгжлийн төв, Хүүхэд хамгааллын төв, Гэр бүл хүчирхийллийн төв гэдэг бол зөвхөн байлгахын тулд байлгаж байгаа юм шиг л ийм хандлагатай байгаа шүү дээ. Салбар бүрээс нь авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байгаа ч гэсэн төсөв хөрөнгийг нь тавьдаггүй. Хүний нөөцийг нь хөгжүүлдэггүй, сэтгэл зүйч, багш, сурган хүмүүжүүлэгчид цаашлах юм бол тэр эвлэрүүлэн зуучлагчид энд тэндээс ирж

зөвлөдөг мэргэжлийн хүмүүсийн оролцоо гээд асар хангалтгүй байгаа. Энэ дээр ямар бодлого хэрэгжүүлэх гэж байна.

Энэ хуулийн зорилго бол түрүүн хэлсэн. Гэр бүл, хүүхэд төвтэй эрх зүйн систем байх ёстой. Хүчирхийллийг бууруулах, хамгаалалтын шуурхай тогтолцоог бүрдүүлэх ёстой. Тэгээд олон улсын гэр бүлийн эрх зүйн орчин дээр бас мөрдөгдөж байгаа авах, авахгүй, нутагшуулах ямар асуудлууд байгаа юм. Тэр маргаанаас үүдсэн тэтгэлэг, өмчийн маргааны асуудлуудыг шийдвэрлэх ямар шинэ стандарт зохицуулалт бий болгох ёстой юм гээд энэ бүхнийг бид нар яаж зохицуулах гэж байгаа юм. Энийг хэлж өгөөч. .../минут дуусав/

Ж.Бат-Эрдэнэ: Амарсайхан гишүүний асуултад хариулъя. Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Амарсайхан гишүүн бас маш чухал асуудал хөндөж байна. Яг таны ярьж байгаа энэ нийгэмд тулгамдаад байгаа энэ асуудлуудыг шийдэх гэж үндсэндээ бол нэлээд хамгийн их хэл ам таталсан, нийгмийн анхаарал татсан, иргэдийг бухимдуулдаг, тэгсэн мөртөө шийдэл хүлээсэн эрх зүйн зохицуулалт байхгүй асуудал болчхоод байгаа. Ингээд гэр бүл салалт жилээс жилд нэмэгдэж байгаа. Энд ингээд харахад 2022 онд 4500 гэр бүл салж байсан, 2023 онд 4800, 2024 онд 4449 гээд хувиар аваад үзэх юм бол нийт гэрлэсэн тохиолдлуудаас 2022 онд 25 хувь нь, 2023 онд 27 хувь нь, 2024 онд 31 хувь нь салж байгаа. Ингээд гэрлэлт салах, гэр бүл салахтай холбоотойгоор хэн хохирч байна вэ гэдэг дээр ихэнх нь л эмэгтэйчүүд хохирдог. Тийм болохоор үүнийг шийдэх шаардлагатай байна.

Мөн бас гэр бүл салалтаас болж хамгийн их хохирдог хүмүүс бол хүүхдүүд байгаа юм. Энэ шүүхээс гэрлэлт цуцлах шийдвэр гаргахдаа тухайн гэрлэгчид хүүхэдтэй бол нэхэмжлэлийн шаардлагаас үл хамаараад хүүхдийн тэтгэлэг тогтоох ёстой. 2017 оны тохиолдол дээр 50 шүүхийн шийдвэрийг түүвэрлэн судалж үзэхэд 40 шүүхийн шийдвэр буюу 80 хувь дээр нь хүүхдийн тэтгэлэг шийдэлгүй, шүүх шийдвэр гаргасан байгаа. 2022 онд бас яг 50 тохиолдлыг аваад үзэхэд 45 буюу 90 хувь нь хүүхдийн тэтгэлэг олгоогүй орхигдуулсан ийм шийдвэр гарч байсан. Цаашлаад ингээд хүүхдүүдийн асуудал дээр гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг эхээс 100 орчим мянган хүүхэд төрсөн байгаа юм. Сүүлийн 4 жилийн хугацаанд. Мөн энэ харилцаа бас эрсдэлтэй, тодорхойгүй. Нөгөө гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг эхээс төрсөн. Тэгээд иймэрхүү асуудлуудаас болж л үндсэндээ таны ярьж байгаа хараа хяналтгүй, дээрээс нь эцэг эх, асран хамгаалалт нь бас асуудалтай, тэтгэмж байхгүй гээд хүүхдүүд их хохирч байгаа. Эмэгтэйчүүд их хохирч байгаа учраас л энийг зохицуулсан зохицуулалт байхгүй болохоор энэ хуулийн шинэчилсэн найруулгыг Засгийн газраас Их Хуралд өргөн барьж, хэлэлцүүлж байгаа. Энэ хууль батлагдах юм бол таны ярьж байгаа энэ асуудлууд ер нь бас нэлээн хэмжээнд шийдэгдэх, яг үүнтэй холбоотой бас гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн бас эхнэр, нөхөр болж байгаа хүмүүсийн эцэг эх байх үүрэг, эрх, хариуцлага энэ бүх юм бас энэ хуулиудаар нэлээн тодорхой болно. Ялангуяа хүүхдийн эрх ашиг илүү бас хамгаалагдах, хангагдах ийм бололцоо боломж бүрдэнэ гэж бас үзэж оруулж ирсэн.

Энэ дээр манай ажлын хэсэг бас нэмээд хариулчихъя.

Н.Учрал: Ажлын хэсгээс нэмж хариулна. 4 дүгээр микрофон.

М.Цогтбаатар: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Цогтбаатар ахлах шинжээч. Төрөөс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүн амын өсөлтийн

хөгжлийг дэмжих бодлогыг бол Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар, бусад салбаруудтай хамтран хэрэгжүүлж байна. Бусад тухайлсан хуулиуд, салбарын хуулиуд бол хэрэгжиж байгаа. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль байна. Хүүхдийн эрх, Хүүхэд хамгааллын тухай хуулиуд бол 2 жилийн өмнө батлагдсан. Эдгээр хуулиудаар Монгол Улс бол хүүхэд хамгааллын гэр бүлийн хамгааллын тогтолцоотой орон гэж явдаг. Тэгээд энэ хууль дээр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, энийг хамтарсан багаар шийдвэрлэх гэх мэт хүүхдийн тусламжийн утас, тэнд үйлчилгээ үзүүлэх боловсон хүчин, санхүүжилт гээд бүх тогтолцоогоор шийдсэн. Энэ одоо хэрэгжиж явж байгаа. Улсын хэмжээнд гэр бүлд үйлчилгээ үзүүлэх төвүүд ажиллаж байна. Гэр бүлийн .../минут дуусав/

Н.Учрал: Амарсайхан гишүүн тодруулна.

С.Амарсайхан: Би 3 зүйл дээр маш тодорхой сайн анхаарч ажиллаарай гэж хүсье.

1 дүгээрт нь энэ хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах зүйл заалт бүлгийг маш боловсронгуй тодорхой болгох хэрэгтэй шүү гэдгийг.

2 дугаарт хүүхэд хамгааллын олон улсын энэ конвенцууд, цаашлах юм бол Монгол Улсын бараг 300 мянга гаруй иргэн гадаад улс оронд ажиллаж амьдарч байгаа. Гадаадад байгаа энэ Монгол өрхийн аюулгүй байдал, хүүхдийн ирээдүй, хамгааллын асуудал дээр бас энэ хууль дээр тусгах ёстой шүү.

3 дугаарт нь энэ сэтгэл зүйн аливаа орчин, тэр эцэг эх нь байна уу, хүүхэд нь байна уу, гэр бүл нь байна уу сэтгэл зүйн аюулгүй орчинд ажиллаж амьдрах, түүнийг хамгаалах, цаашлах юм бол эцэг эхийн хариуцлагыг нэмэгдүүлэх гэхээсээ илүүтэй эцэг эхийн нийгмийн оролцоо, идэвх санаачилга, гэр бүлийн дотоод уур амьсгал, соёлыг дэмжих энэ агуулга дээр та бүхэн анхаарч ажиллаарай. Монгол өрх, залуу гэр бүл өнөөдөр асар өөр орчинд амьдарч байгаа шүү. Дарамт шахалттай, эдийн засгийн хүндрэлтэй, архидалт, донтолттой, цалинтай, цалингүй .../минут дуусав/

Н.Учрал: 1 минут нэмж өгье. Амарсайхан гишүүн.

С.Амарсайхан: Өнөөдөр Монгол гэр бол их амаргүй нөхцөлд ажиллаж амьдарч байгаа. Монголын залуучуудын ирээдүй асар хүнд сорилтын өмнө байгаа шүү. Ялангуяа залуу гэр бүл ипотекийн зээл, айлын карма өрөө, хашаанд гэр түрээсэлнэ. Энэ их салалт, энэ их үл ойлголцол бол өнөөдөр орлогогүй байгаа, ажилгүй байгаа, орон сууцгүй байгаа, түүнээс үүдсэн амьдралдаа итгэх итгэлгүй байгаагаас болж байгаа ийм асуудал. Нөгөө талаараа бол эдийн засгийн болон нийгмийн асар их хууль, дүрэм журмын дарамт шахалт, эдийн засгийн дарамт, тэр донтолт, архидалт, цаашлах юм бол ажилгүйдэл, цалингүйдэл, ядуурал гэсэн маш олон үндэс суурь байгаа учраас 1 дүгээрт эрх зүйн талаас нь, 2 дугаарт нь нийгмийн олон төрлийн хөтөлбөр, соён гэгээрүүлэх ажил, 3 дугаарт нь эдийн засгийн төрийн бодлого өрхийн орлого руу чиглэсэн хүний хөгжил, нийгмийн асуудал, цалин тэтгэмж, тэр нь шударга хөдөлмөр дээр тогтсон эдийн засгийн зах зээлжсэн тогтолцоо руу шилжих. .../минут дуусав/

Н.Учрал: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс

урьдчилж ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Бямбацогт дарга дахин үг хэлэх юм уу. Саранчулуун гишүүн. Индрээс үг хэлнэ. Санал хураалт уг нь болмоор л байна. Гэр бүлийн тухай хууль хэлэлцэж байхад хариуцлагагүй хандаж байна шүү дээ. Ийм хариуцлагагүй хүмүүс гэр бүлдээ ч гэсэн адилхан л хариуцлагагүй байгаа шүү дээ. Хуралдаа ингэж хандаж байгаа хариуцлагагүй хүмүүс бол гэр бүлдээ бас хариуцлагагүй хүмүүс. Энд байгаа хүмүүсийг харуулмаар байна. Энд байгаа хүмүүсийн зургийг нь Бямбацогт дарга аваадхаач. 1 дүгээр микрофон Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Юуны өмнө Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн өдрийг өчигдөр бид нар бүх нийтээрээ бас тэмдэглэж өнгөрүүлсэн. Энэ өдөр Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар ямар ахиц гаргасан бэ гэдгээ бас дүгнэж, тал талдаа ярилцлаа. Яг одоо надад үг хэлэх боломж гарсан дээр. Би яг хэлэлцэгдэж байгаа энэ хуультай холбоотой хэдэн зүйлийг хэлье. Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлийн дэмжлэг сул байна. Асран хамгаалалт голдуу ээжийн тал дээр төвлөрдөг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ээжүүдийн ажил эрхлэлт 2 дахин буурдаг. Гэр бүлийн орлого тэр айлд 30-40 хувь багасдаг. Эцэг эхийн салалт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхөд илүү өндөр байдаг. Ийм учраас түрүүний миний хэлээд байсан асаргааны асуудал, асрахуй эдийн засаг гэдэг бол асарч байгаа хүний хөдөлмөрийн тухай ойлголт байгаа. Хөдөлмөрийг үнэлэх тухай би яриад байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар анхаарах хэрэгтэй байгаа. Олон улсын жишээг аваад үзэхээр Япон, Солонгос, зарим орнуудад тусгай асаргаа дээр зохицуулалт байдаг. Монгол Улсад өнөөдөр асаргааны мөнгө хүрэхгүй байгаа гэдгийг бид нар өнгөрсөн саржингаа ярьсан. Тэр асарч байгаа хүмүүс яагаад мөнгө нь хүрэхгүй байгаа вэ гэхээр ээжүүд өөрсдөө ажил хийх боломжгүй, хүүхдээ асарч байдаг. Хүүхдийг нь сургууль авахгүй. Энэ нөхцөл байдалд байгаа. Тэгэхээр яг энэ хуультай холбоотой энэ хууль боловсруулж байгаа хүмүүс дээр энэ асуудлыг онцгойлон оруулж өгөөч гэж бас хэлмээр байгаа юм.

Дараагийнх дээр нь гэр бүл салсны дараа гэр бүл салалт, хүчирхийлэл 2 бол бие биетэйгээ холбоотой. Тэгэхээр гэр бүлийн салалтын үеэр хүчирхийлэл бүр их гардаг. Монгол Улсад салалтын дараа хүүхдэд чиглэсэн интервенц хангалтгүй байгаа. Салалтын дараа шууд хэзээ уулзах гэдгийг цагийг тохирохоос гадна салалтын дараа хүүхэдтэй уулзалт дахиж сэтгэл зүйн гэмтлийг нь даамжруулахгүй байх, хүүхэд гэр бүлийн нөгөө харилцагчийг хохироохгүй байх тал дээр нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн оролцоог илүү тодотгож өгөх хэрэгтэй байна энэ хууль дээр. Тэгэхгүй бол салсны дараах хүчирхийлэл байсаар л байгаа. Бид нар зүгээр л хэмждэггүй болохоос биш.

Ер нь бол Монголд хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг бид нар ярихгүй өнцөг булан гэж алга. Хаана хүн амьдарч байна. Тэнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байгаа учраас энэ хууль санаачлагч нар хуулийн төсөл дээр ажиллаж байгаа хүмүүс энэ дээр анхаарна уу гэдгийг хэлье. Тэгээд баярлалаа.

Н.Учрал: Сархадын Зулпхар гишүүн. Энэ хуультай холбогдуулаад, үзэл баримтлалтай холбогдуулаад дэмжсэн, дэмжээгүй байр сууриа гишүүд илэрхийлнэ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн. 1 дүгээр индрээс үг хэлнэ. Таны нэр байсан уу. Хааччихав харин. Индэрт бэлэн байгаарай. 1 дүгээр микрофон.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг бол хэлэлцэхийг зарчмын хувьд дэмжиж байгаа. 1999 онд батлагдсан энэ хууль бас гарцаагүй өөрчлөгдөх хэд хэдэн нөхцөл байдлууд байгаа. Энэ анагаахын шинжлэх ухаанд ч гэсэн маш олон тийм шинэлэг ойлголт, шинэлэг зүйлүүд бас нэвтэрсэн. Жишээ нь, хүйс солих, магадгүй юу гэдэг юм үр хүүхэдтэй болж чадахгүй байгаа хүмүүс бас тодорхой түвшинд тээгч эхийг ашиглаад бас үр хүүхэдтэй болох ч гэдэг юм уу. Үүнээс үүсээд энэ хувийн эрх зүйн суурь болсон гэр бүлийн харилцаа дахь эд хөрөнгийн болоод эдийн бус бололцоо болох овог нэр авахаас эхлээд маш олон зүйлүүд дээр өөрчлөгдөх зайлшгүй шаардлагууд бол гарч байгаа гэдэг зүйлийг бас хэлмээр байна. Энэ агуулгыг багтааж орж ирсэн учраас энэ хуулийг бол зайлшгүй хэлэлцээд явах ёстой гэж үзэж байгаа.

2 дугаарт энэ Гэр бүлийн хууль гэдэг бол нийгэм дэх тэр ёс суртахуун болоод хувь хүний хариуцлагын асуудлуудыг илүү их өндөржүүлж өгдөг хууль байдаг. Ойлгуулж өгдөг хууль байдаг. Тэгэхээр эндээс үүсэж байгаа үр дагаврууд бас зарим талаараа хохирч байгаа гол иргэд нь бол магадгүй ээжүүд, хүүхдүүд байдаг. Тэгэхээр энэ нөхцөл байдлууд дээр бас нэлээн шинэлэг зохицуулалтууд орж ирж байгаа. Ялангуяа гэр бүлийн дундын өмч, эргээд эд хөрөнгийн эрхтэй холбоотой олон өөрчлөлтүүд дээр бас ахиц дэвшил авчрах ийм зохицуулалтууд орж байгаа учраас зайлшгүй энэ өөрчлөлтүүдийг нь баталгаажуулаад явах ёстой гэж зүйлийг бас энэ дашрамд хэлмээр байгаа юм.

Дээрээс нь энэ үр хүүхдүүдийг магадгүй ээж аав нь зуурдаар ч байдаг юм уу эсвэл ээж аав нь эцэг эх байх эрхээ хасуулдаг ч юм уу энэ тохиолдолд аль болохоор юу гэдэг юм хамаатан саданд нь үрчлүүлэх, дараагийн асуудал нь бол асралт гэр бүлд бас байлгаж хүмүүжүүлэх, өсгөх, хөгжүүлэх, бүр боломжгүй бол асрамжийн газар байрлуулах ийм дэс дараатайгаар орж ирж байгаа юм. Тэгэхээр энэ үйл ажиллагааны цаана төрийн бас үүргүүд байгаа гэдэг зүйлийг бид бас ойлгох ёстой. Өөрөөр хэлэх юм бол үүний зохион байгуулалт, бүтэц, менежментийг хэрхэн авч явах вэ гэдэг зүйлийг бас анхаарах зайлшгүй шаардлага байгаа. Гэр бүлийн хууль бол мэдээж хувийн эрх зүйн хууль учраас энэ асуудлыг зохицуулахгүй. Яг төр талын үүнтэй холбоотой хуулийн зохицуулалт бол Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль дээр орж ирэх ёстой. Тийм учраас яг энэ Гэр бүлийн хуулийг хэлэлцээд явж байх хугацаанд Аубакир сайд бас цаг алдалгүй Засгийн газраас дээрх энэ хуулиудын асуудлыг зайлшгүй оруулж ирж, хамтаар нь цогц байдлаар шийдэхгүй бол энэ хууль хэрэгжинэ, шүүхийн шийдвэр гарна, хэрэгжих боломжгүй болно л гэсэн үг. Тэгэхээр ийм зүйлүүд бол байгаа. Тэгэхээр энийг бол зайлшгүй анхааръя гэдэг зүйл байгаа.

Тэгээд ер нь сошиалаар гэр бүлийн асуудлаа шүүлгэдэг моод манайд гарч эхэлж байна. Тийм учраас амьдрал баян гэдэг шиг хэдийгээр хайр сэтгэлээр гэрлэж байгаа боловч гэр бүл цуцалсан тохиолдолд, салсан тохиолдолд эд хөрөнгийн асуудлаа хэрхэн яаж шийдэх вэ гэдэг зүйлээ бол ер нь гэрээгээр баталгаажуулж суралцах, ойлголцох хэрэгтэй. Энэ гэрээ байгуулаад ирэхээр яг ази хүний гэдэг юм уу, ялангуяа Монгол хүний mentality талдаа жоохон зохимжгүй байдаг боловч өнөөдрийн энэ харилцаан дээр бол ийм зүйлүүдийг зайлшгүй хийгээд явах шаардлагатай юм байна гэж бас харагдаж байгаа. Тэгэхээр энэ дээрээ анхааръя гэж бодож байгаа.

Тэгээд энэ Гэр бүлийн хууль бас орж ирж байгаатай холбогдуулаад энэ цус ойртолт гэдэг зүйлээс урьдчилан сэргийлэх, ургийн овгийн асуудлыг бас төрд байгаа мэдээллүүдийг иргэддээ ашиглах боломжийг нь зохион байгуулалт, менежмент, дэд бүтцийн хувьд бий болгоё. Тэгээд 1915 онд анхны хүн амын тооллогыг явуулсны тэр материал сая Польш улсаас тодорхой эрдэмтэд авчраад ингээд хэвлэсэн байна. Үүнийг ашиглаж жинхэнэ ургийн овгоо тогтоолгох энэ бололцоог бүрдүүлье. Тэгээд сумууд дахь хүн ам бол 3 дахь, 4 дэх үе дээрээ гэр бүл болж байгаа тохиолдол 85 хувьтай .../минут дуусав/

Н.Учрал: Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай болон бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлж дууслаа.

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу тус асуудлаар хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Санал хураалтыг нэгтгэж хийе. Гэр бүлийн энэ хууль чинь дагасан бараг 10, 11 хууль байгаа юм байна шүү. Тэгэхээр санал хураалтад гишүүд ирц өндөр оролцох ёстой. Тэгэхээр санал хураалтыг эхний асуудалтай нэгтгэж явуулна.

16.11 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Сандагийн Бямбацогт танилцуулна. Индэрт урьж байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалтад Гэр бүл, хүүхдийн хэргийн Давж заалдах шатын шүүх, 2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 1 дэх заалтад Нийслэл дэх Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатын тойргийн шүүхийг тус тус байгуулахаар заасан.

Шүүх байгуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд тус зохицуулалтыг 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан.

Түүнчлэн, “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 68 дугаар тогтоолын 4-д Нийслэлд Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатын тойргийн болон давж заалдах шатын шүүх байгуулсантай холбогдуулан эрүү, иргэний хэргийг хянан шийдвэрлэх хууль тогтоомжид холбогдох зохицуулалтыг тусган Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэхийг тус тус даалгасан болно.

Үүний дагуу Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн. Олон улсын туршлагаас үзвэл 1949 онд Япон улсад байгуулагдсан Гэр бүлийн хэргийн дагнасан шүүх нь Азийн хамгийн анхны гэр бүлийн хэргийн дагнасан шүүх болж байгуулагдаж байсан бөгөөд Гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх хуулиар гэр бүлийн хэрэгт тохирсон онцлог процесс ажиллагааг нь зохицуулдаг байна. Түүнчлэн БНСУ 1963 онд Сөүл хотын Гэр бүлийн хэргийн дагнасан шүүх байгуулагдсан нь Япон улсын дараа орох анхны гэр бүлийн дагнасан шүүх болно. Тус шүүх нь гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх бие даасан хуулиар гэр бүлийн хэргийг хянан шийдвэрлэх онцлог зохицуулалтыг бий болгосон байдаг.

Иймд, Монгол Улс анх удаа Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүхтэй болж байгаа тул олон улсад нэгэнт тогтсон гэр бүл, хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэдэг сайн туршлагыг судлан хүүхдийн тэргүүн дээд эрх, ашиг сонирхлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хамгаалах зорилгоор олон улсын жишигт нийцүүлэн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг 5 бүлэг 40 зүйлтэйгээр боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх нь хэргийг шийдвэрлэхдээ тухайн гэр бүлийн нөхцөл байдлыг бүрэн тал бүрээс нь шинжлэн судлах, нэг шүүхэд гэр бүлийн холбогдолтой тухайлбал гэрлэлт цуцлалт, гэр бүлийн хүчирхийллийн хэргийг хамтад нь шийдвэрлэх, хүүхдийн эрхийг хамгаалахыг зорилго болгон ажиллах болно.

Хуулийн төслийг дагалдуулан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай зэрэг 12 хууль тогтоомжийн төсөл боловсрууллаа.

Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Бямбацогт даргад баярлалаа. Төслүүдийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэл танилцуулна. Индэрт урья.

О.Алтангэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Хууль зүйн байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хууль санаачлагч гэрлэлт цуцлах, эцэг эх байх эрхийг хасах, хязгаарлахад хүүхдийн эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах, хохироохгүй байх, гэрлэлт цуцлалт болон холбогдох бусад гэр бүлийн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэхэд хүүхэдтэй холбогдолтой асуудлыг нэхэмжлэх гаргасан эсэхээс үл

хамаарч заавал шинжлэн судалж шийддэг бай байх, шүүгч эвлэрүүлэн зуучлагч нар гэр бүлийн эрх зүйгээр мэргэших, гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн систем шүүхэд бий болох, цаашлаад эцэг, эх хүүхдийн өмнө хүлээх гэр бүлийн хариуцлага дээшлэх, шүүхийн өөрийн санаачилгаар нөхцөл байдлыг тал бүрээс нь шинжлэн судлах үүрэг оролцоог нэмэгдүүлж хүүхдийн эрх, ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хангуулах зэрэг асуудлыг зохицуулахаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төслийг иргэдийн оролцоог хангах санал авах зорилгоор Улсын Их Хурлын D-Parliament цахим сайдад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Гэр бүл, хүүхдийн шүүхээс гарсан шийдвэрийн биелэлтийг хангах буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой зохицуулалтын талаар, тус шүүхийн шүүгчид тавигдах тухайлсан шаардлага хуулийн төсөлд туссан эсэх, Прокурорын байгууллага гэр бүлийн хэрэг маргааныг шийдвэрлэх тусгай нэгж байгуулах эсэх, Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал Гэр бүл, хүүхдийн шүүхийн төсвийн талаар, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуультай хэрхэн уялдах талаар, Улсын дээд шүүх процессын шинжтэй хэм хэмжээг тогтоох журам батлах нь тохиромжтой эсэх, шүүгчийн захирамж болон шинжээчийн гаргасан дүгнэлтэд гомдол гаргах эрхийг хязгаарласан зохицуулалт нь оновчтой эсэх, насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж хорих ял оногдуулж байгаа гэмт хэргийн төрлийг бууруулахад баримтлах бодлогын талаар асуулт асууж, хариулт авлаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг Гэр бүлийн хөгжлийг дэмжих болон хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, эрх зүйн ач холбогдолтой үйл явдалд овог нэр тогтоолгох асуудлыг оруулах, онцлогтой хэрэг маргааныг шийдвэрлэхэд Гэр бүл, хүүхдийн шүүхийн шүүгчийг туслахаар мэргэжлийн ур чадвартай, гэр бүлийн сэтгэл зүйч, нийгэм, социологийн чиглэлийн мэргэжилтэй хүмүүсийг ажиллуулахад анхаарах эрх зүйн чадамжгүйд тооцох асуудлыг процессжуулах, Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал шүүхийн үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангах хүрээнд хангах хүрээнд Хууль зүйн байнгын хорооноос хянасан төсвийг бууруулахгүйгээр улсын төсөвт тусгах нь зүйтэй зэрэг саналыг хэлсэн болно.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 53,3 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүх байгуулах тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүд болон “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Учрал: Алтангэрэл гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Бямбацогт, Батаагийн Батцэрэн Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч, Пунцагийн Золзаяа Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Отгонбаярын Мөнхбаатар Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, Нэргүй Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ядамдоржийн Жавхлан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Доржсүрэнгийн Мөнгөнтуул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Оюунбаатарын Оюунзул Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Баатарсүрэнгийн Батзориг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, Колягийн Нямдаваа Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Занахүүгийн Сансарзолбоо Улсын ерөнхий прокурорын газрын Бодлого, төлөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах прокурор, Очирбатын Амарсанаа Олон улсын Улаанбаатар их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор.

Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцууллаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэл, хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Бямбацогт сайд шаардлагагүй байх. Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн байхгүй байна. Мэндбаярын Мандхай байхгүй байна. Пүрэвжавын Сайнзориг байхгүй байна. Тэгээд яаж хүлээх юм бэ энэ чинь. Пүрэвжавын Сайнзориг асуулт асууна.

П.Сайнзориг: Ингээд бас яах вэ, зүгээр шүүхийг төрөлжүүлж байгуулах асуудал бас энэ хүрээнд яригдаж байгаа. Тэгээд би яах вэ, зүгээр энэ асуудлыг бол зарчмын хувьд дэмжиж байгаа.

Хууль зүйн байнгын хороо дээр бас хэлсэн нэг зүйл уг нь яах вэ, шүүхийн төрөлжилт дээр уг нь бас энэ арилжааны шүүхийг байгуулах асуудал бас их чухал байгаа. Тэгээд яах вэ, Гэр бүлийн шүүхээс эхэлж байна. Үүнийг бас дагалдуулаад цааш цаашдаа энэ шүүхийг төрөлжүүлэхэд бол бас Засгийн газар шүүх эрх мэдлийн байгууллагатай харилцан ажлын уялдаагаа хангаж бас яваасай гэж 1 дүгээрт зарчмыг хэлж байгаа юм.

2 дугаарт яах вэ, энэ Гэр бүл, хүүхдийн шүүхэд ажиллах шүүгч нарт бас ердийн буюу бусад шүүхүүдэд ажиллаж байгаа шүүгчдээс тавигдах шаардлагуудыг бусад оронд бол нэмж тавьж өгдөг юм. Тухайлбал өөрөө гэр бүл зохиосон байх, дээрээс нь шүүгчээр ажиллах гэж байгаа хүн бүр үр хүүхэдтэй байх буюу энэ гэр бүлийн харилцаанд болдог энэ процесс гэдэг юм уу, энэ мэдрэмжийг өөрөө мэдэрсэн яг аав хүн, ээж хүн байхыг зайлшгүй шаарддаг. Тэгэхээр энэ зүйлүүдийг уг нь энэ процессын хууль дээрээс бас тодруулж өгвөл их зөв байсан.

Түүнээс биш гэр бүл зохиогоогүй ийм хүмүүс өнөөдөр шүүхийн сонгон шалгаруулалт орчихсон явж байгаа байхгүй юу. Туслахууд байсан энэ тэр гээд. Тэгэхээр эд нар бол гэр бүлийн хэргийг шийдэж чадахгүй ээ. Тийм учраас энэ дээрээс бас анхаарах ёстой. Цаашдаа энэ процессын хууль нь батлагдаагүй байж байхад Гэр бүл, хүүхдийн шүүхэд ажиллах хүмүүсийн сонгон шалгаруулалтыг хийгээд байгааг би бас ойлгохгүй байгаа. Тэгэхээр энийг бас анхаараач ээ гэж байгаа юм.

Дээрээс нь яах вэ, энэ санал, дүгнэлтэд бас ороод байгаа нарийн мэргэжлийн том мэдрэмж шаардсан энэ ажил дээр заавал шүүгчийн туслахаар эрх зүйч хүн байх тухай биш, хуульч хүн нь байх тухай биш, илүү их нийгмийн ажилтан, социологич мэргэжлийг магадгүй эрх зүйчтэй хавсарсан ер нь социологич, нийгмийн ажилтнууд шүүгч дундын туслах хийх ёстой. Хүүхэдтэй яаж харьцахаас эхлээд, асуулгад шүүгчээс тавих асуулт энэ тэр дээр их нарийн мэдрэмжтэй асуухгүй бол эргээд хүүхдүүд бас хувь заяагаа шийдэх энэ асуудал дээр яг тэр хуулийн шүүхийн хүрээ дотор ороод бас айж балмагдах ч байдаг юм уу ийм юмнаас болоод бас сэтгэл зүйн юманд ордог. Тэгэхээр энэ чиглэлдээ бид нар бас хандлагаа өөрчлөөд, энэ шүүх эрх мэдлийн байгууллагад заавал эрх зүйч юм уу, хуульч хүмүүс ажиллах тухай биш, яг нарийн мэргэшсэн энэ социологичдыг, сэтгэл зүйчдийг, нийгмийн ажилтныг ажиллуулах асуудал дээр бас энэ хуулиуд дээрээс бас нээж өгөх ёстой юм. Ингэж байж бид нар энэ нарийн мэдрэмжтэй энэ шүүхийг бас ажиллуулахад бас хийж чадна гэж үз үзэж байгаа.

Тэгээд бас олон гишүүд маань асуугаад байсан. Ялангуяа гэр бүл, хүүхэдтэй холбоотой шүүхийн шийдвэр, тэр дундаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах энэ хангалтгүй байгаа гээд байгаа. Тэгэхээр энэ хууль дээр бас энэ тогтолцооны хувьд ер нь ямар өөрчлөлтүүдийг Гэр бүл, хүүхдийн шүүхээс гарч байгаа шийдвэрийг биелүүлэхэд бас анхаарахаар байж байгаа вэ. Шийдвэр гүйцэтгэгч маань тогтолцооны хувьд энийг дагаад өөрчлөлт орох уу. Эсвэл Засгийн газрынхаа дэргэд л Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дэргэд ажиллаад байх юм уу. Эсвэл энэ шүүхийг дагасан шийдвэр гүйцэтгэлийн асуудлыг бүр салгаад ер нь шүүх эрх мэдлийн байгууллагад нь өгвөл яадаг юм бэ. Ийм концепц энэ тэрийг судалсан зүйл байна уу. Өөрөөр хэлэх юм бол хэрэг маргааныг үүсгэснээсээ эхлээд гарсан шийдвэрийг биелүүлэх хүртэл хугацаанд яг энэ шүүхэд нь бас энэ асуудал, боломжийг нь олговол яасан юм бэ гэдэг зүйлийг бас миний хувьд тавиад байгаа юм. Тэгээд энэ шүүхийн төрөлжүүлэлтийн асуудал дээр цаашдаа бас анхааръя. Хандлагаа өөрчилъе л гэж байгаа. Заавал шүүгчийн туслахаар хуульч, эрх зүйч биш, бусад салбар мэргэжлийн, нарийн мэргэжлийн хүмүүсийг ажиллуулъя гэж байгаа. Тэгэхээр энэ зүйлүүд дээр бас ажлын хэсгээс буюу энэ Засгийн газар өргөн барьсан талаас ямар байр суурьтай байгаа вэ. Бас тодруулж хэлж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм.

Н.Учрал: Бямбацогт сайд хариулна.

С.Бямбацогт: Тэгэхээр бид нар 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн бас нэг гол заалт бол шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус ажиллах нөхцөлийг бас хуулиар бүрдүүлнэ гэж Үндсэн хуульд оруулсан. Энэ хүрээндээ бид нар бас 2021 онд Шүүхийн багц хуулийг баталж, шүүхийн багц хуультай холбоотойгоор хуульд бас тодорхой дагнасан шүүх байгуулж болохоор заасан байгаа. Энэ дагнасан шүүх байгуулж болохоор заасан энэ заалтын хүрээнд гэр бүлийн шүүхийн асуудлыг оруулж ирж байгаа юм. Гэр бүлийн хэргийн маргаан шийдвэрлэх. Яагаад энэ шүүх бас орж ирж байгаа юм бэ гэхээр шүүх дээр иргэний хэргийн шугамаар шийдэгдэж байгаа хэргүүд дээр бас дийлэнх хувийг нь гэр бүлийн маргаантай, гэр бүл салалтай, үр хүүхдээ бас асран хамгаалах, тэтгэмж олгох гээд иймэрхүү асуудалтай холбоотой хэргүүд шийдэгддэг юм байна лээ. Тийм болохоор бас Монгол Улсын Үндсэн хуульд заасан гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална гэж Үндсэн хуулийн заалт байгаа. Энэ Үндсэн хуулийн заалтыг бас илүү хэрэгжүүлэх ёстой. Гэр бүлийн тухай хууль 1999 онд батлагдсан. Өнөөдөр бас шинэчилж найруулж байгаа. Үүнтэйгээ холбогдуулаад нийгмийнхээ хөгжил, өнөөдрийн бас нийгмийн өмнө тулгамдсан хамгийн анхаарал татсан тулгамдсан асуудал болоод байгаа гэр бүл, хүүхдийн асуудал, ээж, хүүхдийн асуудал. Энийг шийдэхэд бас Гэр бүлийн шүүх байгуулж, дагнасан шүүхээр энэ асуудлыг хурдан шуурхай шийдвэрлэж байх нь зөв юм байна гэдэг үүднээс энэ хуулийн төслийг оруулж ирж байгаа.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн шинэчилсэн мэдээллээс аваад үзэхээр Гэр бүлийн хуулиар шийдэгдсэн 4 жилийн дундаж нийт иргэний хэргийн 10 гаруй хувь нь гэр бүлийн маргаантай холбоотой асуудал байгаа. Түрүүн хэлсэн нөгөө гэр бүл салалттай холбоотой сүүлийн жилүүдэд байнга 2022 онд 25 хувь нь салж байсан. 2023 онд 27 хувь, 2024 онд 31 хувь нь салж байсан. Салахаар ар талд нь нөгөө хүүхдүүдийн эрх ашиг илүү их хохирдог, хүүхдийн тэтгэмж олгогддоггүй ийм асуудлууд үүсдэг. Эвлэрүүлэн зуучлах асуудлыг бас хэрэгжүүлдэг байгууллага бүтэц байгаа. Энэ эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны үндсэндээ бол 90 хувь нь амжилтгүй болж байгаа. Дахиад эцэст нь нөгөө ээж, хүүхдүүд хохирдог иймэрхүү бас бодитой асуудлууд байгаад байгаа учраас энэ дагнасан шүүхтэй больё. Энэ мэргэшсэн гэр бүл хүүхэдтэй холбоотой бүх асуудлуудыг нэгтгээд шийддэг байя.

Гэр бүлийн салалтын асуудал, гэр бүл цуцлалтын асуудал, хөрөнгийн маргааны асуудал, хүүхдийн тэтгэмж, хүүхдийг хохироохгүй байх гэх мэтийн энэ асуудлуудыг бүгдийг нь.../минут дуусав/

Н.Учрал: Бямбацогт дарга нэмэлт 1 минут.

С.Бямбацогт: Тэгээд хүүхдийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл гээд энэ бүгдийг нийлүүлээд дагнасан энэ гэр бүлийн харилцаатай, хүүхдийн харилцаатай холбоотой бүх асуудлыг дагнаж шийддэг байх ийм шүүхтэй байх нь зөв юм байна. Сая Сайнзориг гишүүний хэлж байгаа эдгээр асуудлуудыг шийдэхэд өөрөө эх эцэг байх, өөрөө бас эцэг эхийн хайр халамжид бас өссөн байх, гэр бүлийн эцэг байхын, аав байхын, ээж байхын жаргал зовлон, тэр сайхан аз жаргалыг мэдэрдэг хүн бол илүү энд бас ажиллах ёстой гэдэг таны саналтай бол санал, байр суурь 1 байна.

Тэгээд энэ шүүх байгуулах тухай хуулийг хэлэлцэх эсэхийг нь шийдээд хэлэлцүүлгийн явцад бас илүү сайжруулах зүйл заалт байх юм бол сайжруулаад, саяын таны хэлж байгаа саналуудыг тусгаад явах боломжтой гэж харж байна.

Н.Учрал: Даваасамбуугийн Ганмаа гишүүн байхгүй байна. Аюушийн Ариунзаяа гишүүн үг хэлэх юм уу.

А.Ариунзаяа: Сайд нар орж ирсэн байгаа юм чинь асуулт асуулгүй яах вэ. 11 сарын 25-аас 12 сарын 10 хүртэл 16 хоногийн жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аян дэлхий нийтээрээ өрнөдөг. Монгол Улс ч гэсэн үүнд нэгдээд нэлээд олон жил болж байгаа. Энэ зүүгээд байгаа улбар шар алчуур бол өөрөө яг энэ жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аяны хүрээнд бас бэлгэ тэмдэг болж нийтэд энэхүү мэдээллийг хүргэдэг ийм онцлогтой. Би Статистикийн хорооны даргаар ажиллаж байхдаа 2017 онд миний сэтгэлд хамгийн тод үлдсэн нэг судалгаа бол хүчирхийллийн нүцгэн үнэн буюу Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэл ямар дүр төрхтэй байгаа юм бэ гэдгийг гаргаж байсан. Монгол Улсад 3 эмэгтэй тутмын 1 нь дотнын хамтрагчийн зүгээс үйлдсэн бэлгийн болон биеийн хүчирхийллийн хохирогч болсон байдаг. 10 эмэгтэй тутмын 1 нь 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хүчирхийлэлд өртсөн байдаг гэсэн ийм судалгаа манай Монгол Улсын хувьд бол байгаа. Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх энэ 16 хоногийн аян давхцаж бас таарлаа. Нийгэмд 2, 3 эмэгтэй бас шүгэл үлээж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болж байгаа шүү, болсон шүү гэдгийгээ нэлээд чанга дуутай илэрхийлсэн. Нийгэмд бас болсон маш харамсалтай хэргүүд та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа байх. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогч болсон, амь насаа алдсан хүн хүртэл байна. Гэр бүлийг салгахад гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа хүнийг эвлэрүүлэн зуучлах хугацаагүйгээр салгана гэдэг заалт шинээр орж ирж байна уу. Өмнө нь байсан уу. Энэ хэрхэн яаж хэрэгжиж байгаа вэ гэдэг ийм асуулт байна.

Түрүүн Ганмаа гишүүн бас нэг асуултыг асуугаад, тодорхой хариулт авч чадаагүй. Би лавлаж бас асууя. 25.1 дээр байгаа шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авахгүй байж болох бас 1 заалт байгаа нь яг энэ гэрлэгчид эвлэрэх боломжгүй, гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжлийн ноцтой аюул учирч байгаа, хор уршиг учирч болзошгүй, эсвэл учирсан нь тогтоогдсон гэсэн ийм заалт байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ үндсэндээ байнгын хүчирхийлэл гэдэг байнгын гэдэг 1 үгээс болж гэр бүлийн хүчирхийлэлд өртөөд ирж байгаа эмэгтэйд уучлаарай байнгын гэдэг бол 3 удаагийн хүчирхийллийг хэлэх юм гэж тайлбарлан, чи 1 л удаа хүчирхийлэлд өртсөн үү, байж байгаарай дахиад 2 удаа зодуулаад ир тэгвэл салгаад өгье гэдэг байдлаар хандаж байгаа мэт орчуулагдаад байна. Ийм учраас яг гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа эвлэрэхгүй ээ, би салъя, би хүүхдүүдээ бодоод ч тэр, өөрийгөө бодоод ч тэр энэ хүнтэй хамтран амьдрахгүй гэж ирж байгаа эмэгтэйд, эрэгтэй ч байж болно. Шууд салгах арга хэмжээ авч чадаж байна уу, үгүй юу. Үүнийг бас тодорхой хэлж өгөөч ээ.

Гэр бүлийн шүүх үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бэлэн байна уу. 2026 оны 1 сарын 1-ээс уг нь үйл ажиллагаагаа эхлэх хуулийг бид нар баталсан. Тэгээд ер нь одоо бэлэн бус байгаа, төсөв нь ч гэсэн батлагдаагүй гэж хариулах байх. Улсын Их Хурлын гишүүддээ бас уриалах нь байна. Шүүх болоод энэ шүүхтэй холбоотой аливаа зардлыг, төсвийг хасдаггүй..../минут дуусав/

Н.Учрал: Бямбацогт гишүүн хариулъя.

С.Бямбацогт: Гэр бүлийн шүүх байгуулах нэг гол үндэслэл таны ярьж байгаа асуудал. Тэгээд гэр бүл болохдоо, тэгээд л хайртай, дуртай, хэзээ ч хагацахгүй,

салахгүй, насан туршдаа хайрлана гэж байгаад суучихдаг. Тэгээд хуримаа хийгээд, үр хүүхдээ гаргаад, ажил амьдралын стрессээс болоод бас гэр бүлдээ хүчирхийлэл үйлдэх, эцэст нь нөгөө төрсөн үр хүүхдээ бас амьтны үр ангирын зулзага гээд л хайрладаг мөртөө зовоодог, гэр бүлийн хүчирхийллийн байнгын дарамтад өртдөг ийм явдал бол их байсан. 2016 онд Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тухай хуулийг бас миний бие Хууль зүй, дотоод хэргийн сайд байхдаа бас Их Хурлаар батлуулж, энэ хууль батлагдсанаас хойш үндсэндээ гэр бүлийн хүчирхийлэл бол эрс багассан. Эрс багассан. Харьцангуй бас сайн хэрэгжиж байгаа хуулиудын нэг гэж бас харж байгаа. Гэхдээ юу гэдэг юм таслан зогсоогдоогүй. Гэр бүлийн хүчирхийлэл бас үйлдэгдсээр байгаа. Энэ үйлдэгдэж байгаа гэр бүлийн хүчирхийллийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдээд тэр нь удаа дараа болчих юм бол шууд таслан зогсоох, гэр бүлийг салгах ийм зохицуулалт байхгүй байгаад байгаа юм. Хүчирхийлэл үйлдэгдсээр байтал нь нотлохыг шаарддаг, гэрлэлт цуцалт нэхэмжлэлийг хүлээж авахгүй байх талаар бас иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлд, Гэр бүлийн тухай хуулийн 14-д бас заачихсан байгаад байгаа юм. Хүүхдийн болон гэр бүлийн гишүүдийн эрх, эрх чөлөөг хязгаарласан ийм заалт. Өөрөөр хэлэх юм бол нотол. Нотолж байж удаа дараа хүчирхийлэл үйлдэх энэ заалтыг шинэ хуулиар бол хүчингүй болгож байгаа. Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй бол заавал нотлох баримт шаардахгүйгээр хүсэлтийг нь хүлээж авна. Эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг шаардахгүй. Ийм байдлаар энэ асуудлыг шийдэхээр энэ Гэр бүлийн шүүх байгуулах тухай хуульд бас орж ирж байгаа. Тийм болохоор таны ярьж байгаа энэ гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байгаа, үүнээс болж салах хүсэлтээ гаргасан гэр бүлийн асуудлыг бол шууд шийдээд явах боломжтой болж байгаа гэдгийг бас хэлье.

Та бас 2020 онд та Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд байсан. Энэ үедээ бас Гэр бүлийн тухай хуулийг Их Хуралд бас оруулж ирж байсан хүний хувьд энийг сайн мэдэж байгаа байх. Мөн бас хэлэлцэх эсэх нь шийдэгдээд ажлын хэсэг байгуулах үед бас энэ асуудал дээр бас илүү анхаарал тавиад, илүү бас сайжруулаад ажиллах боломж бас танд байгаа гэдгийг бас хэлье.

Н.Учрал: Ариунзаяа гишүүн тодруулна.

А.Ариунзаяа: Байнгын хүчирхийлэлд өртөж байгаагаа нотлох гэдэг маань өөрөө эргээд дахиад ажлын хэсгийнхээ хүрээнд хэдүүлээ засъя гэдэгтэй та санал нэгдэж байна гэж би ойлголоо. Одоогийн байдлаар байнгын гэдгийг 3 ба түүнээс дээш гэж л ер нь Дээд шүүхийн тайлбар байдаг юм байна гэж би хариултуудаас ойлгоод байгаа шүү дээ. Тийм ойлголт байгаа юу, байхгүй юу. Байнгын гэдгийгээ бас юу гэж үзэх вэ гэдэг асуултыг л асуумаар байгаа юм.

Тэгээд ер нь бол бид нийгэмд бас уриалах нь хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн 1 хүрэхгүй хувь нь ер нь цагдаад хандсан байдаг. Бусад нь бүгдээрээ тэвчээд, чимээгүй өнгөрсөн байдаг. Байх ёстой юм шиг л ийм ойлголттой байгаа нь бол өөрөө орчин цагт ердөөсөө хүлээн зөвшөөрөх, тэвчих асуудал биш юм гэж. Тэгэхээр хохирогчдыг буруутгадаг асуудлыг бүх нийтээрээ бас болих хэрэгтэй. Тэгээд эр эмийн дундуур илжиг .../минут дуусав/

Н.Учрал: Санал хэллээ. Ажлын хэсгээс нэмж хариулъя. Батцэрэн шүүгч хариулах уу. 4 дүгээр микрофон.

П.Золзаяа: Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Золзаяа. Энэ зохицуулалт өмнө нь Гэр бүлийн тухай хуульд байсан. Одоо ч гэсэн энэ хуульд орсон байгаа. Энэ мэдээж эвлэрүүлэх арга хэмжээг авахгүйгээр шууд цуцлах тийм үндэслэл шалтгаан бол амьдрал дээр байгаа. Тэрийг хуульд буулгасан байгаа байдал нь бол энэ байгаа юм. Тэгэхдээ байнгын гэдгийг яах аргагүй тайлбарлахдаа бол байнгын шинжтэй, 3-аас дээш удаа ч гэдэг юм уу гэж томъёоллын хувьд бол тодорхойлдог. Гэхдээ гэрлэлт цуцлах тухайд бол шүүхийн практикт энийг бол өөрөөр ойлгож, тайлбарлаж, хэрэглэж явж байгаа. Өөрөөр хэлбэл үнэхээр тэр байнгын биш ч бай, ер нь тэр хүчирхийллээс болоод эрүүл мэнд, амь насанд нь ямар нэгэн хохирол учруулахаар болзошгүй эсвэл учирсан байгаа бол энд эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр цуцалж болно гэж ... /минут дуусав/

Н.Учрал: Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууна.

Д.Ганмаа: Өөр асуулт асуух гэж байсан боловч энэ байнгын дээрээ бас л тодруулмаар л санагдаад байна л даа. Дуусаж өгөхгүй. Өмнөх дээр нь асуухад энэ Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль дээрээ туссан байгаа гэсэн боловч аль аль хууль дээр нь тусаагүй байна. Уг нь танилцуулга дээрээ яг энийг засаж залруулж, хийдлийг зүгээр болгоно гэж оруулж ирсэн мөртөө энэ байнгын гэдгийгээ хууль зүйн тусгайлан ийм бэлтгэгдсэн байдлаар оруулж ирэхгүй бол шүүх болгон, дүүрэг болгон дээр ч юм уу өөр өөрөөр тайлбарлаад, хүн хүн дээр өөр өөрөөр хэрэгжилт үүсээд байна гэдэг л асуудлыг яриад байна л даа. Тухайлан Гэр бүлийн шүүхэд хянан шийдвэрлэх хууль дээр байгаа хэдэн асуулт маань энэ Гэр бүл, хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх дагнасан шүүх байгуулах гэж байгаа нь сайн хэрэг. Энд ажиллах гэж байгаа шүүгч, шинжээч, эвлэрүүлэн зуучлагч нар нь бол мэргэжлийн зөвхөн хууль хэрэглэх мэдлэг ур чадвараас гадна гэр бүл, хүүхдийн хэрэгт зайлшгүй шаардлагатай soft skill гэж ярьдаг. Бэлтгэдэг эсвэл тийм чадвартай хүмүүсийг сонгон шалгаруулах талаар ямар нэгэн тийм бодитой төлөвлөгөө туссан уу, үгүй юу гэдэг дээр асуулт байна.

Мөн тухайн гэр бүлийн буюу хүүхдийн хэргийн шүүхийн онцлогоос шалтгаалан хүүхэд болон хохирогчид ээлтэй орчин, аюулгүй байдал, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, дотоод зохион байгуулалтын тал дээр бас хэрэгжилтийн ямар нэгэн төлөвлөгөө боловсруулсан юм байгаа юу гэдэг асуулт байна.

3 дугаарт энэ гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүстэй харьцаж байгаа хууль сахиулагчид нь өөрсдөө гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдлэг, ур чадвар ямар түвшинд байдаг вэ. Тэдний мэдлэг, ур чадварыг сайжруулах талаар ямар нэгэн мөнгө төгрөг, санхүүжилт ч юм уу, тусгай хөтөлбөр энэ тэр суулгасан юм байдаг уу. Ямар арга хэмжээнүүд байдаг вэ гэдэг дээр хариулж өгөх үү.

Н.Учрал: Бямбацогт дарга хариулах уу. Ажлын хэсгээс хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Ганмаа гишүүний асуултад хариулъя. Шүүгч болон шүүхэд ажиллах эвлэрүүлэн зуучлагч, мөн нөхцөл байдлын шинжээч энэ тэрд тавигдах шаардлага зүйлүүдтэй холбоотой зүйлүүд бол энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн хүрээнд шүүгчийн сонгон шалгаруулах хүрээндээ ямар шүүгчийг шилж сонгох вэ гэдгээ шийдвэрлэх боломжтой гэж үзсэн учраас энэ хуулиуд дээр бол шүүгчид тавигдах шаардлагатай холбоотой зүйл орж ирээгүй. Харин энэ хуулиуд дээр бид нар нөхцөл байдлын шинжээч, эвлэрүүлэн зуучлах баг энэ тэрд ажиллах орон тооны бус

зөвлөлийн гишүүд, эвлэрүүлэн зуучлагч энэ тэр дээр социологич, сэтгэл зүйч, боловсрол, нийгмийн чиглэлээр мэргэшсэн байх энэ тэр гэдэг энэ шаардлагуудыг тавьж өгсөн байж байгаа.

Гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр хууль сахиулах албаныхан энэ талын ойлголт, мэдээллийн асуудлаар төлөвлөгөө зүйлүүд байна уу гэж. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар бол Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл бас Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэд ажилладаг. Энэ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн хүрээнд бол гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой ойлголт, мэдээллийг хууль сахиулах байгууллага буюу мөрдөгч, прокурор, мөн өмгөөлөгч зэрэг мэргэжлийн хүмүүст бол сургалт зохион байгуулах, үүний талаарх ойлголт, хандлага юу гэдэг юм гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдээс мэдүүлэг авахдаа юуг анхаарах вэ гэдэг чиглэлээр олон улсын туршлагатай зөвлөх энэ тэрээс сургалтыг авч зохион байгуулдаг. Ялангуяа Хууль сахиулах их сургууль дээр бол мөрдөгч бэлтгэх сургалтын хөтөлбөрт энэ чиглэлийн агуулга тусаж бас явж байгаа. Дахин мэргэшүүлэх энэ тэр асуудал дээр бас энэ сургалтын төвүүдээрээ дамжуулж хууль сахиулагч нарт хүчирхийлэлд өртсөн хүмүүсээс мэдүүлэг авахтай холбоотой энэ чиглэлийн сургалтуудыг ороод явж байгаа.

Н.Учрал: Ганмаа гишүүн тодруулъя.

Д.Ганмаа: Түрүүн байнгынх дээрээ бас үлдчихлээ. Эхний асуулт дээр асууж байхад энэ хууль дээр орж ирнэ гэсэн учраас би сая бас давхар харлаа. Тэгээд энэ гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4 дэх хэсэг дээр хүүхдийн болон гэр гэр бүлийн гишүүдийн эрх, эрх чөлөөг хязгаарласан зохицуулалт болчихсон байна. Ийм учраас энэ хүчирхийлэлтэй холбоотой шинжтэй байвал заавал нотлох баримт бол шаардахгүй. Жишээлбэл, шүүх эмнэлгийн ч юм уу гэх мэтчилэн зүйлүүд орсон мөртөө яг ингээд тодорхойлсон заалт, зүйл энд ороогүй. Энийг шаардахгүй байх талаар эд нарт хохирогчид илүү ээлтэй байдлаар шийдэхийн тулд тусгайлсан тийм заалт байвал их зүгээр санагдаад байгаа юм. Тэгэхгүй бол энэ заалт нь өөрөө ийм асуудалтай байгаа талаар үзэл баримтлалдаа бол өөрсдөө хууль санаачлагчид маань тусгачхаад, хууль нь .../минут дуусав/

Н.Учрал: Бямбацогт гишүүн хариулъя.

С.Бямбацогт: Энэ байнгын хүчирхийлэл гэдэг дээр хуулийн төслийн 20 дугаар зүйл дээр бас тодорхой орсон байгаа. Тэгээд гэр бүлийн нөхцөл байдлын шинжилгээ хийнэ гээд. Гэр бүлийн нөхцөл байдлын шинжилгээг шинжээч хийнэ. Мөн бас аюулын зэргийн үнэлгээгээр цагдаагийн байгууллагаас аюулын зэргийг нь тогтоож, энэ 2 үндэслэл, энэ 2 нөхцөл байдлыг үзэж байж байнгын мөн үү, байнгын биш 1 удаагийн тохиолдол байсан уу гэдгийг нь тогтооно гээд хуулийн төсөлд бас тодорхой заалт орсон байгаа. Тэгэхээр энэ заалтын дагуу үндсэндээ байнга хүчирхийлдэг байх юм бол гэр бүлийг цуцлах, дараагийн арга хэмжээг авах. Байнгын биш байх юм бол бас эвлэрүүлэн зуучлах гэх мэтээр ингээд зохицуулна гээд үндсэндээ тодорхой процесс бол энэ хуульд туссан байгаа.

Хэрвээ жоохон тодорхой биш байна гэж үзэх юм бол нэмээд бас сайжруулаад, өшөө илүү тодорхой болох эрх нь бол Улсын Их Хуралд байгаа. Тэгээд Их хурлын хэлэлцүүлгийн явцад бас сайжруулж болно.

Н.Учрал: Дахиад тодруулах юм уу. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Баярлалаа. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль бас их чухал байгаа. Ирэх жилээс гэр бүлийн дагнасан шүүх байгуулагдаад ирэхэд. Тэгээд яах вэ, бид нар хууль гаргаад байдаг. Амьдрал дээр яаж хэрэгжиж байна гэдэг дээрээ маш сайн анхаармаар юм шиг байгаа юм. Тэгээд бодит амьдрал, бодит кэйсүүдийг харахаар юун дээрээ байгаад байна гэдэг дээр маш сайн нөхцөл байдлын дүгнэлт хийхгүй бол гоё гоё юм ярьдаг. Тэгээд хэрэгжихдээ их буруу хэрэгждэг. Эсвэл хойрго хэрэгждэг юмнууд ч байна. Тэгээд яг түрүүн бас би дурдаж байсан. Асуудал гэвэл энэ гэр бүл цуцлалтын асуудал, гэр бүлийн хүчирхийлэл байдаг юм уу эсвэл ингээд салж амьдраад, нөгөөх нь өөр хамтран амьдрагчтай болоод 7, 8 жил болчихсон үед шүүхэд нэхэмжлэл гарахаар эвлэрээд ир гээд хугацаа өгөөд явуулчихдаг. Тэгээд дахиад нөгөөдхөө яах гэхээр нөгөө хүн нь байр, орон сууцаа хуваахгүй гэдэг юм уу, хүүхдийн тэтгэлэг тогтоохгүй зорилгоор алга болчихдог. Нөгөө оршин суугаа газраа байдаггүй. Тэгээд бөөн юм болж байж нөгөө нэхэмжлэгч маань дахиад л өөр дүүргийн шүүхэд хандана. Дахиад л нөгөө дүүргийн шүүх нь болохоор дахиад л эвлэр гээд явуулчихдаг процесс нь энэ юм гээд. Ингэсээр байгаад 3, 4 жил ингээд болсон кэйс байна. Үр дүнд нь тэнд хүүхдүүд л хохирч байна. Эцгээсээ ямар ч тэтгэлэг авч чадахгүй, ямар ч дэмжлэг авч чадахгүй. Тэгээд яагаад ийм болоод байна гэхээр шүүхэд эрэн сурвалжлах гээд яахаар тэр зарлан дуудах, эрэн сурвалжлах ажиллагаа дээр их асуудал гарч байна. Хаяг нь тогтоогдохгүй байна. Чи өөрөө олж ир. Цагдаад хандана эрэн сурвалжилга хийнэ. Олдохгүй байна, чи өөрөө олж ир гээд. Нөгөө хүүхдэдээ тэтгэлэг авах гээд, энэ чинь эрхээ эдлэх гээд явж байгаа хүн дээр давхар давхар ачаа гараад байгаа юм. Тэгээд энэ яах вэ, дагнасан шүүхтэй болж байгаа юм. Бас нэг давуу талыг та бүхэн бас хэлээч. Би энд Гэр бүлийн шүүхийн харьяаллыг харахаар нэг бол гэр бүл цуцлалттай холбоотой асуудал нийслэл дэх дагнасан шүүх дээр очих гээд байна уу. Эсвэл 7.2-оор анхан шатын шүүх дүүргийн шүүх рүү очих гээд байна уу. Хэрвээ дүүргийн шүүх рүү очихоор бол дахиад л гэр бүлийн хэргийн нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана гэж байгаа юм. Тэгээд хариуцагчид нь зугтаад явчихдаг байхгүй юу. Цуцлуулахгүй. Цуцлуулах юм бол эд хөрөнгөө хуваачихна. Тэтгэлгээ тогтоолгочихно. Яршиг гээд. Тэгээд явж байгаа энэ хүмүүсийн бид нар амьдралыг нь энэ шүүх шударга ёсыг нь тогтоохын тулд энэ процессуудыг нь жоохон амьдралд нийцсэн болгохын тулд бүгдээрээ яах ёстой вэ гэдэг дээр та бүхнээс бас тодруулга авмаар байна. Шүүхийнхэн маань ч гэсэн энд оролцсон байна. Ийм ийм процессын асуудлаас 2, 3 жил болж байгаа кэйсүүд их байна. Бүр аргаа ядаад үнэхээр энэ чинь мухардал орчхоод байна гээд хандаж байгаа ч кэйсүүд байна. Тэгээд энийг яаж шийдэх юм бэ. Ингээд алга болчихдог, хаяг нь тодорхойгүй болчихдог, зугтаад байдаг энэ асуудлыг энэ хуулиар ер нь яаж шийдвэрлэж байгаа юм. Эсвэл энэ харьяаллаараа дахиад л хариуцагчийн оршин суугаа газарт л шүүхэд гаргана гээд. Энэ эрэн сурвалжлах ажиллагаа, зарлан дуудах ажиллагаа маань хэр үр дүнтэй явж байгаа юм. Хүн хүч нь бага байдаг юм уу. Уг нь бол Улаанбаатар хот, Монгол улс цөөхөн хүн амтай, их тийм том газар биш шүү дээ. Эрэн сурвалжлаад олоход хаягжилт дээр байдаг юм уу, юун дээр хүндрэл учраад байдаг юм. Энэ дээр та бүхэн бас хариулт өгөөч.

Н.Учрал: Хэн хариулах вэ. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Золзаяа. Ажлын хэсэг хариулна.

П.Золзаяа: Харьяаллын хувьд бол энэ хуулиар их тодорхой зохицуулж өгсөн. 7.2 аль шүүхэд хандах юм бэ гэдгийг бол ойлгомжтой зохицуулж өгсөн. Энд

нийслэлд бол Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатын тойргийн шүүх буюу дагнасан шүүх байх учраас нийслэлийн хэмжээнд бол гэр бүлийн энэ асуудлаар бол энэ шүүхэд хандчихаж байгаа. Энэ дагнасан шүүхдээ. Үүнээс бусад тохиолдолд буюу 7.2-т зааснаар гэр бүлийн маргааныг орон нутагт жишээлбэл тухайн шатын анхан шатын шүүх шийднэ гэсэн ийм зохицуулалттай байгаа юм. Ер нь бол гэр бүлийн харилцаа бол их онцлог харилцаа. Хуулиар зохицуулсан олон асуудал байдгаас гадна ёс суртахууны маш олон үүргийн харилцаа байдаг. Тэгээд үүнтэй холбоотой шүүхэд бол нэлээн мэдрэмжтэй, тэгээд нэлээн өргөн хүрээнд алсыг харж чаддаг ийм ажиллагаанууд шаарддаг. Тийм учраас ийм дагнасан шүүхэд бол шүүгч нь ч гэсэн мэргэшсэн байх ёстой гэдэг ийм шаардлагыг тавиад, энэ үүднээс ч гэсэн сонгон шалгаруулалт явагдаад байгаа юм.

Тэр эвлэрэх боломжгүй гэдэг дээр сая үнэхээр ийм асуудлууд бол гарсан. Яагаад гэвэл ерөөсөө эвлэрэх боломжгүй юман дээр эвлэр гээд яваад байдаг ийм асуудлууд практикт гарсан учраас энийг судалж үзээд, энэ хуулийн 25 дугаар зүйл дээр эвлэрэхгүйгээр шууд гэрлэлтийг цуцалж болох ийм нөхцөлүүдийг хуульчилж өгсөн байна.

Хаягийн асуудал дээр энэ бол шүүхэд болон шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд байнга байсан, хамгийн хүндрэлтэй асуудал байгаа. Тэгэхээр энэ гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд бол энэ хариуцагчийг яаж олох вэ, хариуцагчийг шүүхэд яаж ирүүлэх вэ гэдгийг нэлээн нарийвчилж зохицуулж өгсөн. Үүний 1 онцлог нь гэвэл бас шүүх санаачилгаараа тодорхой ажиллагаануудыг хийхийг энэ хуулийн 14 дүгээр зүйлд маш тодорхой зааж өгсөн байгаа. Энэ нь бол өмнөх хуулиас илүү учирч байгаа бэрхшээлийг бас зохицуулсан ийм шинжтэй байгаа.

Н.Учрал: Номинчимэг гишүүн тодруулъя.

О.Номинчимэг: Баярлалаа. Гол нь тэр шийдвэр гүйцэтгэл, тэр нөгөө гүйцэтгэл дээрээ л бид нар амьдрал дээр энэ маань хэрэгждэг, хурдан түргэн иргэддээ чирэгдэл гаргахгүй энэ тал дээр нь бас их анхаарах ёстой л байгаад байгаа юм. Тэгэхгүй бол цагаан дээр хараар бичсэн бид нар хэчнээн гоё хууль баталлаа гээд яг энэ маань өөрөө үр өгөөжөө өгөхгүй бол үр дүн нь гарахгүй байна.

Тэгээд сая Золзаяа шүүгчийн хэлж байгаа 7.1, 7.2 дээр их тодорхой биччихсэн гэхээр надад бол тодорхой санагдахгүй байна. Энэ иргэдэд бол бүр ч тодорхой биш. Яагаад гэвэл нийслэлийн хэргийг бол нийслэл дэх гэр бүлийн газар гэж заагаагүй. Энэ хуульд заасан гэр бүлийн хэргийг гэхчхэн байгаа байхгүй юу. Энд бол заасан гэр бүлийн хэрэг нь 5.1 дээр байгаа юм. Тэгээд 7.1-д зааснаас бусад тохиолдол гэхээр энэ хуульд заасан гэр бүлийн хэргүүд нь ийшээ, бусад нь бусад дүүргийн шүүх дээр ч гэсэн байж болохоор. Тэгээд энэ асуудал нь гэр бүлийн хэргийн нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд хандана гээд 8.1. Би бол хуульч хүний хувьд тэгж хараад байгаа байхгүй юу. Тэгээд нийслэлийн асуудал зөвхөн Нийслэлийн шүүх дээр бөөгнөрнө гэж харахгүй байгаа.../минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт тодруулга хийх үү. Номинчимэг гишүүн.

О.Номинчимэг: Тэгэхээр яг гэр бүл цуцлалтын асуудал чинь энэ хуульд заасан гэр бүлийн хэрэг буюу 5.1.1-д байгаа гэрлэлтэй холбоотой маргаан гэдэгт орж байгаа юм уу. Бүх гэр бүл цуцлалтын асуудал чинь 7.1-ээрээ Нийслэл дэх гэр

бүл, хүүхдийн хэргийн анхан шатын тойргийн шүүхэд анхан шатаар, бусад бүх хэргүүд бол давж заалдах шат нь нийслэл дэх болчхож байгаа шүү дээ. Захиргааны хэргийн шүүхтэй адилхан ингээд байна уу. Энэ дээр жоохон тодруулаад өгөөч. Тэгээд энийг мэдээж хэлэлцүүлгийн явцад бүгдээрээ илүү тодорхой болгоод яваад ажиллачих боломжтой гэж үзэж байгаа. Гэхдээ энэ дээр яг ямар үзэл баримтлалаар оруулж ирсэн юм гэдгийг тодруулаад өгөөч гэж хэлэх гэсэн юм.

Н.Учрал: Ер нь эмэгтэй гишүүд асуугаад, бүсгүйчүүд асуугаад эмэгтэй ажлын хэсгийн гишүүд хариулаад дууслаа шүү. Энэ эрэгтэйчүүд бас Гэр бүлийн хууль дээр хариуцлагатай байхгүй бол энэ танхимд чинь эрэгтэй хүн алга байна. Ховорхон байна шүү. Одоо тэр нэрийг хар. Дандаа эмэгтэй гишүүд л асууж байна. Ажлын хэсгийг хар. Золзаяа Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн хариулж байна. Хууль зүйн яамнаас Оюунзул хариулж байна. Тэгээд Мягмар дарга, Бямбацогт дарга 2 дундуур нь орж байна. Иймэрхүү байдалтай Гэр бүлийн хуулийг хэлэлцэж байна. Ажлын хэсэг хариулъя.

О.Оюунзул: Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Оюунзул. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл маань одоо байгаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн гэр бүлийн холбогдолтой хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааны бүлгийг болон онцгой ажиллагааны журам дээр байдаг жишээ нь эцэг эх тогтоох, эцэг эх байх эрхийг хасах, хязгаарлах энэ онцгой ажиллагааны хүсэлтээр үүсдэг, шийдвэрлэдэг хэргүүдийг нийлүүлээд, бас Гэр бүлийн тухай хууль дээр байгаа, бас байж болох маргаануудыг тодорхойлоод, гэр бүлийн хэрэг гээд тодорхойлсон. Тэгээд бусад улсууд, жишээлбэл, Солонгос улс, Япон улс зэрэг улсуудад бол бас гэр бүлийн хэрэг гэж тодорхойлоод А, В, С категорид ангилж байгаад, онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх нь энэ хэргүүд, ердийн журмаар шийдвэрлүүлэх нь энэ хэргүүд гэж ангилаад, тэгээд тодорхой нөхцөл байдлын шинжилгээ хийх журам эд нар нь энэ хууль дээрээ байгаад, бусад нь бол Иргэний процессын хууль дээрээ байдаг.

Тэгээд энэ харьяаллын хувьд гэрлэлт цуцлах эдгээр энэ онцгой ажиллагааны журмаар .../минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут.

О.Оюунзул: Харьяаллын хувьд энэ гэрлэлт цуцлалт, тэтгэлэг асрамж, эцэг эх байх эрхийг хасах, хязгаарлах эдгээр гэр бүлийн гэх тодотголтой хэргүүд маань нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Сүхбаатар гэсэн дүүргүүд дээр үүссэн анхан шатын Гэр бүл, хүүхдийн тойргийн шүүх дээр хариуцагчийн нутаг дэвсгэр байх юм бол энэ шүүхэд хандана. Бусад нутаг дэвсгэрт нь хариуцагчийн тухайлбал Багахангай дүүрэг ч юм уу, эсвэл Хөвсгөл аймаг байх юм бол тухайн ердийн иргэний хэргийн шүүхэд энэ гэр бүлийн хэргийн талаарх нэхэмжлэлийг гаргана.

Дээрээс нь энэ дээр бас тодруулж хэлэхэд хариуцагчийн хаяг дээр хүндэтгэн үзэх шалтгааны улмаас очих боломжгүй байх юм бол сонгож авсан буюу нэхэмжлэгч өөрийнхөө оршин суугаа газрын нутаг дэвсгэрийн шүүхэд хандах боломжтой байдлаар бол хуульчилж өгсөн байгаа.

Н.Учрал: Баярлалаа. Ер нь ингэхэд нөгөө тэтгэмжийн асуудлыг яаж шийдсэн билээ энэ хууль дээр. Хүмүүс бол их сонирхож байх шиг байна шүү дээ. Тэгээд энэ амьжиргааны түвшинтэй нь харьцуулаад, нөгөө тэтгэмж өгдөг асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн бэ. Энэ хариуцлагагүй хүмүүс хүүхдийнхээ тэтгэмжийг өгдөггүй. Орчин үеийн Шагдар олон байна гэж хүмүүс ярьж байна шүү дээ. Тэгэхээр тэр хүмүүст ямар хариуцлага ноогдуулах вэ. Тэгээд энэ тэтгэмжийг нь орлоготой нь дүйцүүлж тооцох асуудлыг шийдэж чадсан уу гэдэг асуултад Бямбацогт дарга хариулна. Бямбацогт гишүүний микрофоныг өгье.

С.Бямбацогт: Салсан гэр бүлд нөгөө тэтгэмж олгох буруутай ер нь ихэнхдээ эрчүүд. Тэгээд тэтгэмж олгоход хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тэтгэмж олгодог. Бүсчлэл тогтоодог. Тэр нь өнөөдрийн байдлаар 450 орчим мянган төгрөгийн талаар нь. Тэгээд гэр бүл салсан хүүхдүүдэд сард 230 орчим мянган төгрөгийн тэтгэмж дунджаар олгохоор ийм л хуультай байгаа. Тэгээд өнөөдөр 230 мянган төгрөгөөр яаж ажиллаж амьдрах вэ, бас хэцүү. Бүгд мэдэж байгаа. Энэ хуульд бас оруулж байгаа өөрчлөлтөөр бол тэр тэтгэмж олгох эцэг болон эсвэл эх, түүний хөрөнгө орлогоос нь хамаарч тэтгэмжийг нэлээн хөрөнгөтэй орлоготой бол ахиухан тэтгэмж тогтоох. Мөн бас хүүхдийн хэрэгцээ шаардлагаас бас хамаарч олгодог байх ийм зохицуулалтууд орсон. Нөгөө 0-11 настай бас бага, 11-18 хүртэл нь арай жаахан ахиу олгох байсан бол үндсэндээ 0-21 нас хүртэл нь үндсэндээ хүүхдүүдэд тэтгэмж олгохоор, хөрөнгө орлогоос нь хамааруулж, мөн хүүхдийн хэрэгцээ шаардлагаас нь хамаарч олгох ийм зохицуулалтууд орсон. Тэгээд энэ зохицуулалтын дагуу бол үндсэндээ эцэг эхчүүд хүүхдэдээ тэтгэмж олгох, эцэг эхийн үүргээ биелүүлэх хэдийгээр салсан ч гэсэн энэ үүргийг нь бас хариуцлагажуулж өгсөн байгаа гэдгийг бас хэлье.

Н.Учрал: Их хариуцлагатай хууль болж байгаа. Тэгээд Их Хурлын гишүүдийг танхимд урьж байна. Гэр бүлийн хуулийг хэлэлцэх эсэхийг дэмжих санал хураалт явуулна шүү. Тэгээд эсрэг санал хураалтад гарчхаад, дараа нь олон юм ярьж тайлбар тавихгүй. Тэгэхээр гишүүдийг танхимд урьж байна. Гэр бүлийн хууль хэлэлцэж байна. Та нар танхимдаа орж ирмээр байна. Хэдэн эмэгтэй гишүүд асуултад хариулаад ингээд сууж байдаг ийм л боллоо шүү дээ. Энэ чинь Монголын амьдрал ер нь хэдэн эмэгтэйчүүдийн л нуруу дээр явж байгаа нь угаасаа хаа сайгүй харагдаж байгаа. Тийм учраас эрчүүд орж ирж танхимдаа сууцгаа. Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууна.

О.Саранчулуун: Баярлалаа. Салсны дараа тусдаа амьдрахаар эцэг эх хүүхэдтэй уулзах хугацааг тогтооно. Тэгэхдээ хүүхдийн нас, эцэг эхийн ажлын ачаалал, хүүхдийн сонирхлыг харгалзан үзнэ гэж байгаа юм. Тэгэхээр ажлын ачаалал гэдгээс илүү эцэг эхийнх нь нөгөө хүчирхийлэгч зан үйл ч юм уу, тэр дадал зуршлыг нь харгалзан үздэггүй юм уу. Салсны дараа ээж аавд нь ч юм уу өгөөд явуулчихаар бүр зодож нүдээд, зовоогоод, хоол ундыг нь буруу хооллоод, харшилтай ийм байдаг бол тэрийг нь уулгаад ирүүллээ гэдэг кэйс амьдрал дээр зөндөө л байдаг шүү дээ. Тэгэхээр манайх энэ гэр бүлийн салсны дараах интервенц гэдэг асуудал дээр ер нь энэ хууль, энэ харилцаа ямар ахиц дэвшил гаргах вэ. Салсны дараа ер нь бол салалт чинь хүчирхийллээс л болж салж байгаа шүү дээ. Ямар нэгэн төрлийн хүчирхийллээс. Салалтын үед өмнө ба дараа хүчирхийллийн нөхцөл байдал бүр хүндэрдэг. Тэр үед хүүхдийн сэтгэл санаа хохирол бүр их нэмэгддэг. Энэ дээр ямар нэгэн байдлаар ямар бодлого ахиц байгааг яримаар байна.

2 дугаарт нь гэр бүл бол зөвхөн эхнэр, нөхөр, хүүхэд 3-ын харилцаа ч бас биш л дээ. Энэ дотор чинь ахмад настай хүмүүс байгаа. Гэр бүл доторх өөрөө бие даан өөрийгөө асрах чадваргүй ахмад настай хүмүүсийн буюу харгалзан дэмжигч гэж энэ хууль дээр орсон энэ хүмүүсийн нөхцөл байдлын үнэлгээг хэн хийх вэ. Одоо байгаа хуулийг харахаар гэр бүлийн шинжээч нь гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийнэ гэж байна. Хүүхдийн эрсдэлийн үнэлгээ хийнэ гэж байгаа юм. Тэгвэл 3 дахь бүлэг хүмүүс болох тэр асран хамгаалал шаардаж байгаа хүмүүсийн асуудлыг хэн үнэлэх юм. Хохирогч гэдэг та бүхэн ямар ямар ойлголтуудыг ярьж байгаа, тэр болгон дээрээ энэ шинжээч нөхцөл байдлын үнэлгээ хийж хохирлыг барагдуулах уу. Энэ шийдвэр хаана гарах вэ гэдгийг тодруулмаар байна. Тэгээд хариултынх нь дараа дахиад 1 юм тодруулах юм байна.

Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх урьдчилсан арга хэмжээ гээд 14 дүгээр зүйл дээр байгаа юм. Хэрвээ тухайн тохиолдол хүчирхийлэл асуудал боллоо гэхэд хохирогч гэр бүлийн нөгөө өмч нь хэний нэр дээр байгаагаас хамаараад явж явж аягүй бол хохирогч гэрээсээ хол явах хэрэгтэй болдог. Тэгэхээр хохирч байгаа хүнээ хамгаалахгүй бол яг үнэндээ хүчирхийлэгчээсээ холдох ямар ч орон зай байдаггүй байхгүй юу. Явах газар байхгүй. Өмчлөгч нь магадгүй хүчирхийлэгч өөрөө байж болно. Тэр үед энэ асуудлыг яаж шийдэх вэ. Ийм асуултууд байна.

Н.Учрал: Бямбацогт гишүүн хариулна.

С.Бямбацогт: Тэгэхээр гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг бас урьд нь хамгаалах эрх зүйн орчин байдаггүй. Очих газар, орон гэр байхгүй болохоороо арга барахаараа хэд хоног муудалцаад аав ээж дээрээ, эс үгүй бол ах дүү нар, найз нөхөд дээрээ очиж хэд хоночхоод, тэгээд аргагүйн эрхэнд буцаад гэртээ очдог дахиад хүчирхийлүүлдэг ийм байдал бас байсан. Тэгээд түрүүн би бас хэлсэн. 2016 онд Хууль зүй, дотоод хэргийн сайд байхдаа энэ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг Их Хурлаар оруулж батлуулж, Гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцдог болсон. Гэмт хэрэгт тооцдог болсон. Үүнийг дагаад эрс гэр бүлийн хүчирхийлэл буурсан. Нөгөө хүчирхийлдэг нөхөр гэмт хэрэгтэн болгохгүйн тулд. Мөн бас гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байгаа гэмт хэргийг хараад, үзээд, мэдээд, сонсоод ярьдаггүй, хэлдэггүй, мэдээлдэггүй иргэнд хариуцлага тооцдог болсон. Нөгөө эр эмийн хооронд илжиг бүү жороол гээд хуучин монголчууд бол уламжлалт аргаараа яршиг яршиг, авгай, нөхөр хоорондоо муудалцаж байхад хол явъя гээд холдоод явчихдаг байсан бол одоо заавал мэдээлэх үүрэгтэй болж, ингээд үндсэндээ гэр бүлийн хүчирхийлэл бас буурах тодорхой зохицуулалтыг оруулж өгсөн.

Сая таны асууж байгаа хохирогчдыг яах вэ гэж. Энэ гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах байртай болсон. 21 аймаг, Улаанбаатар хотын дүүргүүд бас гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд очоод байрлах ийм байртай болгосон. Энэ бодлогуудын үр дүнд үндсэндээ саяын хэлж байгаа гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийн асуудлыг шийдэх ёстой ийм бололцоо эрс багассан. Гэхдээ бол байгаад байгаа. Тийм болохоор бас энэ асуудал дээр энэ хуулиар дахиад процессжуулж энэ шүүх дээр сая таны ярьж байгаа асуудлыг бас шийдэх асуудал бас нэмж орж байгаа.

Тэгээд энэ тусдаа амьдарч байгаа эцэг, эх хүүхэдтэй уулзах хугацааг тогтоох, мөн бас сая ярьж байгаа тэр хөрөнгө орлоготой холбоотой асуудал дээр манай ажлын хэсгээс нэмээд хариулчихъя тэгэх үү.

Н.Учрал: Ажлын хэсэг нэмж хариулъя. Мягмар дарга.

Н.Мягмар: Гэр бүл салсны дараах хүчирхийлэлтэй холбоотой, нөхцөл байдлын үнэлгээтэй холбоотой зохицуулалтын талаар Саранчулуун гишүүн асуулаа. Энэ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хууль энэ тэрээр нийгмийн ажилтан буюу баг, хороо, сум, дүүрэгт бол энэ хамтарсан багууд, мөн хууль зүйн хороо ингээд ажилладаг болсон. Энэ хүрээндээ гэр бүлийн орчинд өсөж байгаа гэр бүлийн нөхцөл байдлыг бол хамтарсан багийн хүрээнд энэ асуудалдаа бол хяналтаа тавиад явах юм. Тэгэхээр хэрвээ энэ дээр эрсдэлт үнэлгээ, нөхцөл байдлын шинжилгээг нь хийгээд энэ гэр бүлд энэ хүүхэд өсөж бойжиход хүндрэлтэй байна гэж үзэх юм бол асран хамгаалах, харгалзан дэмжлэгийн асуудлыг шүүхэд тавиад .../минут дуусав/

Н.Учрал: Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Дахиад асууя. Хамтарсан багийн үйлчилгээ бол гэр бүлийн хүүхэд хамгааллын асуудал дээр илүү ажиллаж байгаа. Тэгэхээр гэр бүлийн шүүх болон шүүхийн хянан шийдвэрлэх энэ процесс дээр түрүүн Сайнзориг гишүүний хэлсэн шиг нийгмийн ажилтнууд, гэр бүлийн шинжээч шинжилгээ нөхцөл байдлын үнэлгээ дээр илүү тодорхой орж ирнэ гэсэн үг үү. Би яах вэ хуулиас нь харахгүй байгаа болохоор асууж байгаа шүү. Тэрийг тодруулмаар байна. Тэгээд эрүүл мэндийн дадал зуршил буюу хүчирхийлэл үйлдэгч гэж хэлдэг юм уу, нөгөө салсан буруутай этгээд гэдэг юм уу. Өөрөөр хэлбэл хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж байгаа эцэг юм уу, эх, эсвэл асран хамгаалагчийг салалтын дараа яаж харилцааг зохицуулах юм бэ. Уулз гээд л орхичих юм уу. Эсвэл тэр зан үйл засах сургалт энэ тэр чинь яаж үйлчлэх юм бэ. Тэрнийхээ дараа хүүхэдтэйгээ уулзуулах юм уу. Өмнө нь уулзуулах юм уу л гэж би асуугаад байгаа байхгүй юу. Засагдаж байж хүүхэд .../минут дуусав/

Н.Учрал: Ажлын хэсэг. 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Энэ түрүүний гэр бүлийн хууль дээр бас байгаа юм. Энэ нөгөө асран хамгаалах, харгалзан дэмжих асуудлыг өөрчлөхтэй холбоотой сум дүүрэг, баг хорооны Засаг даргын эрх хэмжээ дээр бол заагаад өгчихсөн юм. Гэр бүлийн тухай хуулийн 57.2 дээр. Энэ дээр нөхцөл байдлын хүсэлт гаргаад шинжилгээгээр бол асран хамгаалах, харгалзан дэмжлэгийн асуудал жишээ нь, ахмад настан бие даан амьдрах чадваргүй байдалтай байна энэ тэр гэх юм бол асран хамгаалах, харгалзан дэмжлэгийг нь өөрчлөх хүсэлтээ бол Засаг дарга шүүхэд нөхцөл байдлын шинжилгээ гаргаад, энийг нь асран хамгаалах, харгалзан дэмжлэгийг өөрчлүүлэх хүсэлт гаргаад шүүхээр шийдвэрлэх боломж бол бүрдэж байгаа.

Тэр хүүхэд уулзахтай холбоотой асуудалд бол гэр бүлийн дагнасан шүүхийн шүүгч шийдвэр гаргахдаа энэ гэр бүлийн нөхцөл байдлын шинжээчийн дүгнэлт тайлан дээр .../минут дуусав/

Н.Учрал: Саранчулуун гишүүн тодруулна.

О.Саранчулуун: Би тэгвэл бүр бататгаадахъя. Гэр бүлд байгаа бие даан амьдрах чадваргүй, хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх шинжээчийн дүгнэлтийг хэн гаргах вэ гэдгийг тодорхой хэлээд өгөөч.

2-т нь Засаг дарга тэр дүгнэлтээ гаргаж байж, Засаг дарга нар оролцож байж арга хэмжээ авна гэхээр энэ хэр процесс шаардах вэ.

Н.Учрал: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Н.Мягмар: Энэ анхан шатын нэгжүүд болох баг, хороо дээр байгаа нийгмийн ажилтан хамтарсан багийн хүрээндээ л энэ гэр бүлийн нөхцөл байдлыгаа судлаад баг, хорооны Засаг даргыг бид нар хуучин сум, дүүргийн Засаг дарга гэж байсан бол одоо баг, хорооны Засаг даргыг оруулж ирж байгаа. Тэгэхээр яг анхан шатны нэгж дээр гэр бүлтэйгээ ойрхон нөхцөл байдлаа мэддэг энэ баг хорооны Засаг дарга дээр энэ хүсэлтийг тавих боломжийг нээж өгч байгаа. Тэгэхээр энэ маань илүү анхан шат руугаа ойртож байгаа учраас энэ хүсэлт дүгнэлтүүд нь хурдан гарна гэсэн ийм ойлголтоор хуулийн төсөлд энийг өргөжүүлсэн байж байгаа.

Хугацааг тэр хамтарсан багийн нөхцөл байдлын шинжилгээнээсээ л хамаарна шүү дээ. Хэр олон нөхцөл байдлыг судлах юм. Гэр бүлийн орчны, гэр бүлийн орлогын асуудал гээд ингээд тийм учраас энэ анхан шатынхаа нэгж дээр байгаа энэ байгууллагууд дүгнэлтээ хурдан гаргана. Дунджаар бол .../минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 2 тодруулсан. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууна.

Х.Баасанжаргал: Манай ажлын хэсгийнхэн бас ойлгоорой. Бид нар хуулийн төсөл, үзэл баримтлалаа бүгдийг нь уншсан. Уншаагүй болоод асуугаад байгаа юм биш. Бид нарын энэ ярьж байгаа асуудал өөрөө өнөөдөр өдөр болгон, өдөр тутамдаа хүний амьдралд маш чухал асуудлын тухай бид нар хэлэлцэж байгаа. Тийм учраас хүн болгон энийг бас анхаарч сонсож байгаа олон хүмүүс байгаа. Юу өөрчлөгдөх гээд байгаа юм. Энэ хууль батлагдсанаараа миний амьдралд ямар өөрчлөлт гарах юм бэ. Ямар зүйлийг энэ парламент яриад байна вэ гээд бид нар энгийн иргэдэд бас ойлгомжтой байдлаар мэдээллийг бас хүргэх үүрэгтэй. Тэр утгаараа бас зарим зүйлүүдийг маш нарийн тодруулж асуугаад байгаа.

Тэгээд сая Саранчулуун гишүүний асуусан асуултыг би бүр тодруулаад асуучихъя. Яг энэ төрлийн хэрэг буюу энэ гэр бүлийн хэрэг маргааныг дунджаар анхан шатад хэд хоногийн дотор шийдэж байгаа юм. Энэ дагнасан шүүх байгуулагдсанаараа хэд хоног болж хугацаа нь багасах юм. Нөгөө чирэгдэлгүй байх тэр процесс хангагдаж чадах уу гэдэг ийм асуулт гэсэн үг. Тэгэхээр яг хоног хугацаатай, урьдчилсан байдлаар хийсэн судалгаа өөрөө яаж гарч байгаа вэ гэдэг ийм асуулт.

2 дугаар асуулт ганцхан энэ бол шүүхийн хийх ажил биш гэж би хувьдаа харж байгаа. Маш олон дэд бүтэц, маш олон бусад байгууллагууд уялдаатай ажиллах ёстой. Ажлын хэсэгт агентлаг байгаа юу. Гэр бүл, хүүхдийн агентлаг энэ ажлын хэсэгт байна уу. Хүн байна уу. Байхгүй байгаа байхгүй юу. Агентлаг энэ дотор чинь аягүй чухал үүрэгтэй байх ёстой шүү дээ. Яагаад агентлаг байхгүй байгаа юм. Тэгэхээр энэ чинь өөрөө бүх оролцогч талуудын уялдааг хангасан маш том тогтолцооны маш том өөрчлөлтийг бид нар хийх гээд сууж байгаа гэсэн үг. Тэгэхээр энд оролцох ёстой талууд бүгд өнөөдөр үүрэг, хариуцлагаа хүлээгээд байж байх ёстой. Байр сууриа илэрхийлж байх ёстой. Энэ тогтолцоог бид нар бүтнээр нь тогтолцоо гэж харах ёстой гэсэн үг.

Тэгэхээр энэ асуулттай холбоотой ямар асуулт урган гарч байна вэ гэвэл яг төсвийн асуудал яригдана. Шүүхийн төсвөөс гадна бусад нөгөө хүний нөөцийнх нь төсөв, хүний нөөц нь бэлэн үү. Удахгүй 1 сарын 1 боллоо. Ямар хэмжээний нөөц, төсөв хэрэгцээ шаардлага үүсгэх вэ. Одоо байгаа нөөц нь боломжтой юм уу, боломжгүй юм уу. Би санаж байна. Хавар бид нар төсөв батлахдаа шүүхийн төсвийг танаад л явуулсан. Хэзээ ч Байнгын хорооны баталсан хэмжээнд шүүхийн төсвийг баталдаггүй. Бямбацогт сайд бас энэ дээр амлалт өгөөсэй гэж хүсэж байна. Ер нь шүүх эрх мэдлийн байгууллагадаа иймэрхүү маягаар ханддагаа болих хэрэгтэй. Тэгээд одоо ингээд гоё үр дүн гаргах гээд байгаа юм шиг. Мөнгө нь байхгүй юм чинь яг үнэн хэрэгтэй үр дүн гарах юм уу. Би бол тэрэнд итгэхгүй байгаа. Тэгэхээр энэ дээр тодорхой хариулт авмаар байна.

3 дугаарт эвлэрүүлэн зуучлалын шүүгч гээд энэ нь өөрөө Үндсэн хуульд нийцэх үү. Энэ дээр бас манай шүүх ямар байр суурьтай байгаа юм бол. Шүүгчээ би бид нар дотор нь нөгөө дагнасан хэрэг маргаанаас нь гадна дахиад өөр нэг ангилал үүсэх гээд байна л даа. Эвлэрүүлэн зуучлалын шүүгч. Тэгэхээр энэ Үндсэн хуульд нийцэх үү.

Хамгийн сүүлийн асуулт. Шинжилгээ хийдэг болж байгаа. Нөхцөл байдлын үнэлгээ хийдэг болж байгаа. Тэгэхээр эдгээрт Шүүхийн шинжилгээний тухай хууль хамаарахгүй. Нөгөө талаар бас гомдол гаргах эрхгүй гээд шинжээчийн үнэлгээний тайланд гомдол гаргах эрхгүй. Шинжээчийн үнэлгээний тайлан нотлох баримт бөгөөд шүүх нотлох баримтаар үнэлэх эсэхийг шийдвэрлэж, хэргийг хянан шийдвэрлэхдээ харгалзан үзнэ гээд биччихсэн байгаа юм. Тэгэхээр яг энэ нотлох баримтаар үнэлнэ гэсэн асуудалдаа дахиад өмгөөлөгч нар энэ дээр гомдол гаргах эрхгүй болохоор яах вэ. Тэгэхээр нөгөө хүний гомдол гаргах эрхийн асуудлыг бид нар жоохон хязгаарлаад байна уу. Эсвэл нөгөө шинжээчээс юугаараа ялгаатай юм гэдгийг бас нэлээн ойлгомжтой дэлгэрэнгүй бас тайлбарлаж өгөөч ээ гэсэн ийм асуулт байна.

Н.Учрал: Бямбацогт гишүүн хариулна.

С.Бямбацогт: Тэр шүүхийн зардалтай холбоотой яах вэ, Монголчууд бид нар бас жоохон өөдрөг харах хэрэгтэй байгаа юм. Ер нь Монголчууд бол бас өв соёл, зан заншил, уламжлалаараа бүгдээрээ л нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгийн төлөө хэдэн мянган жилийн түүхтэй, аав ээждээ хайртай, эмээ өвөөгөө хайрладаг, эргээд аав ээж нь төрүүлсэн үр хүүхдээ, ач зээ нараа хайрладаг энэ өв соёл, уламжлал маань одоо хүртэл алдагдаагүй. Гаднын улс орнууд, ялангуяа барууныхан тэгээд л хүүхдээ 18 нас хүрэхээр нь өөрөө амь амьдралаа тээгээд хол яв гэхихдэг. Тэгээд л хүүхэд нь 18 нас хүрээд гэрээсээ гараад л явдаг. Аав ээж нь тэтгэвэрт гарахаар нь асрамжийн газарт аваачаад өгчихдөг. Тэгээд үр хүүхэд нь эргэж тойрдоггүй. Үүнтэй харьцуулах юм бол Монголчууд бид их сайхан уламжлалтай. Тийм болохоор энэ өв соёл, уламжлал, зан заншлаа бас түгээж дэлгэрүүлэх, хойч үедээ үлдээх, нөгөө үхтэл үр харам гэж үр хүүхдийнхээ төлөө яаж зүтгэдэг билээ. Энийгээ бас ойлгуулахаас энэ гэр бүлийн үнэ цэн, гэр бүл бат бэх байх, үр хүүхэд маань бас аав ээждээ хайртай, эргээд үр хүүхдээ хайрладаг болох энэ сайхан уламжлал тогтох байх. Ер нь бол хайран дундаас бас хайр төрдөг. Тэгээд үл ойлголцол дундаас үзэн ядалт, тэгээд гэр бүл салалт үүсдэг. Энэ тал дээр бид илүү бас соён гэгээрүүлэх ажлыг хийж хэрэгжүүлэх ёстой байх. Энэ тал дээр бас таны ярьж байгаа байгууллагуудыг ажиллуулах, тодорхой төсөв зардлаа шийдэх тал дээр бас анхаарна гэдгийг хэлье.

Шүүхтэй холбоотойгоор Шүүхийн багц хуулийг бид нар батлахдаа шүүхийн хараат бус ажиллах нөхцөлийг бий болгоё. Шүүхийн бие даасан үйл ажиллагаа явуулах нөхцөлийг. Шүүгч нарын хараат бус ажиллах нөхцөлийг бий болгоё. Энэ үндсэндээ нэг талаасаа гол нь нөгөө санхүү, төсөв, зардалтай холбоотой. Тэгээд шүүхийн төсвийг шүүгч нарын цалингийн асуудлыг Засгийн газраар дамжуулаад, Сангийн ямаар дамжуулаад, Улсын Их Хуралд өргөн барьдаг. Тэгээд Сангийн яаман дээр, Засгийн газар дээр танадаг, хасдаг. Үүнээсээ болоод нөгөө шүүгч хараат бус ажиллах бололцоо боломж нь хаагддаг, хязгаарлагддаг. Шүүхийн байгууллага маань бие даасан үйл ажиллагаа явуулах бас бололцоо боломж нь хаагддаг. Үүнийг зогсоосон. Өнөөдөр одоо бол энэ шүүхийн шинэчилсэн хуулиар шүүхийн байгууллага, Шүүхийн ерөнхий зөвлөл төсвөө шууд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлж, батлуулдаг болсон. Хүргүүлж батлуулдаг. Өөрөөр хэлэх юм бол дунд талд нь Сангийн яам, Засгийн газар гээд юу гэдэг юм дахиад бас гүйцэтгэх засаглал шүүх эрх мэдэлд нөлөөлөх гээд байх нөлөөллөөс нь ингэж ангид болгож өгсөн. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн ач холбогдол бол энэ шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн, төрийн хяналт шалгалт, аудит бас ийм хараат бус ажиллах нөхцөлийг бий болгосон. Энэ хүрээндээ үндсэндээ шүүх бие даасан.../минут дуусав/

Н.Учрал: Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна. Хэн хариулах юм. Ажлын хэсэг үү. Ажлын хэсгээс хариулна.

П.Золзаяа: Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ямар хугацаанд явагдах вэ гэхээр энэ хуульд бол нэлээд олон ажиллагаа Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу явагдахаар байгаа. Тийм учраас энд бол тусгайлан хугацаа тогтоогоогүй. Хамгийн доод боломжит хугацаа бол Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаа юм байна гэж үзсэн. Тэгэхээр энэ хугацаа бол адилхан байгаа.

2 дугаарт эвлэрүүлэн зуучлалын шүүгч гэсэн нэр томьёог энэ хуулийн төсөл дээр хэрэглэчихсэн байгаа. Энэ дээр бид нар бас ажлын хэсэг гэдэг дээрээ ярилцаад, агуулгын хувьд, найруулгын хувьд зөв илэрхийлэх нь үү, үгүй юу гэдэг дээр бас дахиж ярилцах байх. Энэ бол гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгчийн идэвхтэй үйл ажиллагаа хамгийн их хэрэгтэй байгаа. Тэгэхээр энийг өмнөх хуулиас илүү шүүгчийн үйл ажиллагааг тодорхой, тэгээд идэвхтэй байх зарчмын үүднээс ингэж хэд хэдэн ажиллагаанд энэ шүүгч санаачилгаараа хийх ажиллагааг ингэж хуульд заасан. Тэгээд үүний нэг нь .../минут дуусав/

Н.Учрал: Нэмэлт 1 минут.

П.Золзаяа: Үүний нэг нь бол эвлэрүүлэн зуучлах боломжтой тийм гэр бүл дээр шаардлагатай бол тэр хэргийг шийдвэрлэж байгаа биш, тухайн шүүхэд ажиллаж байгаа гэр бүлийн 1 шүүгч нь удирдаад, энэ эвлэрүүлэн зуучлалын багаа удирдаад ажиллагаа явуулахад оролцох шүүгчээ ингээд нэрлэчихсэн юм байна лээ. Тэгэхээр энийг бол ажлын хэсэг дээр нэр томьёоны хувьд бас эргэж харъя гэсэн ийм зүйл байна.

Мөн энэ хуульд шинээр шинжээч орж ирж байгаа. Энэ шинжээч нь шүүхийн ажилтан байна гэж байгаа. Тэгээд гэр бүлийн нөхцөл байдлыг судлаад, нэлээн хэдэн зүйлээр дүгнэлт гаргахаар байгаа. Энэ бол өөрөө ер нь бол нотлох баримт

болно. Тэгэхдээ мэдээж нотлох баримт дээр гомдол гаргана гэж бол байхгүй шүү дээ. Тийм ээ. Тэгэхээр энэ нөхцөл байдлыг өөрчлөх зүйл байгаа бол тэр баримтыг гаргах замаар шинжээчийн тайланг үгүйсгэх юу байна. Энэ замаар бол гаргах эрх нь бол нээлттэй байгаа гэсэн үг.

Н.Учрал: Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: Сая Бямбацогт гишүүнд 1 юмыг бас хэлэх нь зөв байх. Таны яг хэлж байгаачлан Шүүхийн тухай хууль Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр холбогдох хуулиуд батлагдсан боловч харамсалтай нь биелээгүй. Сая 2 удаа бид нар 2 гэж бараг 4, 5 удаа төсөв баталчхав уу. Бүгдэд нь дандаа шүүхийн төсвийг Хууль зүйн байнгын хорооны баталснаас даруй 40, 30, 50 хувиар бууруулж баталсан. Та тэр тоонуудыг авч танилцаарай. Тэгэхээр ерөөсөө нөгөө Хууль зүйн байнгын хороо дунд нь орж батлах ямар ч ач холбогдолгүй болсон. Тэгэхээр энийг бид нар эргэж хараад, гол нь баталсан хуулиа л биелүүлэх асуудал. Тэгэхээр дахиж ийм асуудал гарахгүй байх гэж найдаж байна. Тэгэхээр нөгөө шүүхийн холбогдох төсвийн асуудал шийдэгдэхгүй бол бид нар мянга сайхан ийм тусдаа тогтолцоо байгуулаад энэ маань өөрөө бодит биеллээ л олохгүй гээд байгаа гэсэн үг. Нөгөө талаар энэ бусад оролцогч талууд дээр тодорхой хариулт өгөөч. Яагаад ажлын хэсэгт агентлаг, яам ороогүй юм гэдэг дээр. Сайд нь бас байх шиг байна.

Н.Учрал: Бямбацогт гишүүн хариулъя.

С.Бямбацогт: Тэгэхээр бидний баталсан хуулиар үндсэндээ Засгийн газрыг оролцуулахгүй гэж тийм үү, тэгээд Хууль зүйн байнгын хорооны баталсан төсвийг Сангийн яам, Засгийн газар төсөвтэй нэгтгээд явах ийм хуультай. Энэ хуулийг хэрэгжүүлэх үүрэг нь Засгийн газарт байгаа. Хууль биелүүлэх үүрэг бол Засгийн газарт ноогддог. Хууль биелүүлэх үүрэг. Гэхдээ Хууль зүйн байнгын хороо дээр бас бүх л байгууллагуудад, бүхий л төсвийн ерөнхий захирагч нарт төсөв хэрэгтэй. Бүгд төсвөө нэмүүлэхийг хүсдэг. Байнгын хорооны гишүүд нь бас илүү хариуцлагатай, илүү зарчимтай хандаад улс орныхоо эдийн засаг, нийгмийн байдал, төсөв санхүүгийнхээ байдлыг бас хүндрэлтэй байдлаа харгалзаад маш зөв тооцоо судалгаа хийхгүй бол тэгээд үндэслэлгүй ороод ирэхээр яалт ч үгүй төсөв, санхүүдээ захирагдаад хасах ийм шаардлага үүсдэг байх. Энэ дээр бол 2 талаасаа нэлээн сайн ярилцаад, ойлголцоод хуулиа нэг талаасаа биелүүлдэг байх, нөгөө талаасаа бас зарчимтай, хариуцлагатай, ажил хэрэгч ханддаг байх. Тэгэхгүй бие биедээ найр тавьдаг, тал засдаг ийм/минут дуусав/

Н.Учрал: Тодруулах хугацаа дууссан. Одонтуяа гишүүн. Аубакир гишүүн хариулъя. Үгүй ээ, та нар тэгээд тодорхой хариул л даа. Энэ өглөөнөөс хойш элсэлтийн шалгалтын юм шиг баахан танин мэдэхүйн юм яриад байх юм. Гол асуултдаа хариул л даа. Хэн хариулах юм. Тэдэн онд тэгсэн, эдэн онд ингэсэн, ер нь ийм байдаг гээд тойроод яриад байх юм. Хариул л даа энэ асуултдаа. 4.

Н.Мягмар: Гэр бүлийн хуулийн шинэчилсэн найруулга болон Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиуд дээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, түүний харьяа агентлаг байгууллага ажлын хэсэгт орж ажилласан. Гэр бүлийн хууль дээр түрүүн яамны төлөөлөл нь ажиллаж байгаа. Одоо яг энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны Улсын Их Хурал дээр орж ирсэн ажлын хэсэгт л орж ирээгүй болохоос биш энэ хуулийн төсөл дээр саналаа өгөөд, Засгийн газрын гишүүн, сайд нь саналаа өгөөд, агентлагуудаас нь саналаа аваад, энэ бусад

байгууллагууд Хүний эрхийн Үндэсний Комисс энэ тэрээс саналаа аваад ингээд л орж ирж байгаа. Мөн Их D-Parliament сайт дээр бас энэ санал нь аваад л явж байгаа. Тийм учраас энд агентлаг нь гэдэг юм уу, мэргэшсэн байгууллага нь ороогүй гэж үзэх бололцоо байхгүй. Энэ дээр албан ёсоор ажлын хэсэгт нь ороод ажилласан байгаа гэдгийг хэлье.

Н.Учрал: Бямбацогт гишүүн хариулах юм уу. Та нар чинь агентлагийн дарга яагаад суугаагүй вэ гэдгийг 4 талаас 4 өөр юм ярих юм. Одонтуяа гишүүн асуулт асууя.

С.Одонтуяа: Тэгэхээр өнөөдөр Монгол Улсад энэ шүүхээр асуудлаа шийдүүлэх гэдэг бол үнэхээр тамын ажил болж хувирсан. Монгол хүнийг үнэхээр хашраая, махалъя, зовооё гэвэл шүүхээр л явж байгаа. Энэ тэтгэмжийнхээ араас яагаад зарим хүмүүс явж байгаад больчихдог вэ гэхээр энэ мөнгөнд дургүйдээ биш, зүгээр үнэхээр тэр явдал суудал, тэр хүнд суртал, хүнлэг биш харьцаа энэ бүх зүйлээс халгаад, тэр тэтгэмжийнхээ араас явдаггүй. Шүүхийн шийдвэр гарсан ч гэсэн түрүүн бид нар зөндөө ярилаа. Биелэлт нь байхгүй. Өнөөдөр 10 хэдэн хувийн биелэлттэй л байна гэж байна. Тэгэхээр энийг үндсээр нь бид нар өөрчлөх ёстой. Тэгээд өмнө нь бол бид нар чинь 3 процессын хуультай байсан шүү дээ. Иргэний хэрэг, эрүүгийн хэрэг, захиргааны хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх тухай гээд. Тэгэхээр одоо энэ гэр бүлийн асуудлыг нэмчихээр бүр хүндрээд дордчих юм биш байгаа даа. Ер нь зарим хуулийнхаа өмгөөлөгч нар шинэ салбар болгонд гарч ирээд байвал хэцүү л гэж ярьж байгаа. Тэгэхээр би бол яах вэ, гэр бүлийн хэрэг дээр бол энэ тусдаа байх нь зөв гэж үзэж байгаа. Ер нь цаашдаа ингэж их олон зүйл дээр тус тусад нь ийм процессын хууль гаргаад байх нь бол хэцүү байх.

2 тодорхой зүйл асууя.

1 дүгээрт энэ гэрлэлт цуцлах маргаан дээр гэр бүл дотор хамаг асуудлаа ингээд хүмүүс ил болгодог. Гэр бүлийн нууц байна. Хувийн мэдээллээ цагдаа, мөрдөн байцаагч, шүүхийн өмнө ингээд ил болгодог. Тэгэхээр энэ бүх зүйлийг, мэдээллийг хамгаалах ямар бодлого зохицуулалт тусгасан бэ. Энэ хувь хүний мэдээллийг хамгаалах асуудлууд энд туссан уу. Тийм тохиолдлууд гарсан шүү дээ. Хүн ингээд хамаг нандин зүйлээ ярьдаг. Тэрийг нь ерөөсөө шууд зургийг нь дараад л сошиал дээр тавьчихдаг. Үүнээс болж тэр айлын хүүхдүүд гадаадад гарах тохиолдол ч байна. Ингээд бүр хүндрэлтэй асуудлууд үүсчхээд байгаа юм. Энэ асуудлыг асууя.

2 дугаарт түрүүн бас гишүүд судалгаагаар хэлээд байна шүү дээ. Энэ эвлэрүүлэх асуудлыг 90 хувь нь бараг шийдэгддэггүй юм гэж. Тэгэхээр үнэхээр ийм нийгэмд газар дээрээ буухгүй энэ асуудал нь шийдэгдэхгүй, хий дэмий цаг үрж, тэрнээс болж өчнөөн хохирол гараад байгаа бол энийгээ заавал гэдгийг нь больчихож болно шүү дээ. Яагаад гэхээр эвлэрүүлэн зуучлах юмыг л ороогүй бол шүүх авахгүй байгаа. Тэгэхээр энэ хооронд чинь тэр зарим хүмүүс өмчөө зараад, ийш тийш нь ингээд хөдөлгөчхөж байгаа. Энэ хооронд тэгээд л нөгөө хүүхдүүд, үлдсэн хүмүүс нь өмчгүй үлдчихэж байгаа. Хүн амины хэрэг хүртэл гарч байсан. Тэгэхээр энэ асуудлыг бид нар бас сайн авч үзэх ёстой.

Түрүүн бас гишүүд хэллээ. Хаяг тодорхойгүй гэдгээр яваад байдаг гэж. Тэгэхээр Австрийн нэг туршлага байдаг юм байна. Австрид залуучуудын байгууллага нь яг энэ хүмүүсийн хаягийг тодорхойлж өгдөг. Төр бол амжихгүй

учраас энэ төрийн бус байгууллага ийм зүйлүүдээр бас гэрээгээр гүйцэтгүүлдэг. Эд нар ерөөсөө дор нь олоод ирдэг юм байна. Энэ хүн ийм хаяг дээр, ийм цалинтай ажил хийж байна гээд ингээд дор нь олоод ирдэг. Тэгэхээр ер нь гаднын энэ туршлага судалсан юм уу. Ер нь яг энэ хууль дээр ямар, ямар орны туршлагыг судалсан юм бэ гэдгийг асуумаар байна.

Дээрээс нь тэтгэмжийг нөхөн олгох талаар ер нь шинэ заалтууд орсон уу. Хүн ингээд өөрийнх нь буруугаас шалтгаалахгүйгээр энэ тэтгэмжийг авч чадахгүй хүүхэд нь насанд хүрчихдэг. Гэтэл тэр ээж бол насаараа л тэр өөрийнхөө хамаг юмыг л хугаслаад ингээд ажилласан байгаа шүү дээ. Тэгэхээр энэ нөхөн олговрын асуудал бол ер нь тусгагдаж байгаа юу гэдгийг асууя.

Н.Учрал: Ажлын хэсэг хариулъя. Мягмар дарга хариулъя.

Н.Мягмар: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэл тэтгэлэг төлөгдөхгүй байгаатай холбоотойгоор тусдаа энэ шүүх гарснаараа ачаалал үүсгээд, шүүхийн шийдвэр гүйцэтгэх асуудал улам хүндрэх вий гэж. Энэ одоо байгаа хуулиараа ч гэсэн яах вэ гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх хүүхдийн тэтгэлгийн асуудлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэлээр шийдвэрлээд явж байгаа учраас энэ ажил явдгаараа явж байгаа. Харин энэ тэтгэлэг төлөлтийн асуудлыг яаж үр дүнтэй болгох вэ гэдэг асуудал дээр түрүүний хэлсэн шийдвэр гүйцэтгэлийн багц хуулийнхаа хүрээнд тэтгэлэг төлөх, тэрний төлөлтийг сайжруулах чиглэл рүүгээ хөшүүргүүд орж ирсэн гэдгийг хэлье.

Эвлэрүүлэх амжилтгүй болоод байхад заавал ингээд хугацаа өгөөд шүүх дээр ингэж хэлэлцэхгүй байх энэ асуудлуудыг хөндөж байна. Энэ шинэчилсэн найруулгын маань 1 зүйл бол мөн энэ эвлэрүүлэх шаардлагагүй, тусдаа амьдарчихсан, харилцан гэр бүлээ цуцлахыг тохирчихсон ийм тохиолдолд бол хүүхдийн эрх ашгийг хамгаалах хүрээндээ бол шүүх энэ асуудал дээр нөхцөл байдлын шинжилгээ хийгээд, заавал эвлэрүүлэн зуучилга хийхгүйгээр шүүхийн өмнөх шатад эвлэрүүлэн зуучлагч биш, шүүх дээрээ энэ гэр бүл цуцлалтын асуудлыг шийдээд ингээд явах зохицуулалтуудыг гэр бүлийн болон процессын хууль дээр оруулж ирсэн байж байгаа.

Хаяг тодорхойгүй асуудал үнэхээр хүндрэлтэй байгаа. Практик дээр байж байгаа. Энэ дээр бол Монголчуудын маань ихэнх нь хаяг дээрээ оршин суудаггүй. Үүнээс болоод эрэн сурвалжлах ажиллагаа маань саатдаг ийм асуудлууд байгаа. Энэ хаягжилтын асуудал энэ тэр дээр бол цахим яам болоод хаягийн асуудал хариуцсан энэ байгууллагууд, энэ хаягжилтыг сайжруулах энэ чиглэл дээр явж байгаа. Бид нарын дараагийн нэг боловсруулах гэж байгаа хуулийн төсөл дээр бол энэ нэхэмжлэлийг гардуулсан тооцох асуудлыг бид нар Хууль зүй, дотоод хэргийн яам дээрээ нөгөө иргэний И-Монголиа дээр байгаа бүртгэгдсэн төрийн мэдээллийн и-мэйл хаягаар энэ шүүхийн нэхэмжлэлийг гардуулах энэ ажиллагааг хийх асуудлыг ажлын хэсэг Хууль зүй, дотоод хэргийн яам дээрээ бол судалж байгаа. Энэ хүрээндээ заавал хаяг гэхгүйгээр нэхэмжлэлийг гардуулсанд тооцох тэр судалгааг хийж байгаа. Юун дээр бол гардуулчихсан тохиолдолд шүүх дээр хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирэхгүй байгаа тохиолдол дээр бол харин энэ процессын хууль дээр шууд шүүх хуралдааныг хариуцагчийн эзгүйд энэ гэр бүлийн дагнасан шүүх бол хэрэгжүүлээд явах энэ зохицуулалтыг энэ хууль дээр оруулж ирсэн байж байгаа.

Н.Учрал: Одонтуяа гишүүн тодруулна.

С.Одонтуяа: Тэгэхээр Аубакир сайд аа, танд хандаж нэг зүйл хэлэх гэсэн юм. Гэр бүлийн хөгжлийн хууль гэж өргөн барихаар бэлтгэж байгаа гэж сонссон. Энэ хуулиа та хурдан өргөн барих боломж байна уу. Яагаад гэхээр сая ингээд маш олон асуултад асуухаар энэ гэр бүлийн хөгжлийн хуулиар тусгачихсан байгаа, тэнд тусгачихсан байгаа гээд байгаа байхгүй юу. Ялангуяа Гэр бүлийн дэмжлэгийн асуудлууд байна. Халамжийн асуудлууд гээд. Тэгэхээр энэ юмыг оруулж ирсэн хойно цогцоор нь бас ярих шаардлагатай байгаа юм.

Учрал дарга аа, нэг ийм бас хүсэлт байгаа. Сая Алтангэрэл сайд Засгийн газраас шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хуулийг өргөн барьсан юм. Тэгэхээр энэ Их Хурал дээр байгаа. Энийг та хурдан даргын зөвлөл дээрээ яриад, Учрал дарга аа, даргын зөвлөлөөрөө шийдээд энэ хуулийг хурдан оруулаад ирэхгүй юу. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль. Энэ дээр яг нөгөө хүмүүсийн тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг маш сайн тусгачихсан байгаа. Тэгэхээр бид нар энийг цогцоор нь .../минут дуусав/

Н.Учрал: Шүүхийн шийдвэрийн хуулийг чинь Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хууль санаачлагч нь татна гэсэн сүүлд мэдээлэл өгсөн шүү. Тэрийг Засгийн газартай ярьж, тодорхой мэдээлэл авах хэрэгтэй. Би бол тийм ойлголттой байгаа шүү дээ. Тэгээд Хууль зүйн яам юу гэж үзэж байгаа юм. Шүүхийн шийдвэрийн хуулийг татна гэсэн би мэдээлэл авсан. Хууль зүйн яам ямар байр суурьтай байсан юм. Тэгээд эргээд хэлнэ биз. Аубакир сайд. Таны хуулийг хэлэлцээд байна.

Т.Аубакир: Энэ Засгийн газраас өргөн барьж байгаа Гэр бүлийн тухай хууль Хууль зүйн яамны бэлтгэснээр орж ирж байгаа. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр Гэр бүлийн хөгжлийн тухай хууль өнгөрсөн хоёр 7 хоногийн өмнө Засгийн газар дээр танилцуулагдаад явж байгаа. Одонтуяа гишүүн ээ. Энэ Гэр бүлийн хөгжлийн тухай хууль дээр хүүхдийн мөнгөн дэмжлэг, жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг, хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг, ихэр хүүхдийн мөнгөн дэмжлэг зэрэг дэмжлэг хэлбэртэй олгогддог төсөв дагасан зүйлүүдээ Гэр бүлийн хөгжлийн тухай хууль руугаа хийгээд, нөгөө Халамжийн тухай хуулиа үндсэндээ ер нь хүүхдийн мөнгө энэ тэр халамжийн зардалд ороод харагдаад, хэтэрхий данхайсан халамж харагдаад байгаа юм.

Гэтэл нөгөө талдаа халамж биш дэмжлэгийн зүйлүүд бас байдаг. Энийгээ Гэр бүлийн хөгжлийн тухай хууль дээр хийгээд Засгийн газраар хэлэлцүүлсэн. Өргөн барихад бэлэн болсон. Зарим зүйл, заалтууд дээр нь төсвийн үр дагавартай учраас түр жоохон хойшлуулах ийм шаардлага үүсчхээд байгаа юм. Ирэх жилийн улсын төсөвтэй холбоотой маш олон яг гэр бүлийнхээ хөгжил рүү чиглэсэн заалтууд шингэсэн ийм .../минут дуусав/

Н.Учрал: Аубакир сайд дахиж 1 минут тодруулах уу. 1 минут өгье.

Т.Аубакир: Тийм учраас энэ төсөв санхүүгийн асуудлыг бид нар Засгийн газар дээрээ үндсэндээ хэлэлцээд шийдчих юм бол тун удахгүй энэ Гэр бүлийн хөгжлийн тухай хууль өмнө Энх-Амгалан сайд байх үед нэлээн чамбайруулаад бэлтгэчихсэн ийм хуулиуд бий. 5 хууль бий. Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой гэх зэрэг 5 чанартай хуулиуд бий. Яг энэ

Гэр бүлийн хөгжлийн тухай хууль маань жоохон төсвийн эффекттэй байгаа учраас жоохон хугацааны хувьд хойшлуулах ийм зүйл болж байгаа.

Н.Учрал: Одонтуяа гишүүн тодруулах уу. Болсон уу. Одонтуяа гишүүн нэмэлт 1 минут.

С.Одонтуяа: Баярлалаа. 2 удаа тодруулах боломж олголоо. Тэгэхээр Бямбацогт сайд аа, энэ Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль гээд Алтангэрэл сайд байхдаа өргөн бариад, энэ маш сайн хууль байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг би сая Их Хурлын даргад хурдан оруулж ирээд хэлэлцье. Хамт хэлэлцье гэхээр яам нь буцаад татаж магадгүй гэсэн юм яриад. Тэгэхээр энийг та Хэрэг эрхлэх газрын дарга, сайдын хувьд энэ хуулийг хурдан аль болохоор өргөн барьж, энэ хуультай цогцоор нь хэлэлцэхгүй бол болохгүй байгаа юм. Тэгэхээр яг юм асуухаар л тэр хуульд тусгачихсан, энэ хуульд тусгачихсан гээд. Тэгэхээр энэ Гэр бүлийн хууль чинь өөрөө энэ шүүхийн шийдвэрийн хууль чинь ерөөсөө амилахгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг хамт хэлэлцэх шаардлагатай байна.

Н.Учрал: Тэгээд Бямбацогт дарга хариулъя.

С.Бямбацогт: Ойлголоо. Тэгээд Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн шүүх байгуулах тухай хууль, энэ бүх хуулиуд бол Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд боловсруулагдсан. Өнөөдөр бас Хууль зүй, дотоод хэргийн сайд маань гадаадад томилолттой байгаа учраас би бас орлоод хариулж байгаа. Тэгээд саяын таны хэлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт гэж би ойлгож байна. Энийг яаралтай хууль санаачлагч хэдийд ч нөгөө хуулийн төслөө татан авах эрхтэй. Энэ хүрээндээ татаж авъя гэж Энхбаяр сайд бас хэлсэн байх. Тэгэхээр яаралтай буцааж, Засгийн газраас хурдан өргөн бариулах тал дээр Мягмар дарга бид нар анхаараад ажиллачихъя. Тэгээд ойрын хугацаанд намрын чуулган завсарлахаас өмнө өргөн бариад, тэгээд энэ хуулиа хэлэлцэхдээ хамтад хэлэлцээд явах боломжтой гэж харж байгаа. Манай ажлын хэсэг энийг бас анхааралдаа авчхаарай.

Н.Учрал: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хууль, тогтоолын төслүүдийн талаарх Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс ирсэн нэрс байна. Дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Бямбацогт дарга дахиад үг хэлэх юм. Та ер нь дэмжиж үг хэлээд байна уу, дэмжихгүй үг хэлээд байна уу. Баасанжаргал гишүүн үг хэлэх юм уу. Баасанжаргал гишүүн индрээс 1 номер. Бямбацогт дарга та ер нь 2 дээр зогсож байх уу.

Х.Баасанжаргал: Хуулийн төслийг дэмжиж үг хэлнэ. Тэгэхдээ хэд хэдэн өөрчлөлтийг хүлээж байгаа гэдгийг хууль санаачлагч болоод, мөн яамд, шүүх эрх мэдлийн байгууллагаас хүсэж байгаа үр дүнгүүдээ би энэ удаа тодорхойлж хэлье гэж бодож байна.

Гэр бүлийн тухай хууль бол зөвхөн гэр бүл цуцлах харилцааг зохицуулдаг хууль биш. Гэр бүлийн бүртгэлийн харилцааг, гэр бүл урт удаан хугацаанд тогтвортой байх харилцааг, аливаа бодлого, шийдвэр гаргахдаа томчууд ямагт хүүхдийн дээд ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргадаг байх энэ харилцааг

зохицуулах ийм зорилготой хууль байгаа. Яах вэ, бид нар өнөөдөр энэ танхимд голдуу дандаа гэр бүл цуцлахтай холбоотой гардаг, үүсдэг үр дагавар, асуудлуудыг ихэвчлэн ярилаа. Гэхдээ энэ хууль бол зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй гэдгийг юуны өмнө тэмдэглэж хэлэх ёстой байх.

Дараах хэдэн өөрчлөлтийн төлөө энэ хуулийг бол батлах ёстой гэж хүлээж байгаа.

1 дүгээрт, ямар ч үед хэн ч гэсэн шийдвэр гаргахдаа хүүхдэд хамгийн аюулгүй, хамгийн ээлтэй шийдвэр гаргадаг байхын төлөө энэ хууль байх ёстой.

2 дугаарт, хүүхдийн оролцооны эрхийг зөвхөн 7-оос дээш насны хүүхдийн байр суурийг сонсох төдий биш, хүүхэд өөрөө сонсогддог байх эрхийн төлөө энэ хууль батлагдах ёстой. Өөрөөр хэлбэл хүүхдийн шийдвэр аливаа шийдвэрт өөрөө бодитой жинхэнээсээ нөлөөлдөг байх ийм хууль байх ёстой.

3 дугаарт хүүхдийн асран хамгааллыг шийдэхдээ хүүхдийн байнга оршин байх газрыг зөвхөн тодорхойлох зорилгоор биш, хүүхдэдээ эцэг эхээс гадна өвөө эмээ зэрэг хууль ёсны төрөл төрөгсөд, хамаатан саднууд нь тодорхой хэмжээгээр уулзах боломжтой байх, шүүхийн шийдвэр энэ талаар тодорхой тусдаг байхын төлөө энэ хуулийн өөрчлөлт явах ёстой.

4 дүгээрт хөгжлийн бэрхшээлтэй хүний гэр бүл болох, хүүхэдтэй болох, хүүхэд үрчилж авах зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүн өнөөдөр гэр бүлийн харилцаанд ороход маш их хязгаарлалтад ордог. Энэ хязгаарлалтууд арилахын төлөө энэ хууль батлагдах ёстой.

5 дугаарт Монгол Улс өөрийн гэсэн уламжлал, ахуй соёл, онцлогтой. Энэ онцлогийг онцгойлон анхаарч дотуур байрны хүүхдийн асран хамгааллын асуудлыг бид нар шинээр загварчилж харах ёстой. Энэ бол зөвхөн гэр бүлийн харилцаа юм. Дотуур байрны хүүхэд энэ хуульд хамаарахгүй. Энэ асуудал Боловсролын яамны асуудлаа гэж бид нар орхигдуулж болохгүй. Хүүхэд тэнд 24 цаг амьдарч байгаа гэдгийг бид нар ямагт санах ёстой.

6 дугаарт хүүхэд байхдаа алдсан алдаа нь насан туршийнх нь амьдралын чанарт сөргөөр нөлөөлдөггүй байх ёстой. Энэ удаагийн шүүх энэ дагнасан шүүх байгуулагдсанаараа бид нар ганцхан гэр бүлийн асуудал биш, хүүхдийн маргааныг хүүхэд хэрвээ аливаа гэмт хэрэгт холбогдох юм бол тэр асуудлыг нь бид нар шийддэг болж байгаа ийм тогтолцооны шинэ өөрчлөлтийг хийж байгаа. Бямбацогт сайд аа анхаарна уу. Тэгэхээр энэ бүх өөрчлөлтийн төлөө энэ хууль өөрөө үйлчлээсэй гэж бодож байгаа. Энэ өөрчлөлтийн төлөө байгаасай гэж бодож байгаа.

Хамгийн сүүлийн 2 гол үр дүн юу вэ гэвэл хүчирхийллийн тойргоос шүүхийн болоод нийгмийн ажилтнуудын тусламжтайгаар гарч чаддаг байх энэ тогтолцооны өөрчлөлтийн төлөө энэ хууль байх ёстой. Хүүхэд гэдгээс шалтгаалж, тэднийг шударга бус байдалтай нүүр тулахаас сэргийлэх нь хуулийн хамгийн гол амин сүнс гэдгийг ухамсарлаж, хуульч нар бүгдээрээ үүнийг чин сэтгэлээсээ ойлгож, энэ шүүхийг энэ тогтолцооны өөрчлөлтийг чин сэтгэлээсээ өөрөөр загварчилж хараасай. Бид нарын ойлгодог уламжлалт шүүх энэ бол биш. Энэ бол цоо шинэ механизм, цоо шинэ хүүхдийн төлөө байгуулж байгаа шинэ тогтолцоо гэдгийг томчууд бид анхаараасай гэж хүсэж байна.

Ингээд эцэст нь хэлэхэд энэ бүх мөрөөдөл гэх юм уу, энэ бүх үр дүн шүүхийн бие даасан төсөвгүйгээр бодит биеллээ олохгүй. Манай Хууль зүйн байнгын хороо хариуцлагатай ажилладаг гэдгийг Бямбацогт сайдад бас бид нар хэлье. Бид нар хариуцлагатай төсвийг нь батлаад явуулдаг. Харамсалтай нь Сангийн яам ямар ч үндэслэлгүй төсвийг нь бууруулаад ирдэг. Үндэслэлээ зөвхөн бүх төрийн байгууллага төсвөө тануулж байгаа учраас шүүх ч гэсэн адилхан гэдэг байдлаар ханддаг. Шүүх бол адилхан байгууллага биш. Шүүх бол Үндсэн хуулиар олгосон нэг эрх мэдлийн байгууллага юм гэж үгээ өндөрлөө.

Тэгээд дахиж бид нар энэ шүүхийн төсвийн тухай ярихгүй байх гэж найдаж байна. Итгэж байна.

Н.Учрал: Урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд үг хэлж дууслаа.

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, түүнийг дагуулж хамт өргөн мэдүүлсэн нийт бараг 13 хууль. Мөн Их Хурлын тогтоолын төсөл байгаа. Гэр бүлийн хууль, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдээр чуулганы хуралдааны дэгийн хуульд заасны дагуу санал хураалтыг өглөө л явуулъя даа. Түүнээс одоо явуулаад ингээд Гэр бүлийн хуулийг дэмжихгүй гэж олон эрчүүдийн нүүрийг улалзуулаад яах вэ гээд чуулганаа хаая.

Өглөө 10 цагт Гэр бүлийн хууль, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хууль, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд дээр санал хураана. Малын индексжүүлсэн даатгал зарчмын зөрөөтэй 6 санал. Тэгээд тогтоолд нэмэлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ.

Ингээд өнөөдрийн чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулган өндөрлөснийг мэдэгдье.

17.40 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ